5. Шинэ үндсэн хуулийг санал нэгтэй баталсан нь манай орны амьдралын улс төрийн томоохон үйл явдал мөн.—**Единодушное принятие новой Конституции) — то обстоятельство, что единодушно приняли новую Конституцию) — крупнейшее событие в жизни нашей страны.**

При переводе на монгольский язык русских процессных существительных следует учитывать **время, в котором происходит действие** (настоящее, будущее или прошедшее), так как от этого зависит выбор того или иного монгольского причастия. Например:

... ирэх нь ... — **приезд (то обстоятельство, что придет**
... ирдэг нь ... — **приезд (то обстоятельство, что**

(обычно) приезжает) . . .

... ирж байгаа нь ... — **приезд (то обстоятельство, что**
(сейчас) (приезжает) . . .

... ирсэн нь . . . — **приезд (то обстоятельство, что при-**
ехал) . . .

Сравните: Речь { хэлэх үг
хэлсэн үг

Примечание. Когда субстантивированное будущее причастие обозначает деятеля, оно не обязательно требует после себя частицы личного притяжания. Например:

1. Ерөнхийлөгчийн туслах сурвалжлагчтай ярих. — **Помощник президента дал интервью корреспонденту.**

2. Мөн төлөөлөгчдийг . . . элчин сайдын яамны зөвлөх
нар үдэлцэв. — Делегацию также провожали со-
ветник посольства . . . и другие

Причастие в роли сказуемого

Причастие выполняет функцию сказуемого тогда, когда находится в конце предложения (со-еязками или предикативными частицами либо без таковых). Напримёр:

1. Би чамайг дурсан суух болноо. — Я буду вспоминать тебя.

2. Бид 7-р сарын нэгнээс амрах байсан. — Мы должны были уйти в отпуск с 1-ого июля.

3. Хоёр дүү нь үйлдвэрт ажилладаг ажээ. — Двое братьев работают на заводе.

4. Лав захидал ирсэн байгаа гэж бодож байсан юм.
— Думал: «Наверняка пришло письмо».

5. Хүний нутагт байхад эх орон ямагт бодогддог юм.
На чужой стороне всегда вспоминается родина.

6. Гурван жилийн дараа би энэ сургуулиа төгсөх юм.
Через три года я закончу этот институт.

7. Бид заримдаа утсаар ярьдаг. — Мы иногда говорим по телефону.

8. Өнөө өглөө тэд гэртээ байхгүй байсан. — Сегодня утром их не было дома.

9. Аав хөдөө ажлаар явж байгаа. — Отец (находится) в худоне в командировке.

Причастие в роли определения

Если причастие употребляется перед именем, то оно является определением к этому имени. Например:

1. Таны үлдээсэн бэлгийг аваад би их баярлав. — Я очень обрадовался, получив подарки, которые Вы оставили.

2. Энх тайвнаар зэрэгцэн орших бодлого улс түмний эрх ашигт бүрэн нийцнэ. — Политика мирного сосуществования полностью отвечает интересам народов.

Обстоятельно—дополнительная функция причастия

Причастия склоняются по всем падежам, а также употребляются с послелогоми. Причастие в форме косвенного падежа или с послелогом является в предложении либо обстоятельством, либо дополнением. Например:

1. Ажил тарсны дараа гэртээ ирээд чиний захидлыг дахин дахин уншиж сууна. — После работы пришёл домой и перечитываю твоё письмо снова и снова.

2. Тэнд мөхөөлдөс худалдаж байдгийг чи санаж байна уу?—Ты помнишь, что там продают мороженое?

3. Чиний ирэхийг хүлээн сууя! — Буду ждать твоего приезда!

4. Гэрээ байгуулах тухай ярив. — Говорили о заключении договора.

5. Намайг бага байхад бид тосгонд суудаг байлаа. — Когда я был маленьким, мы жили в деревне.

6. Орохдоо үнэмлэхээ үзүүл! — При (своем) входе предъявите (свой) пропуск!

7. Явахасаа өмнө утастаарай! — Позвони перед (своим) отъездом!

8. Зугаалахаар явъя! — Пойдем погуляем (гулять)!

9. Монгол хэл сурахаар Монголд явсан ажээ.—Уехал, оказывается, в Монголию, чтобы учить монгольский язык.

10. Бид энэ үзэсгэлэнг үзэхээр ирсэн — Мы приехали чтобы посмотреть эту выставку.

11. Зочид буудлаас гарахтай зэрэг ширүүн бороо оров. — Как только вышли из гостиницы, пошел сильный дождь.

12. Биднийг суухтай хамт кино эхэллээ. — Как только мы сели, начался фильм.

Примечание. При склонении будущего причастия гласная перед суффиксом «—х» всегда сохраняется:

явахын	ирэхийн
явахад	ирэхэд
явахыг	ирэхийг
явахаас	ирэхээс
явахаар	ирэхээр

Упражнение 1. Сначала ответьте на вопросы устно, затем напишите свои ответы. Если в них будут ошибки, от объясните причины их возникновения.

1. Аав аа. Та гэртээ харих уу? 2. Чи гэрээ санаж байна уу? 3. Танай гэр Говь-Алтай аймагт байдаг уу? 4. Танайх байшинд суудаг уу, гэрт суудаг уу? 5. Чи гэрий хээ даалгаврыг хийсэн үү? 6. Танайх хэдэн өрөө байртай вэ? 7. Танайх хэддүгээр давхарт байдаг вэ? 8. Танайх хэддүгээр орц (подъезд) вэ? 9. Танай байр тагттай (балкон) юу? 10. Ээж, та өнөөдөр гэртээ байх уу? 11. Ээж, та байрныхаа мөнгийг хураалгасан уу? (платила ли?) 12. Танайх хэзээ шинэ байр авах вэ?

Упражнение 2. Прочитайте текст 6—7-раз, затем переведите его.

Манай гэр Ховд аймагт байдаг. Миний аав малчин хүн. Манайх одоо зуслан дээрээ буух болж байгаа. Манайх өнгөрсөн жил цоо шинэ (совсем новый) гэр барьсан. Манай ахынх аймгийн төвд хоёр өрөө байранд суудаг. Тэдний байрны хажууд цэцэрлэг (сад) бий.

Онъсого таацгаа! Отгадайте загадку.

«Гэрийн хойно, гэдэн годон» тэр юу вэ? (гэээг)

Упражнение 3. Разговаривайте по образцу. Переведите.

— Чи гэр уруугаа харих уу?

— Үгүй, би жаахан сууна. (Немного посижу. В смысле «позанимаюсь»).

— Гэрт чинь хэн байгаа вэ?

— Аав, ээж хоёр бий.

— Танайх хэддүгээр байшин бэ?

— Манайх 19-р хорооллын (19-й район) 15-р байшин.

— Танайх утастай (телефон) юу?

— Манайх одоохондоо утасгүй.

— Танайх хэдэн өрөө байртай вэ?

— Манайх гурван өрөө байртай.

— Танайх хэддүгээр давхарт байдаг вэ?

— Манайх нэгдүгээр давхарт байдаг.

— Ахынх чинь гэрт суудаг уу, байшинд суудаг уу?

— Манай ахынх гэрт байдаг. Гэр нь хоёр өрөө. Ах өөрөө тийм зохион байгуулалттай гэр хийсэн юм (Брат сам соорудил такую юрту).

— Тэр чинь яаж халдаг юм бэ? (Как топится)

— Уураар халдаг (Паровое отопление).

— Ямар сонин юм бэ? (Как интересно!)

— Сонин шүү. Чи очиж үзээрэй.

— Заавал очиж үзнэ. За, баяртай.

— Баяртай.

ЦАЙ

Цай уудаггүй, мэддэггүй хүн гэж одоо үгүй билээ. Тэгвэл гурван зуугаад жилийн тэртээ европчууд цайг мэддэггүй байжээ. Энэ тухай өгүүлье. Английн нэг усан цэрэг алс хол орноос цайны хэдэн навч ээждээ бэлэг болгон авчирч өгчээ. Ээж нь хүүгийнхээ авчирсан бэлгийг танил нөхдөдөө ярьж амтыг нь сонирхуулахаар тэднийг урьжээ. Зочдыг ирэхэд нөгөө авгай тавагтай навчаа ширээн дээр авчирч тавьжээ. Хүүгийнх нь авчирсан бэлгийг зочид амталж үзсэн боловч цай тэдэнд огт таалагдсангүй. Яг энэ үеэр хүү нь гаднаас орж иржээ. Ширээ уруу харж инээмсэглэснээ:

— Ээж ээ! Та чинь юу хийчихсэн юм бэ? гэхэд ээж нь:

— Чиний хэлснээр л цайны навчийг чаналаа шүү дээ! гэжээ. Хүү нь:

— Тэгээд чанасан усаа яасан бэ? гэж асуувал ээж нь:

— Асгачихсан гэж гэнэ.

Новые слова

цай	— чай
уух	— пить
тэртээ	— тому назад
бараг	— почти
өгүүлэх	— рассказывать
усан цэрэг	— матрос
алс хол	— далёкий
навч (ин)	— лист
бэлэг	— подарок
болгон	— в качестве
авчрах	— привезти, принести
танил нөхөд	— друзья, знакомые
амт	— вкус
урих	— приглашать
авгай	— замужняя женщина
таваг	— блюдо, тарелка
тавих	— класть, ставить
амтлах	— пробовать (на вкус)
... ж үзэх	— пытаться
огт	— совсем, совершенно
таалагдах	— нравиться
яг	— как раз, ровно
гадна	— снаружи, вне
инээмсэглэх	— улыбаться
хийчих	— сделать

чанах	— варить
ус (ан)	— вода
асгачих	— вылить

Упражнение 5. Перескажите историю о чае, используя выше приведенные слова.

Упражнение 6. Переведите на монгольский язык.

Давным — давно (эрт урьд цагт) жил один богатый человек. В той же местности был умелец (уран хүн) по имени Гомбожав. Он делал прекрасные вещи. Однажды богач сказал ему: «Сделай мне (пожалуйста) красивые дверь (хаалга) и кувшин (домбо). Я хорошо заплачу тебе (их хөлс өгөх)!» Гомбожав согласился. В один из дней (нэг өдөр) богач послал своего слугу к Гомбожаву. Слуга отдал умельцу двухгодовалую (шүдлэн) овцу. Плата была слишком (даанч) мала. Гомбожав остался недоволен (дургүйцэх), поэтому сказал: «Вещи отдам завтра» На завтра слуга снова пришел в юрту Гомбожава и взял готовые (бэлэн) дверь и кувшин. Вещи были очень красивые. Богач поставил новую юрту и новую дверь. Однако каждый раз, когда дверь открывали и закрывали (нээж хаах болгонд), она говорила: «Гомбожав сделал дверь, и плата мала! «Кувшин же говорил: «Хватит! Хватит! (боль! боль!», и чай не лился (гарахгүй). Так умелец победил богача.

Упражнение 7. Переведите на монгольский язык.

А. Сын габрова решил стать хирургом! — Дурак — заметил отец. — Стань зубным врачом! У людей сердце одно, а зубов — тридцать два.

Б. — Соседушка, ваша собака опять съела мою курицу!

— Вот хорошо! Не буду ее сегодня кормить.

В. — Дедушка! У тебя есть зубы?

— Нет, мой мальчик.

— Тогда поддержи бутерброд, а я поиграю во дворе со своим дружком.

Г. — Дай мне пять яиц от черной курицы! — сказал габровец продавщице. Женщина удивилась и сказала:

— Если ты можешь их различить, выбирай.

Габровец выбрал самые крупные яйца, заплатил и ушел.

Новые слова

хирург	— мэс засалч
дурак	— тэнэг
зубной врач	— шүдний эмч

сердце	— зүрх (эп)
сосед	— хөрш
собака	— нохой
курица	— тахиа (и)
кормить	— тэжээх
бутерброд	— тостой талх
играть	— наадах
во дворе	— гадаа
яйцо	— өндөг (өндгөн)
продавщица	— худалдагч эмэгтэй
удивляться	— гайхах
если можешь	— чадвал
различать	— ялгах
выбрать	— сонгох
платить	— хураалгах, тушаах

Упражнение 8. Образуйте просительную форму II-го лица от следующих глаголов:

заах, угтах, хэлэх, хийх, эргэх, ярих, ажиллах, ирэх, суух, тогтоох, идэх, харах, дуудах, явах, биелүүлэх, бичих, хариулах, орох, захиx, гаргах.

Упражнение 9. Переведите на монгольский язык:

чтобы написать, чтобы выполнить, чтобы войти, чтобы ехать, чтобы показать, чтобы встретить, чтобы сделать, чтобы позвать, чтобы сесть, чтобы работать;

с целью спросить, с целью посмотреть, с целью узнать, с целью показать, с целью выпить, с целью встретиться, с целью побеседовать, с целью открыть, с целью закрыть, с целью понять.

Упражнение 10. Переведите и отгадайте загадки.

1. Сууж байх нь шувуу шиг
Шунаж байх нь чоно шиг (Шумуул)
2. Суусан бие нь суварга шиг
Суурьшсан гэр нь цооног шиг (Тарвага)

Упражнение 11. Переведите на русский язык, используя словарь. Выпишите из текста все причастия, указывая синтаксическую функцию каждого из них.

Д. Сүхбаатар хорвоод мэндэлсэн тэр жил (1893 он) түүний уугуул нутаг Сэцэн хан аймгийн засаг Ринчиндоржийн хошууны тамгын газарт сумын занги Тамдар нарын арваад хүнээс аж амьдралынхаа тэсвэрлэшгүй хүнд байдлын тухай зарга мэдүүлжээ. Түүнд өгүүлсэн нь: «Харьяат сум болон олон тайж ардуудын малд дарцаагаар эмгэг тусаж үгүйрч, оногдсон албаныг аргацаан гаргуулж хохирсон амыг урихнаар тэжээн тэнхрүүлэх зүйлгүйд хүрсэн олон

учрыг мэдүүлсэн боловч тухай бүр эрхиш аргацаахыг ухуулан чангалж тушаасан ёсоор албан гаргуулах хэдхэн тайж, ардуудын нижээд, үнээ, унааны төдий малад алба оногдуулан авна гэхэд тэд малаасаа амьд салахгүй... гэж элдвээр дүрсгүй авирлахад бид аргагүй алба бүтээхийг эрхэлж заримаас нууж, заримаас булаан авсаар нэгэнт иргэний (ардын) амьдралыг шууд алдагдуулахын тулд тэдгээр тайж, ард өлсгөлөн тэсвэрлэн чадахгүйгээр боогдож, эцэг, хөвгүүн тус тусын амийг бодож эгнэгт элбэрлийг алдав. Эр, эм өөрийн биеийг эрхлэн журмыг тэвчиж зүг зүг аму цагаа эрж сарниж... ард иргэн турж үхэхэд хүрэн» гэжээ.

Газар сайгүй ийм зовлонд нэрвэгдэж байсан тухай тэр үед Монгол орноор жуулчлан явсан Томскийн их сургуулийн профессор Боголепов, Соболев нар бичихдээ: монголчууд алба буюу эзэн ноёдын элдэв янзын татвар, гувчуурт нэрвэгдэж, ядуурч зүдүүрэх явдал нь өдөр ирэх тутам өсөж байна.

Манай хөсөг уруу юм тусал хайрла гэж өрөвдмөөр юм хэлсэн хөөрхийлөлтэй нүүр царай бүхий монголын ядуу бүсгүйчүүд ирцгээнэ. Энд үгүйрэл хоосрол ёстой үүрлэсэн газар гэдгийг тэдний зовж зүдэрсэн бие нь үгнээсээ илүү гэрчилж байв. Эмэгтэйчүүд, хөгшдийн хамт өлсгөлөн хүүхдүүд явцаана.

Айлууд, оршин суугчид, хүүхдүүдийн байдал ба буудал бүрт заавал хүрэлцэн ирж уулздаг монголчуудын яриа энэ бүгд нь бид үгүйрэн сүйдэж байгаа нутгаар замнаж явааг баталж байв» гэжээ.

Мөн тэр үед Монголд ирсэн английн жуулчин Каррутерс монголчуудын хүнд байдлын тухай бичихдээ:

«Эдгээр хүмүүс нь ноёд, эздийн хэр хэмжээнээс хэтэрсэн албан татварт нэрвэгдэн зовсон боолууд юм» гэжээ.

«Үнэн» №23 (16926)

1988 оны I-р сарын 27.

Упражнение 12. Переведите на монгольский язык.

А. 1. Когда я был маленьким, я боялся собак. 2. При входе необходимо предъявить пропуск. 3. Я пришел, чтобы поговорить с Вами. 4. Когда я рассказываю об отце (эцгийн тухай), я всегда показываю эту фотографию. 5. Когда она была маленькой, она хотела стать врачом. 6. Они пошли в кинотеатр, чтобы взять билеты. 7. Когда я учился в университете, он преподавал нам английский язык. 8. При входе учителя ученики (обычно) встают. 9. Когда я говорю по-монгольски, я делаю много ошибок. 10. Она отправилась в магазин, чтобы купить поларок. 11. Я взял этот журнал в библиотеке, чтобы показать вам одну очень

интересную статью (өгүүлэл) 12. При показе фильма исчез (алга болох) звук. 13. Она протянула руку (гараа сунгах), чтобы взять тарелку. 14. При повторении (давтах) этого урока я буду спрашивать у вас все слова. 15. Когда я пишу по-монгольски, я почти не делаю ошибок. 16. Дочь пошла на почту, чтобы отправить письмо. 17. При заучивании слов пишите их! 18. Он пригласил своих друзей, чтобы показать им коллекцию (цуглуулга) монгольских марок. 19. Когда она улыбается, она мне очень нравится. 20. Чтобы увидеть далекие страны, он стал матросом. 21. Когда мы начинали учить монгольский язык, мы почти ничего не знали о Монголии. 22. Когда я жду тебя, я (обычно) очень волнуюсь (сэтгэл зовох). 23. Он встал чтобы открыть окно. 24. Чтобы перевести эти предложения, повторите грамматику!

Б. 1. Подожди меня, пожалуйста. 2. Покажите, пожалуйста, Ваш пропуск. 3. Принеси, пожалуйста, тарелку. 4. Дай, пожалуйста, бутерброд. 5. Улыбнитесь, пожалуйста. 6. Пожалуйста, покорми мою собаку. 7. Позови, пожалуйста, свою сестру. 8. Выбери, пожалуйста, самую красивую ручку. 9. Пожалуйста, пригласи его. 10. Пожалуйста, сядь-те здесь.

УРОК 8

УЛААНБААТАР ХОТ

(Город Улан—Батор)

Улаанбаатар хот бол БНМАУ-ын нийслэл юм. Улаанбаатарыг урьд нь Өргөө, Хүрээ, Да Хүрээ гэж нэрлэдэг байжээ. 1924 онд Хүрээг Улаанбаатар (Красный богатырь) гэж нэрлэх болжээ. Улаан гэж «Красный» гэсэн үг. Баатар гэдэг «богатырь» гэсэн орос үгтэй ижил үг. Эртний монгол хэлэнд «Багатур» гэж бичиж, дууддаг байжээ. Одоо цагийн монгол хэлнээ «г» авиа нь гээгдээд, үүний дүнд урт эгшиг үүсэж одоо «баатар» гэж дуудах болсон юм.

— Тэгвэл «богатырь» гэдэг маань монгол үг байх нь ээ?!

— Тиймээ, энэ бол монгол үг. Их сонин зүйл байна.

Улаанбаатар бол ёстой л «Красный богатырь» юм. Учир нь хувьсгалын өмнөх Да Хүрээг өнөөдрийн Улаанбаатартай зүйрлүүлэхэд танигдашгүй болтлоо хөгжжээ. Улаанбаатар бол орчин үеийн гоёмсог хот юм. Улаанбаатар хотын гудамж талбай, өргөн чөлөө нь уужим тэнэгэр, ногоон мод ихтэй.

Хотын төвд жанжин Сүхбаатарын талбай бий.

Талбайн хойд талд Засгийн газрын Ордон, зүүн талд нь Дуурь бүжгийн Улсын академик театр, Шинжлэх ухаан мэдээллийн төв, баруун талд нь Үйлдвэрчний Эзлэлийн Төв Зөвлөл, Төв шуудан зэрэг олон барилга бий. Талбайн өмнө талд өргөн их цэцэрлэг байх бөгөөд цэцэрлэгийн өмнө Ленин клуб, Гадаад явдлын Яам, Улсын филармони зэрэг олон албан газар бий.

Улаанбаатар хот «Баянгол», «Хангай», «Алтай», «Шөгдөлчин», «Улаанбаатар», «Залуучууд» зэрэг олон гоёмсог зочид буудалтай.

Засгийн газрын Ордны ард Монгол Улсын Их сургууль байрлажээ.

Улаанбаатар бол социалист Монголын соёл шинжлэх ухаан, үйлдвэрийн төв мөн.

Улаанбаатар дөрвөн талаасаа модтой өндөр уулаар хүрээлэгдэх бөгөөд далайн төвшнөөс мянга гаруй метрийн өндөрт оршино. Улаанбаатарын өмнүүр Туул гол урсана. Дэлхийн бусад хотоос ялгарах нэг зүйл бол Улаанбаатараас хотын аль зүгт ч гэсэн шугамын автобусаар яваад гүн ой, цэнгэг уст гол горхинд хүрч болно. Улаанбаатар хотод оршин суугч хүнд зугаалга хийнэ гэдэг (загородная поездка) ямар ч төвөггүй ажил мөн.

Улаанбаатар хот түүх дурсгалын үнэт зүйлийг ихээр хадгалжээ. Улсын Төв музей, Лениний музей, Хувьсгалын музей, Богд хааны зуны өргөө, Хотын музей, Дүрслэх урлагийн музей зэрэг онц сонирхолтой музей олон бий.

Улаанбаатар бол гурван зуу гаруй жилийн түүхтэй хот юм.

Социалист Монголын нийслэл Улаанбаатар хот өдрөөс өдөрт цэцэглэн хөгжиж байна.

Слова и выражения

нийслэл	— столица
нэрлэгдэх	— называться
ялах	— победить, побеждать
ижил	— одинаковый
эртний	— древний
дуудах	— произносить
одоо цагийн (син. орчин үеийн)	— современный
авиа (н)	— фонема, звук
гээгдэх	— опускаться
урт эгшиг	— долгие гласные
үүсэх	— образовываться, возникать

ёстой л
зүйрлүүлэхэд
танигдах
болтол
гоёмсог
гудамж (ин)
талбай
өргөн чөлөө
уужим
тэнэгэр
ногоон
жанжин

Засгийн газрын Ордон
зүүн

Дуурь бүжгийн Улсын
академик театр
бүжиг
баруун
Үйлдвэрчний Эвлэлийн Төв
Зөвлөлийн Ордон
барилга

өргөн их цэцэрлэг
этгээд

Гадаад явдлын Яам(ан)

албан газар
ард

дөрвөн талаасаа
хүрээлэгдэх
ялгарах нэг зүйл

урсах
аль (алин)
шугам

гүн ой
цэнгэг ус
хүрэх

зугаалах
түүх дурсгалын

— поистине
— если сравнить
— быть узанным
— до, пока (последлог)
— красивый
— улица
— площадь
— проспект
— широкий, просторный
— спокойный
— зеленый
— полководец, главнокомандующий
— Дом правительства
— восточный, левый
академик театр
— Государственный академический театр оперы и балета
— танец, пляска
— западный, правый
— Дом Центрального Совета профсоюзов
— строительство, стройка, постройка
— большой сад
— 1) сторона
2) лицо, элемент
— Министерство иностранных дел
— учреждение, ведомство
— сзади, позади, за (последлог); север
— с четырех сторон
— окружен
— один из отличительных признаков
— течь, протекать
— какой, который, любой
— 1) линия, черта
2) линейка
— густой лес
— пресная вода
— доходить, доезжать, добираться, достигать
— гулять, развлекаться
— исторический

үнэт зүйл
хадгалах
дүрслэх урлаг
сонирхолтой

— достопримечательность
— хранить, сберегать
— изобразительное искусство
— интересный, достойный
внимания
— цвести, расцветать
— развиваться

цэцэглэх
хөгжих

ГРАММАТИКА: —————

СЛИТНОЕ ДЕЕПРИЧАСТИЕ

(Хам нөхцөл үйл үг)

Суффиксом слитного деепричастия является —н. Это деепричастие (вместе с соединительным и разделительным) входит в группу сопутствующих деепричастий.)¹² Слитное деепричастие по значению близко к соединительному и выражает одно из двух действий, протекающих одновременно, причем такое, которое является сопутствующим со вторым или характеризует его. Например:

1. Охин нь түүнийг хүзүүдэн унав. — Дочь бросилась ему на шею (букв.: **обхватив** его за шею, унала).

2. Манай анги тэр хавьд оршин байв. — Наша часть стояла (букв.: **располагаясь** была) в том местечке.

Монгольскому слитному деепричастию соответствуют в русском языке не только деепричастия, но и наречия образа действия или места), сочетания существительных с предложениями или даже предлог («для»). Например:

уншин — читая (от «унших» — «читать»)

харгалзан — учитывая, с учетом (от «харгалзах» — «учитывать»)

дахин — снова (от «дахих» — «повторять»)

зэрэглэн — рядом (от «зэрэглэх» — «стоять рядом»)

тохиолдуулан — по случаю, в ознаменование... (от тохиолдуулах — «приурочивать»)

холбогдуулан — в связи (с чем—то)... (от «холбогдуулах» — «приводить в соответствие, увязывать»)

зориулан — для (от «зориулах» — «предназначать»)

Очень часто слитное деепричастие является первым компонентом в составе парных слов, например:

ардын хянан шалгах групп — группа народного **контроля**

зэмлэн буруушаах — осуждать

өдөөн хатгалга — провокация

хүлээн авалт — приём

намын зохион байгуулалт — структура партии

Слитное деепричастие, в отличие от всех остальных деепричастий монгольского языка, может принимать отрицание — гүй. Причем, в этом случае суффикс —н меняется на —л—. Например:

1. Юу ч ололгүй гэртээ харив. — Ничего не найдя, вернулись домой.

2. Гэвч гар буу барилгүй дөрвөн жил боллоо. — Но вот уже четыре года, как (я) не брал в руки (букв.: не беря в руки) пистолета. (П).

Словообразование: суффиксы «—ш (гүй)», «—га», «—т»,

1. Путем присоединения суффикса —ш к глагольной основе образуются имена со значением: результата действия; места совершения действия; предмета, на который направлено действие. Например:

онош — диагноз (от «онох» — «попадать в цель»)

хайлш — сплав (от «хайлах» — «уплавиться»)

дарш — силос (от «дарах» — «консервировать»)

хэвтэш — ложе, постель (от «хэвтэх» — «лежать»)

булш — могила, курган (от «булах» — «закапывать»)

идэш — пища, еда (от «идэх» — «кушать»).

Однако чаще всего суффикс —ш употребляется с отрицанием —гүй. Имена на —шгүй соответствуют русским прилагательным и выражают невозможность совершения действия. Например:

салшгүй хань — неразлучный друг (от «салах» — «разлучаться»)

уучилшгүй явдал — непростительный проступок (от «уучлах» — «прощать»)

хэмжээлшгүй эрх — неограниченное право (от «хэмжээлэх» — «ограничивать»)

марташгүй уулзалт — незабываемая встреча (от «мартах» — «забывать»)

тэсвэрлэшгүй хүйтэн — невыносимый холод (от «тэсвэрлэх» — «терпеть»)

орчуулагдашгүй үг — непереводимое слово (от «орчуулагдах» — «быть переведенным»)

эвдэршгүй найрамдал — нерушимая дружба (от «эвдэрэх» — «разрушаться»)

2. При помощи суффикса —га, —гэ, —го, —гө — в соответствии с гармонией гласных) от глагольных основ образуются имена со значением процесса или результата действия. Например:

ажиллагаа — деятельность (от «ажиллах» — «работать»)

зугаалга	— прогулка (от «зугаалах»—гулять)
судалгаа	— исследование (от «судлах»—изучать)
цуглуулга	— коллекция (от «цуглуулах»—собирать)
хими цэвэрлэгээ	— химчистка (от «цэвэрлэх»—чистить)
цоолго	— прорубь (от «цоолох»—продырявливать)
төлөвлөгөө	— план (от «төлөвлөх»—планировать)

3. Путем присоединения суффикса —т к именным основам образуются имена со значением обладания тем, что выражено основой. Такие имена на русский язык переводятся прилагательными. Например:

өнгөт	— цветной (от «өнгө»—цвет)
үнэт	— ценный (от «үнэ»—цена)
зоригт	— смелый (от «зориг»—воля, смелость)
хувьсгалт	— революционный (от «хувьсгал»—революция)
түүхт	— исторический (от «түүх»—история)
морьт	— конный (от «морь»—конь)
үзэсгэлэнт	— прекрасный (от «үзэсгэлэн»—красота)
навчит	— лиственный (от «навч»—лист)
гайхамшигт	— удивительный (от «гайхамшиг»—чудо, диво)

Прошедшее причастие в орудном падеже

Прошедшее причастие в орудном падеже обозначает действие (или состояние), в результате которого совершается другое действие (или имеет место другое состояние) и на русский язык переводится оборотами со словами «в результате...», «вследствие...», «как (что -то сделано), так и...». Например:

1. 1936 онд Налайх—Улаанбаатарын төмөр зам барьж ашиглалтад **орсноор** Сэржийн ажилчин болсны намтар эхэлжээ. — **В результате** строительства и пуска в эксплуатацию Налайхо—Улан-Баторской железной дороги началась биография Сэржа как рабочего.

2. Чиний **хэлснээр** л хийлээ шүү! — **Как ты сказал—так и сделали-** (т.е. по твоим словам...).

Речевой глагол «гэ—»

Глагол **гэ—**(говорить, сказать) употребляется для передачи прямой или косвенной речи и в таких случаях соответствует русскому союзу «что» или — в письменной речи — кавычкам. Например:

Мэднэ! гэв. Сказал, что знает (узнает).
Сказал: «Знаю!» (Узнаю!)

В сочетаниях с другими речевыми глаголами («хэлэх — говорить, «асуух» — спрашивать, «хариулах» — отвечать, «нэрлэх» — называть, «заах» — указывать, «тэмдэглэх» — отмечать, «мэдэгдэх» — заявлять, «унших» — читать, «бичих» — писать, «бодох» — думать, «мэдэх» — знать и др.) глагол **гэ** — имеет форму соединительного дееспричастия **гэж**. Например:

1. Амжихгүй **гэж** бодож байв. — Думал, что не успею (Думал: «Не успею»)

2. Их баярлалаа! **гэж** хэлсэн. — Сказал: «Большое спасибо»!

В причастных формах глагол **гэ** — на русский язык как правило, не переводится. Например:

1. Манай үеийн баатар **гэдэг** роман.. — Роман «Герой нашего времени»...

2. «Дайн сөнөтүгэй!» **гэсэн** лоозон.. — Лозунг «Долой войну!» («Нет — войне!»).

Сочетание «будущее причастие + **гэж** + неречевой глагол» соответствует русскому обороту **цели**. Например:

Билет **авах гэж** явсан. — Ушли за билетами

(Билет **авахаар** явсан.) — (чтобы **купить** билеты).

Сочетание «будущее причастие + **гэж** + «бай —» переводится на русский язык оборотом «собираться сделать что — то». Например:

Амрах **гэж** байна. — Собираюсь отдохнуть

Ирэх **гэж** байсан. — Собирался приехать.

Упражнение 1. Ответьте на следующие вопросы.

1. БНМАУ-ын нийслэл ямар хот вэ? 2. Улаанбаатар хотыг хуучин юу гэж нэрлэдэг байсан бэ? 3. Улаанбаатар гэж юу гэсэн үг вэ? 4. Хотын төвд юу юу байдаг вэ? 5. Өөр бас юу байдаг вэ? 6. Улаанбаатар хотод ямар ямар зочид буудал байдаг вэ? 7. Улаанбаатар хот ямар газар оршдог вэ?

Упражнение 2. Ответьте на вопросы: Затем напишите небольшое сочинение на тему «Улаанбаатар».

1. Монгол улсын нийслэл юу вэ? (ямар хот вэ?). 2. Та Монгол улсын нийслэлд очиж үзсэн үү? 3. Нийслэл Улаанбаатар нутгийнхаа аль хэсэгт оршдог вэ? 4. Улаанбаатар хотыг юутай зүйрлэж болох вэ? 5. Ямар учраас Улаанбаатарыг «Красный богатырь» гэж нэрлэж болох вэ? 6. Улаанбаатар бусад хотоос юугаараа ялгаатай вэ?

Упражнение 3. Переведите.

1. Улаанбаатар орчин үеийн гоёмсог сайхан хот бөгөөд эргэн тойрон модтой уулаар хүрээлэгджээ. 2. Хотын төвд

Сүхбаатарын хөшөө, түүний урд талаар өргөн гудамж бий. Тэр гудамжийг «Энх тайвны өргөн чөлөө» гэдэг. 3. Хотын эргэн тойронд цэнгэг устай гол горхи олон бий. 4. Улаанбаатар хот гурван зуу гаруй жилийн түүхтэй бөгөөд хуучин Да Хүрээ гэж тус хотыг нэрлэж байжээ.

Упражнение 4. Ответьте на следующие вопросы.

1. Явах хүн нь аль вэ? 2. Чи очих хүнийг нь таних уу?
3. Би өнөөдөр хүрэх газраа хүрч чадах уу? 4. Эргэх дөрвөн цагийн улирал гэж юу вэ?

Упражнение 5. Переведите и запомните.

1. Унтах нойронд минь зүүдлэгдсэн
Учралт хонгорын минь хайр уу даа. (Из песни)
2. Уудаг усыг минь сураглаад асуувал хө хө хө
Урьд захын гурван худгийн дунд
талын өндөр худаг хө хө хө
Суудаг байшингий минь сураглаад асуувал хө хө хө
Цувраа барьсан гурван байшингийн дунд
талын шилэн байшин хө хө хө
(Из народной песни)

Упражнение 6. Прочитайте и переведите.

1. Тантай зэрэгцэн суухад над таатай байна.
2. Бид хоёр энэ тэрийг ярилцан явсаар, нэг мэдэхэд гэртээ ойртсон байлаа.
3. Гэдрэг суун хэлхийлгүй
Хойш суун холхойлгүй (Ц. Дамдинсүрэн)
4. Би мэдэлгүй чамайг сэрээчихлээ. Уучлаарай.
5. Бадамлянхуа усан мандалд гандашгүйеэ хө
Бахтай чи минь оюун бодлоос гаршгүйеэ хө (Из песни)
6. Давахгүй гэсэн даваагаар долоо давж
Уулзахгүй гэсэн хүнтэйгээ гурав уулзах (Пословица)
7. Тэр үед Москва над марташгүй сэтгэгдэл төрүүлж билээ.
8. Монгол, зөвлөлтийн ард түмний эвдэршгүй гаг бат найрамдал улам бүр цэцэглэн хөгжсөөр байна.

Упражнение 7. Переведите слова. Составьте предложения с данными словами.

1. Магадлагаа, 2. Гэрчилгээ, 3. Шаардлага, 4. Урьдчилгаа,
5. Өр авлага.

Упражнение 8. Прочитайте текст и переведите.

ҮЗЭСГЭЛЭНТ НУТАГ

Монгол Алтай бол үзэсгэлэнт сайхан нутаг юм. Далайн төвшнөөс өндөрт өргөгдсөн олон уул нуруу, цэнгэг уст гол үзэмжит сайхан байгалиараа бусад нутгаас ялгарна. Алтайд хавтгай (дикий верблюд), хулан, тахь, аргал угалз, янгир, бөхөн (сайгаки) зэрэг дэлхийд ховор амьтад олон бий. Сүрлэг Алтайн их уулсын хооронд их говь бий.

Упражнение 9. Переведите и выучите наизусть «Песню об Улан-Баторе» Ц. Гайтава.

Ц. Г а й т а в .

УЛААНБААТАРЫН ТУХАЙ ДУУ

Намуухан шөнө түм түмэн зулаа асааж
Нарлаг өдөр бум буман толио гялбуулж
Хөвч ханхар уулын ард ярайсан
Хөх цэнхэр тэнгэрийн дор дурайсан
Сайхан эх орноо тэтгэгч булаг болсон
Саруул их үе өөд зүтгэгч хөлөг болсон
Улаанбаатар хот минь хүч чадлаа эрчлээд
Улс монгол орныхоо зүрх болон тэлж байна.
Үйлдвэрийн яндан энхийн харуулд нь зогссон
Үзэсгэлэнт барилга мөнхийн саруулд нь жагссан
Ажил амьдралын арвинаар хүчээ авч байдаг
Ижил хамтын санаагаар хүслээ өвч хийдэг
Сайхан эх орноо тэтгэгч булаг болсон
Саруул их үе өөд зүтгэгч хөлөг болсон
Улаанбаатар хот минь хүч чадлаа эрчлээд
Улс монгол орныхоо амьсгал болон цохилж байна
Москва хот ахтайгаа гараа бат барьсан
Мөнх сайхан үе өөд нэрээ тод бичсэн
Мөрөөдөж хүссэн замаараа мөрөө тод гаргасан
Мөнгөн Туулын хөвсөн дээр мөч бүхэнд жаргасан
Сайхан эх орноо тэтгэгч булаг болсон
Саруул их үе өөд зүтгэгч хөлөг болсон
Улаанбаатар хот минь хүч чадлаа эрчлээд
Улс монгол орныхоо амьсгал болон цохилж байна

Новые слова

тухай	— о, об, про (последлог)
дуу (н)	— песня
намуухан	— тихий, спокойный
зул	— лампада
асаах	— зажигать

нарлаг
хөх цэнхэр
толь гялбуулах

тэнгэр
дурайх
хөвч
ханхар
ярайх

тэтгэх
саруул
өөд

зүтгэх

хөлөг

хүч чадал
эрчлэх
зүрх (эн)
тэлэх
яндан (г)
энх
харуул
зогсох
мөнх
жагсах
арвин
хүч (ин)
хүчээ авах
хамтын
санаа (н)
хүсэл
хүслээ хийх
өвч
амьсгал
цохилох

гар
бат
тод
мөрөөдөх
хүсэх
зам
мөр
гаргах
мөнгө (н)

— солнечный
— синевато-голубой
— сверхать зеркалом (на
солнце)
— небо
— виднеться ясно, отчетливо
— лес, тайга
— величавый, внушительный
— растянуться вереницей,
поблескивая
— поддерживать, опекать
— светлый
— к, на, по, в - в значении
«вверх». (последлог)
— тянуть, вести за собой;
стараться
— 1) экипаж, карета
2) судно, корабль; лайнер
— сила, мощь
— скрутить, напрячь
— сердце
— расширяться, увеличиваться
— труба (дымоходная)
— мир, спокойствие
— стража
— стоять
— вечный
— выстраиваться
— обилие
— сила
— черпать силы
— общий, коллективный
— мысль; идея; намерение
— желание
— осуществлять свои желания
— полный, целый, полностью
— дыхание
— биться (о сердце); быть
(множественно)
— рука
— крепкий, крепко
— ясный; ясно отчетливо
— мечтать, тосковать
— желать, хотеть
— дорога
— след
— оставлять (след); выводить
— серебро, деньги; серебряный

хөвөө (н)	— край (берега); кромка
бүхэн	— каждый
мөч	— мгновение
жаргах	— быть счастливым
тархи (н)	— 1) головной мозг
	2) ум
сэтгэх	— мыслить, думать

Упражнение 10. Переведите на русский язык, используя словарь.

Д. Нацагдорж

ШУВУУН СААРАЛ

(1)

Хөндий талын зэргэлээ мяралзаж, ирвэгнэх нь холоос үзэхэд сонин, хэдэн жижигхэн юм түүний дотор сүүмэлзэх нь агаарт дэгдэж, үүлэнд умбан алдмара хоёр чихээ солбил-раа сэлгүүцэх, хээр хөдөөгийн цэнгэл, хурдан морины яралзан ирэх эр хүний бахдал, ойртон үзвэл хэдэн залуучууд морьд тарлаж байв.

(2)

Сүрэнхүү, саарал морины амыг арайхийн тогтоож, овооны дэргэд буун хөлсийг нь хусаад тамхи татна. Ташаа нь тэвхийж, хавирганы яс нь зурайсан, ялуун саарал морь нь тогтож ядан гуа сайхан дөрвөн хөлөөрөө ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сажих нь агаарт дэгдэж, үүлэнд умбан алдмаар хоёр чихээ солбил-зуулан, хааяа нэг шилгээж, эзнийхээ сэтгэлийг баясгана.

(3)

Энэ үе удаа дараа хүрч ирсэн хүмүүс, түүнийг гайхан магтах бөгөөд шувуун саарал гэж нэрийдэв. Сүрэнхүүгээс шалж өдий төдий залуу тарган морины үнэ хаялцана. Сүрэнхүү, морины толгойг илж худалдахгүй гэнэ. Цугаараа нэгэн зэрэг шувуун саарлын тухай яриа бололцоод, оройн шар наранд зүг зүг гэр гэртээ, хоёр гурваар нийлэлдэн ярилцан исгэрэлдэн одоцгооно...

1930 он

Упражнение 11. Переведите на монгольский язык.

1. В результате победы социалистической революции в нашей стране установилась народная власть. 2. Вследствие землетрясения (газар хөдлөх) разрушены (нурж сүйдэх)

тысячи строний изданий. 3. В результате визита (зйлч-лах) в нашу страну министра иностранных дел МНР был заключен этот договор. 4. В результате пуска (в эксплуатацию) электростанции появились возможности (бололцоо) для строительства в этом районе двух крупных заводов. 5. В результате оказания поддержки (дэмжлэг үзүүлэх) Вьетнаму со стороны социалистических стран и прогрессивных сил всего мира народ этой страны одержал победу. 6. В результате визита главы (тэргүүн) этого государства в СССР заключен договор о дружбе и сотрудничестве. 7. Вследствие бомбежки (бөмбөгдөх) город стал неузнаваемым. 8. Вследствие того, что рабочие трудились днем и ночью, завод был пущен в эксплуатацию через 2 месяца. 9. Как ты написал-так и сделали! 10. Как он сказал так и сварили!

Упражнение 12. Переведите на монгольский язык, обращая внимание на подчеркнутые слова.

1. Сегодня на улице **невыносимый** холод. Я не пойду гулять. 2. Его младшая сестра принесла **несъедобные** грибы (мөөг). Она не умеет собирать (түүх) грибы. 3. На собрании председатель объединения говорил о **непростительном** поступке Даваа. 4. В этом стихотворении (шүлэг) много **непереводимых** слов. Я понимаю смысл последней строки (мөр), но не могу найти подходящие русские слова. 5. Я избавился от нестерпимой боли. Теперь мое здоровье лучше. 6. Руководители этой группы допустили **непростительные** ошибки. В выпущенном постановлении (тогтоол) написано о правом уклоне 7. Военная хунта установила свою **неограниченную** власть. Люди боятся выйти из дома 8. Участники собрания говорили о **нерушимой** дружбе монгольского и советского народов. 9. Это была **незабываемая** встреча. Я могу рассказать вам о ней. 10. Этот город стал **неузнаваемым**. Я жил здесь 20 лет назад. Тогда население города составляло (болох) 100 тысяч человек. 11. У цыпешней молодежи **неограниченные** возможности (бололцоо). Когда я был молодым, я работал с утра до вечера на заводе. У меня было возможности учиться. А мой сын стал известным ученым. Двое моих внуков (ач) учатся в аспирантуре. 12. Вы с ним знакомы? Он мой **неразлучный** друг. Мы вместе закончили школу, вместе учимся в ИСЛА при МГУ.

УРОК 9

МИНИЙ АЖЛЫН ӨДӨР

(Мой рабочий день)

Би өглөө 7 цагт босож, биеийн тамирын дасгал хийж, гар нүүрээ угаагаад цайгаа уудаг. Хичээл 9 цагаас эхэлнэ. Бид өдөрт 6 цагийн хичээл хийдэг. Орой зав гарвал кино үзнэ. Бидэнд монгол хэлний хичээл сонин байдаг. Бид одоогоор ойлгох зүйл бага байвч монгол хэлний зүйн онцлог байдал сонирхол татна. Би өдөрт тогтмол 6—7 шинэ үг тогтоодог. Би автобусны зогсоол, гудамж, хаа боловч заавал үг тогтоож явдаг. Хэл сурахын тулд нэг хормыг ч атугай үр бүтээлтэй ашиглаж сурах хэрэгтэй. Ил газар монгол үгийг цөөн цөөнөөр бичиж хадаад нүдлэх их сайн.

Би өдөрт монгол хэлний нэвтрүүлэг буюу яриаг 2—3 цаг заавал сонсдог. Ингэх нь яриаг ойлгодог, өөрөө ярьдаг болоход их чухал юм. Бололцоо олдвол монгол хүнтэй ярихыг хичээдэг.

Аливаа гадаад хэл сурч буй хүн уг хэлийг сайн сурахын тул олсн янзын аргаар хичээллэх нь зүйтэй.

Иймээс миний ажлын нэг өдөр зөвхөн л үүнд зориулагддаг юм. Учир нь хэлийг сайн сурна гэдэг бол зөвхөн олон үг мэдсэнээр ч хязгаарлагдахгүй. Эсвэл дан ганц дүрэм цээжилснээр ч биелэхгүй. Аль алиныг хослуулах хэрэгтэй. Дүрэм ч хэрэгтэй. Үг ч хэрэгтэй. Үгийг салангид цээжлээд хэрэггүй. Заавал бусад үгтэй нь холбоотой тогтоох хэрэгтэй. Жишээ нь «нойр» («сон») гэсэн үгийг тогтоолоо гэхэд хажууд нь «хүрэх»-«хулжих» гэсэн хоёр үгийг давхар тогтоосвол бүр сайн. Учир нь орсоор «сон идёт (не идёт)» гэдэг байхад монголоор «нойр ирж байна (прэхгүй байна)» гэхгүй, харин «хүрч байна (хүрэхгүй байна)» гэнэ. Ийм учраас хэл сурч буй хүн ямагт бодож, сонсож, ярьж бичиж байх хэрэгтэй. Бодож, сонсож ярьж, бичиж нэг өдөр, нэг сар, нэг жил, гурван жил, таван жил, нэг насаа зориулвал хэл сурч болно.

Слова и выражения

өглөө	— утро, утром
босох	— вставать
биеийн тамирын дасгал хийх	— делать зарядку
гар нүүрээ угаах	— умываться
цайндаа орох (цайгаа уух)	— идти завтракать
цаг	— время, час, часы

эхлэх
 өдөрт
 орой
 одоогоор
 зав
 онцлог байдал
 сонирхол татах
 автобусны зогсоол
 хаа боловч
 тулд
 хором
 атугай
 үр бүтээлтэй
 ашиглах
 ил газар
 цөөн
 хадах
 бүдлэх
 монгол хэл дээр явагддаг
 нэвтрүүлэг
 сонсох
 ингэх
 бололцоо
 олдох
 хичээх
 уг
 аливаа
 олон янзын арга
 зориулагдах
 бүтэх
 эсвэл
 дан
 цээжлэх
 аль алиныг
 хослуулах
 хос
 салангид
 хажууд
 нэг насаа

- начинать
- в день
- вечер, вечером
- сейчас
- досуг, свободное время
- специфика
- вызывать интерес
- автобусная остановка
- где бы ни находился
- ради, для, чтобы (последлог)
- секунда
- хотя бы, пусть
- рационально, с пользой
- использовать
- на видном месте
- немного по нескольку
- 1) прикрепить, прибить
- 2) косить, жать
- зрительно запоминать
- передачи на монгольском языке
- слушать
- делать так, таким образом
- возможность
- обнаружиться, найтись
- стараться
- здесь: этот, данный
- любой, всякий, каждый, какой бы ни был
- много различных методов
- быть посвященным чему-либо
- осуществляться, сбываться, исполняться
- или; напротив, в противном случае
- 1) одинарный, без пары
- 2) только, совсем
- выучивать наизусть, запоминать
- то и другое
- сочетать, соединять попарно
- пара
- врозь, отдельно
- 1. возле, около, рядом
- 2) помимо того, наряду с...
- всю жизнь

УСТУПИТЕЛЬНОЕ ДЕЕПРИЧАСТИЕ

Дутагдах нөхцөл үйл үг

Суффиксом уступительного деепричастия (которое входит в группу обстоятельственных деепричастий) является **-вч**. Эта форма обозначает действие, вопреки которому совершается действие управляющего глагола.

Например:

1. Өндөр уулан дээрээс **ширтэвч**

Холын бараа харагдахгүй

Өдөр шөнөгүй хүлээвч

Сэтгэл санааны гарз. (Д. Н.)

Даже если с высокой горы **устремишь** (свой) взгляд.

Далекий силуэт не появится (букв.; не завиднеется).

Даже если будешь **ждать** днем и ночью,

— Все напрасно (букв.; потеря души и мыслей).

2. Бүгдийг мөлжихийг доллар хүсэвч

Бүгдээр найрамдахыг бид хүснэ (Ц. Д.).

Хоть и хочет доллар всех эксплуатировать,

Мы хотим, чтоб все пришли к согласию.

3. Одоо зововч хожим жаргах цаг байх болно (Ц. Д.).

Хотя сейчас страдаем, потом будем радоваться (букв.; настанет время блаженствовать).

4. Нисэгч нар уг газрыг хэчнээн ширтэн харавч хүмүүсийг олж үзсэнгүй. — **Сколько ни** вглядывались летчики в местность—людей не обнаружили.

5. Чи хэчнээн түргэн бичивч бүх үгийг тэр дор нь бичиж амжихгүй. — **Как бы** быстро ты ни писал—все равно сразу все слова написать не успеешь.

Для выражения уступительного значения используются также «комбинированные» формы: причастие или имя+«боловч» или-редко—«байвч» т.е. глаголы «бол—» или «бай—» в форме уступительного деепричастия). Например:

1. Юу ч мэдэхгүй боловч «мэдэлгүй яах вэ?» гэж тэр хариулав. **Хотя** ничего не знает, он ответил: «Конечно, знаю!».

2. Хичээлдээ ирээгүй боловч үг хуулан бичсэн байв.

Хотя не пришел на урок, слова были переписаны.

3. Би өөрийн энэрэнгүй сэтгэлээр тэгсэн гэж болох боловч худал хэлэхийг хүсэхгүй. — (**Хотя**) Я мог бы приписать умеренность мою одному великодушию, но не хочу лгать (П).

4. Бат настай болсон боловч залуу хүн шиг ажилладаг.

Хотя Бат постарел, он работает, как молодой.

5. Тоть шувуу муухай дуутай **боловч** хүний хэлийг дуурайж чадна.

— **Хотя** попугай имеет неприятный голос, он может имитировать человеческий язык.

6. Сайн эм аманд гашуун **боловч**—өвчинд—тустай

Шударга үг чихэнд аягүй **боловч** явдалд тустай

Хотя хорошее лекарство вызывает горечь во рту, оно помогает при болезни.

Хотя справедливые слова неприятны для ушей, они помогают делу.

7. Хүйтэн байвч тэд өдөр бүр цанаар гулдадаг.—**Хоть** и холодно они каждый день катаются на лыжах.

УСЛОВНОЕ ДЕСПРИЧАСТИЕ

(Болзох нөхцөл үйл үг)

Условное деспричастие входит в группу обстоятельственных деспричастий. Оно выражает действие, при условии которого совершается действие управляющего глагола. Например:

1. **Эхэлбэл** дуусгах хэрэгтэй

Эрвэл олох хэрэгтэй

Если **начинать**—надо закончить (Начал—закончи)

Если **искать**—надо найти (Ищешь—найди)

2. Алтан хараацай өндөрт нисэж байвал тэнгэр цэлмэг сайхан байх.

— Если ласточки **летают** высоко, будет хорошая погода (быть хорошей погоде).

3. Чи **явбал** надад утастаарай!—Если **пойдешь**—позвони мне!

4. Бид номын санд **очвол** ямар ном авах вэ? — Если мы **пойдем** в библиотеку, какие книги **взять**?

Суффиксом условного деспричастия является—**бал**)—**вал**.

Если основа глагола оканчивается на согласные —в, —л, —м—пишется—**бал**) —**бэл**, —**бөл**, —**бөл**, в соответствии с гармонией гласных). Например:

авбал

— если **взять**

зовбал

— если **горевать**

жишээлбэл

— если **привести пример**
(например)

төлбөл

— если **заплатить**

нэмбэл

— если **прибавить**

(самар) цөмбөл

— если **щелкать (орехи)**

Если основа глагола оканчивается на любую другую согласную или гласную—пишется—**вал**(—**вэл**, **вол**,—**вел**—в соответствии с гармонией гласных). Например:

сурвал	— если учиться
үзвэл	— если посмотреть
босвол	— если встать
өгвэл	— если дать
эндвэл	— если испортить
асуувал	— если спросить
гаргавал	— если выпустить
хийвэл	— если сделать
сонговол	— если выбрать

Условное деепричастие может принимать отрицательную частицу **эс**: «эс явбал»—«если не ходить» и т. п.

Для выражения условия используется также частица **бол** (гаглологически вместо «болбол», т. е. от глагола **бол**—в форме условного деепричастия). Частица **бол** употребляется после причастий, имен и отрицания **үгүй**. Например:

1. Та **завтай болсон бол** манайд очихгүй юу?—Если Вы освободились, не зайдете ли к нам?

2. Чи **айж байгаа бол** хоёулаа очё!—Если ты боишься—пойдем (—ка) вдвоём!

3. Намайг сургуульд **оруулахгүй бол** би хаашаа очих билээ?—Если меня в школу не возьмут, куда мне идти?

4. Би сүүтэй цай уумаар байна. **Хар цай бол** уухгүй.—Я бы выпил чай с молоком. Если без молока—не буду (пить)

5. Чамд мөнгө **хэрэгтэй бол** би өгнө.—Если тебе нужны деньги—я дам.

6. Чи ардын дуу сонсох **дуртай бол** би чамд энэ хоёр пянз бэлэглэе.

— Если ты **любишь** слушать народные песни, я подарю тебе эти две пластинки.

Танилтай бол талын чинээ

Танилгүй бол алгын чинээ

У кого есть друзья — тот широк, как степь

У кого нет друзей — тот узок, как ладонь

(буквально: если с друзьями — величиной со степь

если без друзей — величиной с ладонь

8. **Өвчин үгүй бол** жаргал

Өр үгүй бол баян

Если нет болезней — счастье

Если нет долгов — богатство

Оборот условного деепричастия со словом «зохино» соответствует русскому обороту со словом «необходимо (сделать что-то)» или «следует (сделать что-то)». Подобный стиль характерен для письменных текстов, преимущественно официального характера. Например: Аймаг, хотын намын хо-

роод ... ажлаа ... VIII таван жилийн төлөвлөгөөний бие-
лэлтийг хангахад **чиглүүлбэл зохино.** — Аймагчым и городс-
ким партийным комитетам **следует направлять свою работу**
на обеспечение выполнения планов VIII пятилетки.

Упражнение 1. Дайте на следующие вопросы устные и письменные
ответы.

1. Та өглөө хэдэн цагт босож юу хийдэг вэ? 2. Та одоо
монгол хэлний хичээлийг хэр зэрэг ойлгож байна? 3. Та
өдөрт хэдэн шинэ үг тогтоодог вэ? 4. Та өдөрт нэвтрүүлэг
хэзий хугацаагаар сонсдог вэ? 5. Хэлийг яаж сайн сурч бо-
лох вэ? 6. Хэл сурахад юу хэрэгтэй вэ? 7. Таны өдрийн
ажил ямар байх ёстой вэ?

Запомните:

«Өсөхөөс сурсан үндсэн хэл мартаж болонгүй соёл» Д.
Нацагдорж

Дома: Используя словарь, напишите содержание этого
высказывания на русском языке и проверьте его с препода-
вателем.

Упражнение 2. При списывании вместо точек вставьте пропущенные
слова и выражения. Прочитайте текст 7-8 раз и запомните его.

1. Хэл сурахад ... хэрэгтэй. 2. Би өдөрт ... сонсдог. 3. ...
монгол хүнтэй ... ярихыг хичээдэг. 4. Хэл сурахад зөвхөн ...
болохгүй. 5. Хэл сурахад ... хэрэгтэй ... бас чухал. 6. Үг ...
заавал ... хичээх хэрэгтэй. 7. Их зохиолч Д. Нацагдорж ...
гэж хэлсэн байна.

Упражнение 3. Поговорите между собой.

— Чи өглөө хэдэн цагт босдог вэ?

— Би өглөө 6 цагт босдог. Манайх сургуулиас хол бай-
даг. Дараа нь биеийн тамирын дасгал хийж, гар нүүрээ
угаагаад цайгаа ууна.

— Чи ямар ангид сурдаг вэ?

— Би орос хэлний ангид сурдаг. Орос хэл бол сурахад
хэцүү хэл юм.

— Хүнд гадаад хэл (человеку иностранный язык) сура-
хад хэцүү санагддаг юм. Гэвч хэлийг сурч болно.

— Тиймээ, хэл сурахад уйгагүй их хөдөлмөр, тогтмол
ажиллагаа хэрэгтэй.

— Хэл сурахад бас нэг сайн арга бол их унших явдал
мөн.

— Үнэхээр (в самом деле) их луншвал хэл сайн сурч
болно шүү.

— Энэ орос өгүүлбэрийг хоёулаа орчуулъя! Сколько
знаешь иностранных языков, столько раз ты человек!»

— Ингэж хэн хэлсэн юм бол? Монголоор юу гэж орчуу-
лах вэ?

Упражнение 4. Дома напишите сочинение на тему «Мой рабочий день» Покажите его своему преподавателю.

Упражнение 5. Переведите на русский язык.

1. Би өдөржин монгол хэл үздэг (изучать). 2. Би монголоор уншиж, сонсож, бичдэг. 3. Хэл сурахын тулд их ажиллах хэрэгтэй. 4. Үгийг цөөн цөөнөөр бичиж, халаас (карманы), гар цүнх (портфель) зэрэгтээ авч яваад, өчүүхэн бага цаг гарахад нөгөө бичсэн зүйлээ хараад байж байдаг байвал их сайн. 5. Хэл сурах сайхан. 6. Хэл сурахад чинь амжилт хүсье.

Упражнение 6. Переведите на монгольский язык.

1. Я изучаю монгольский язык. 2. Монгольский язык-красивый язык. 3. Для того, чтобы хорошо выучить язык, надо очень много работать. Все нужно сочетать: писать, читать, слушать и слышать. 4. Слова нужно запоминать в контексте. 5. Изучающему язык нужны не только слова, но и грамматика. 6. Желаем успеха в изучении языка.

Упражнение 7. Вспомните о своем рабочем дне. Затем, используя словарь, напишите об этом 10 предложений.

Упражнение 8. Прочитайте текст 3 раза. Переведите текст.

ААВЫН ЗАХИАС

Сүрэн 10 жилийн сургуулиа төгсгөөд цаашид эрдэм сурахаар Монгол Улсын Их Сургуулийн монгол хэлний ангид хуваарилагдан явахад аав нь:

— За, хүү минь, «Аавын бийд хүнтэй танилцаж, агтны бийд газар үз» гэсэн юм. Манай хуучуул «Эрхийг сурахаар бэрхийг сур» гэж ярьдаг. Үүнийг чи ойлгож байна уу?

— Ойлгож байна аа.

— Юу гэж ойлгож байна?

— Эрхэлж, ажил хийхгүй байж сурахаар, өөрөөр хэлбэл ингэж сурахын оронд бэрх байж сур, ажил хийж сур гэсэн сургаал байна.

— Зөв, хүү минь, зөв. Эрдэм сурваас бүх юмны учир тайлагдана. Эрдэм бол дээд баян гэсэн сургаал бий. Эрдэм их сурч, эх орондоо ирээдүйд хүчин зүтгэхээс илүү сайхан юм ер үгүй. Эрдмийг хичээлээр сурдаг. Залхуу хойрго зан эрдэм сурахын дайсан мөн—гэж захижээ.

Упражнение 9. Переведите на монгольский язык, используя словарь.

Позади три года двенадцатой пятилетки. Это были хорошие годы. Многое удалось сделать. Многое изменилось к лучшему. Советский народ, партия живут напряженной, насыщенной жизнью, настойчиво работают над выполнением

социально-экономической программы, выдвинутой XXVII съездом КПСС.

Упражнение 10. Переведите на русский язык.

Ц. Дамдинсүрэн.

МИНИЙ СЭТГЭГДЭЛ

Номын утга нь тэнгэр мэт агуу, дэлхий мэт өргөн, далай мэт гүн юм.

Номыг унших нь тэнгэрт нисэж, дэлхийг тойрч, далайд шумбах мэт.

Зохиогчтой уулзах нь нартай тунгалаг өдөр цэцэгт өргөн талаар, үлгэрийн сайхан дагинатай зугаалах мэт.

Зургийн цэцгийг үзэхэд сайхан боловч, амьд цэцгийг үзэх нь түүнээс илүү сайхан байдаг.

Цаасан дээр бичсэн юмыг уншихад сонин боловч, номыг зохиосон хүнтэй уулзах нь түүнээс илүү сонин байна...

1958 он

Новые слова

сэтгэгдэл	— впечатление
утга	— содержание; смысл, значение.
мэт	— словно, точно, как, подобно; подобный
агуу	— великий, огромный, обширный
нисэх	— летать, лететь
тойрох	— обходить (объезжать) вокруг чего-либо; окружать
шумбах	— нырять; погружаться в воду
зохиох	— создавать, творить; сочинять
үлгэр	— сказка; пример, образец,
зураг	рисунок; картина; снимок
амьд	— живой, одушевленный
цаас (ан)	— бумага, бумажные деньги (перен.)

Упражнение 11. Переведите на русский язык.

МЭДНЭ, МЭДНЭ...

(Селонгас ардын шог үлгэр)

Өвгөн эмгэн хоёр аж төрөн суудаг байжээ. Тэд тохитой улс боловч хүний хэлсэн үгийг бүрэн гүйцэд сонсолгүй, юм

л бол «мэднэ, мэднэ...» гэж ам булаалдан өгүүлдэг байлаа. Нэг өдөр тэднийд нэг хүн ирээд тэрлэг үзүүлж:

— Энэ тэрлэгийг өмсөөд нэг товчийг нь товчилбол газраас нэлээд дээш дэгдэнэ. Хоёр дахь товчийг нь товчилбол тэнгэрт нисэж очно гэж хэлэв. Өвгөн энэ үгийг сонсмогц тэнгэрээс эргээд яаж буухыг лавлалгүй «мэднэ, мэднэ...» гэж өгүүлээд өнөөх тэрлэгийг өмсөж бүх товчийг нь товчлон тэнгэрт нисжээ. Эмгэн өвгөнөө харуулдан тал бүр тийш хашхиран гүйж:

— Хараач! Хараач! Өвгөн маань нисэж явна! гэж тэнгэр өөд өлөлзөн гүйсээр ёроолгүй нүхэнд унасан ажээ. Тэр цагаас хойш өвгөн нь харцага, эмгэн нь загас болсон юм гэж ярилцдаг гэнэ.

Новые слова

өвгөн	— старик
эмгэн	— старуха
улс	— люди
бүрэн	— полностью, всё
уралдах	— состязаться
ам булаалдан	— наперебой
тэрлэг	— летний халат
өмсөх	— надевать (что-либо)
товч	— 1/ пуговица 2/ краткий
товчлох	— 1/ застегивать (пуговицу) 2/ конспектировать (доклад)
нэлээд	— значительно, довольно
дэгдэх	— взлетать, подниматься
сонсмогц	— как только услышал
буух	— спускаться, сходить
лавлах	— осведомляться
өнөөх	— этот (тот) самый
харуулдах	— поджидать
хашхирах	— кричать (многократное)
гүйх	— бегать
өлөлзөх	— задирать голову
ёроол	— дно
нүх (эн)	— дыра, отверстие
унах	— 1/ падать 2/ ездить верхом
харцага	— ястреб

Упражнение 12. Переведите пословицы и фразы на русский язык.

1. Агт алдвал барьж болдог
Ам алдвал барьж болдоггүй

2. Мод хэдийгээр өндөр боловч
Үндэсгүй бол ургахгүй
Хүн хэдийгээр мэргэн боловч
Сургаалгүй бол болохгүй
 3. Хүнд тус хийвэл
Өөрт тус болно
 4. Давс шорвог боловч
Идээний амтад тустай
 5. Мэдье гэвэл сурах хэрэгтэй
Сурья гэвэл сонсох хэрэгтэй
 6. Бэлчээр сайтай бол мал тарган
Бэх сайтай бол бичиг тодорхой
 7. Хүний дотор баясгалантай болбол, юутай сайхан
Хүний дотор зовлонгүй болбол, юутай сайхан
- (Д. Нацагдорж, «Эрүүл» 1935 он)

8. Жаргалиг хүсвэл
Эрүүлийг хүс.
Эрүүлийг хүсвэл
Эмнэлгийг хүс
- (Д. Нацагдорж «Эрүүл ба жаргал», 1935 он)

Упражнение 13. Переведите на монгольский язык.

1. Если Вы освободитесь, не пойти ли нам в театр? Недавно вышла очень интересная пьеса (жүжиг) о молодежи.
2. Если вы хотите почитать книгу советского писателя, переведенную на монгольский язык, купите ее в магазине «Дружба».
3. Если Вы не встретите делегацию сегодня вечером, не зайдете ли к нам? Наша семья будет очень рада (баярлах) с Вами снова увидеться.
4. Здравствуйте! Если Вы меня забыли, я могу напомнить (сануулах) свое имя.
5. Если вы не повторяете новые слова ежедневно, вы не сдадите (өгч чадахгүй) хорошо экзамены.
6. Если Вы хотите поступить на работу (ажилд орох), идите в отдел кадров (боловсон хүчний хэлтэс), который находится на втором этаже.
7. Я хочу разыскать в парке (цэцэрлэг) то интересное дерево, о котором Вы рассказывали. Если Вы освободитесь, не пойти ли вместе?
8. Если Вы его не извините, Вы сделаете ошибку. Он Вас очень уважает (хүндэтгэх).
9. Если она не пойдет на вечер (үдэшлэг), я тоже не пойду.
4. Лошадь вообще-то тоже прекрасный вид транспорта.
5. Сейчас в нашу жизнь

вошел (внедрился) еще один транспорт-мотоцикл. 6. В сельской местности на мотоциклах стали разыскивать заблудившийся скот. 7. Таким образом, лошадь и верблюд перестали быть главным транспортом монгола. 8. В Улан-Баторе главный вид транспорта-это автобус. 9. В автобусе мы платим 50 монгу. 10. В любой конец города ходит маршрутное такси. 11. Такси мы называем «пёстрой лошадкой». 12. В Москве много различных видов транспорта. 13. В автобусе мы платим 5 копеек, в троллейбусе-4 копейки, в трамвае - 3 копейки. 14. Метро-быстрый, прекрасный транспорт. Зимой (там) тепло, летом прохладно. 15. Троллейбус очень удобный вид транспорта в ваших условиях. 16. Я хочу съездить в падь Зайсана. Где автобусная остановка? 17. Остановка автобуса рядом с гостиницей. Идите прямо. 18. Давайте поедem на такси!

Упражнение 2. Переведите на монгольский язык:

1. Как вы переводите слово «пересадка»? 2. Вы (ведь) не различаете два слова «приехал» «пришел»? -Да. Мы говорим одинаково: «Я пришел (с улицы) «и» Я приехал (из Москвы)». 3. — Когда (в какие моменты) вы употребляете глаголы с окончаниями «-гтун», «-сугай»? «В разговоре почти не употребляем. Обычно употребляем в письме. Глаголы с такими окончаниями встречаются в постановлениях, решениях и т. д. 4. Одно время слово «пролетарии» переводили как «неимущие». Сейчас слова, подобные этому, почти забыты. 5. — А «социализм» и «коммунизм» тоже переводили? 6. — Да. А сейчас слово-«эв хамт» осталось только в выражении «Манифест Коммунистической партии».

Упражнение 3. Переведите на русский язык, используя словарь:

Бүх нийтийн энх тайван, улс түмний найрамдлыг бэхжүүлэх үйл хэрэгт Монголын энх тайван, найрамдлын байгууллагууд, тэдгээрийн гишүүд, идэвхтнүүдээс оруулж байгаа хувь нэмрийг өндрөөр үнэлж, Монголын энх тайван, найрамдлын байгууллагуудын холбоог үүсэн байгуулагдсаны нь 20 жилийн ойг тохиолдуулан «Алтан гадас»- одонгоор шагнасугай.

Упражнение 4. Переведите на русский язык, используя словарь

ТӨГСГӨЛ

(уран сайхны кино зохиол)

Зөвлөлт орос улсын өргөн нутгийн баруун талаас нь зүүн тийш зурваслан харагдах төмөр замын хил дээрх нэгэн өртөг.

Галт тэрэгний цуваамы нэгэн вагоны өрөөнд сууж явсан үл мэдэгдэх нэгэн зорчигч дээр хилийн хоёр-цэрэг орж ирж хүмүүсийн хил нэвтрэх пиу бичгийг шалган үзнэ.

— Та ноён Лорс уу? гэж тэрхүү үл мэдэгдэх хүнээс хилийн цэргийн нэг нь асууна.

— Тийм ээ.

Тэд тэр хүний пиу бичгийг үзээд:

— Та францын харьяат юм уу?

— Тийм ээ.

— Харбин явж байна уу?

— Тийм ээ.

— Энэ бичгээ авагтун. Сайн яваарай! гээд цэргийн тэр хоёр хүн гарч одов.

Галт тэрэгний цуваа аажмаар цааш хөдлөхөд зэргэлдээ өрөөнд явсан гурван зорчигч Лорсын өрөөнд орж ирээд түүний нэг нь барьж явсан торон саваа хажуудаа тавилаа. Нөгөө нэг нь Лорсын хажууд сууна. Гурав дахь нь цонх уруу харж замын хажуугаар тохиолдсон юмыг ажиглана.

— Хил хүртэл хэчнээн хэмжээний газар үлдсэн бэ? гэж тэр орж ирсэн гурвын нэг нь асуув.

— 5 км хэртэй үлдлээ гэж нөгөө нь хэлэв.

— Одоо дахиад өртөө тохиолдох уу? гэж нэг нь асуухад

— Үгүй гэж нөгөө дэх нь хариулав.

Лорс сууж байсан байршаасаа босож өрөөнөөс гарахыг завдана. Түүний өрөөнд орж ирсэн нөгөө гурван хүний тор барьж ирсэн нь хөлөө үл мэдэгдэхүйц хөдөлгөн Лорсын явах зам уруу сэлүүлэн тавина. Лорс-тэр-хүний хөлд тээглэж унах зуур нуруугаараа эргэн гадуур цамцныхаа халааснаас гар буу гарган, дэгээдэж унагах гэсэн хүн уруу зангахад Лорсын өрөөнд орж ирсэн хүний нэг нь Лорсыг барьж авна. Ингээд тэр өрөөнд нэлээд үймээн болж бие биеэ хараан зүхэж занаж буй дуулдана. Галт тэрэг ч алгуурхан зогсоно. Лорстой ноцолдсон хүн түүний барьж явсан гар бууг булаан авч халаасандаа хийгээд босон ирж:

— Циркийн наадам хийхээ больё. Сомов миш! явцгаая гэв...

Упражнение 5. Переведите на русский язык.

Английн агаарын тээврийн нэг компанийн ерөнхийлөгч, жинхэнэ африкийн тоть Африкаас авчирч өгөхийг нэг нисэгчээсээ гуйсанд маш сайхан тоть авчирч өгчээ. Гэвч «Нисэгчдийн цалинг яаралтай нэмэгдүүлэгтүн!» гэж тэр золигийн шувуу бүтэн өдөржингөө хашхирдаггүйсэн бол ч ёстой л бүх юм ёсоороо байхсан хэмээн ерөнхийлөгч найздаа гомдон ярьсан гэнэ.

Упражнение 6. Составьте предложения со следующими словами и выражениями:

Эндээс ...хүртэл 5 зогсоол байдаг, метрогоор явбал дээр, ... аас асуух, автобусанд суух, автобусаар явах, автобусаас буух, дэргэд троллейбусын зогсоол байдаг, дараагийн буудал ямар буудал, буух уу, гарах, билет ямар үнэтэй, билет авах, энэ мөнгийг дамжуулж өгөөч, хаана байна зааж өгнө үү, такси дуудах, такси авах, буцах билет, (нисэх) онгоцны буудал дээр очих, нисэх онгоцоор нисэх, бидний суусан онгоц газраас тасарлаа (агаарт хөөрлөө),...оор явахад таатай байдаг, сайн яваарай, сайн сууж байгаарай, онгоцонд сайн явлаа, нисэх онгоцны буудал дээр буух, галт тэргээр явах илүү дуртай, тийшээ өдөр бүр галт тэрэг явдаг, сургуульдаа явахдаа ямар унаагаар явах, хөдөө явах, чамд задгай мөнгө бий юү, дараагийн буудал дээр буух.

Упражнение 7. Расскажите о московском транспорте (метро, автобус, троллейбус, трамвай, такси).

Упражнение 8. Переведите на русский язык, используя словарь:

1. Тээвэр, холбооны байгууллагын ажилчин, ажилтан нар аа! Машин техникийн ашиглалтыг сайжруулан, улс ардын аж ахуй, хүн амд үйлчлэх хариуцлагатай, хүндтэй үүргээ нэр төртэй биелүүлэгтүн!

2. Үйлчилгээний хөнгөн шуурхай, соёлч боловсон байдлыг эрс дээшлүүлэгтүн!

3. Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн малчид, тариаланчид, мэргэжилтэн нар аа! Мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах, ашиг шимийг нэмэгдүүлэх, тариаланг хөгжүүлэх талаар МАХН-ын дэвшүүлсэн зорилтыг бүрэн биелүүлэхийн төлөө нөөц бололцоогоо дайчлан ажиллагтун!

4. Мал сүрэгт тарга хүч сайн авахуулах, арвин их тэжээл бэлтгэх, мал аж ахуйн өвлийн бэлтгэлийг бүрэн хангахын төлөө шаргуу тэмцэгтүн!

5. Тариа, ногоог агротехникийн шаардлагын дагуу арчлан хамгаалж арвин их ургац хураан авах нөхцөлийг хангагтун!

6. Ардын эрүүлийг хамгаалах, биеийн тамир-спортын байгууллагын ажилтан нар аа! Эмнэлэг, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг дээшлүүлэн, ард иргэдийн эрүүл энхийн төлөө ариун үйлсэд хүч, мэдлэгээ зориулагтун!

7. Биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх, түүний материаллаг баазыг бэхжүүлэхийн төлөө тэмцэгтүн!

8. Соёл, урлаг, хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан нар аа! Намын нийтэм-эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөрчдийн ёс суртахуун, гоо сайхны хүмүүж-

лийг дээшлүүлэхэд соёл, урлаг, утга зохиол, хэвлэл, мэдээллийн байгууллагын ажлын үр нөлөөг дээшлүүлэгтүн!

9. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг тэргүүн туршлага дэлгэрүүлэх индэр болгохын төлөө чармайн ажиллагтун!

10. Ардын Армийн яруу алдарт дайчид аа! Байлдааны болон улс төрийн бэлтгэл, сонор сэрэмжээ ямагт өндөр байлгаж, цэргийн орчин үеийн зэвсэг техникийг чадамгай эзэмшигтүн!

11. Шинжлэх ухааны байгууллагын эжилтэн, эрдэмтэн нар аа! Шинжлэх ухаан үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлж, шинжилгээ, судалгааны ажлын үр ашгийг дээшлүүлэн, түүний ололт, нээлтийг улс ардын аж ахуйд өргөн нэвтрүүлэгтүн!

Упражнение 9. Переведите на монгольский язык.

А. Я хочу (хотел бы).

1) доехать до вокзала без пересадки, 2) посмотреть московское метро; 3) поехать в музей изобразительных искусств; 4) отдохнуть немного перед отъездом; 5) переодеться (сменить одежду) и выпить чаю; 6) встретиться с советником посольства; 7) почитать выступление помощника президента; 8) показать вам одну интересную вещь; 9) разыскать одного из своих друзей; 10) позвонить ему сейчас по телефону; 11) написать письмо своим родителям; 12) поговорить с работником этого отдела; 13) отправить своей старшей сестре телеграмму; 14) остаться здесь до октября; 15) встретить их в аэропорту; 16) немного поплавать перед обедом; 17) покататься на лыжах в воскресенье; 18) поехать на маршрутном такси; 19) посмотреть скачки и стрельбу из лука; 20) пойти в театр оперы и балета.

Б. 1. Родители получили за год всего лишь два письма. 2. По дороге нам встретился молодой солдат. 3. В комнате стоял только один стул. 4. Быстренько одевайся и выходи! 5. На улице тепло и солнечно. 6. Давай посидим немного! Здесь прохладно.

Упражнение 10. Переведите на монгольский язык.

1. Дождь перестал идти. 2. Ребенок перестал плакать. 3. Они перестали встречаться. 4. С завтрашнего дня я прекращаю тут работать. 5. Они прекратили розыски. 6. Перестань думать об этом! 7. Прекратите смеяться! 8. Оюун перестала нам звонить. 9. Снег перестал идти. 10. Тебе нужно перестать курить. 11. Прекрати читать (книгу)! 12. Ему нужно перестать пить. 13. Перестаньте насмехаться! 14. В последнее время мы перестаем так говорить.

Упражнение 11. Переведите на монгольский язык.

1. У них нет другого выхода, кроме как заплатить (деньги). 2. Иначе, чем «вручить», не переведешь. 3. Иначе, чем так, не скажешь. 4. Мне ничего не оставалось сделать, кроме как уйти. 5. Кроме как сделать пересадку-нет другого выхода. 6. Иначе, чем «поменять транспорт», не скажешь. 7. Кроме как запрячь оленей-нет другого выхода. 8. Нам ничего не оставалось сделать, кроме как заночевать в том аиле. 9. Болду ничего не оставалось сделать, кроме как **согласиться выступить**. 10. Кроме как ждать-нет другого выхода. 11. Мне ничего не оставалось сделать, кроме как пойти с ним в театр оперы и балета. 12. Кроме как объединиться-нет другого выхода. 13. Детям ничего не оставалось сделать, кроме как пойти пешком. 14. У тебя нет другого выхода, кроме как извиниться. 15. У Вас нет другого выхода, кроме как купить эти цветы. 16. Мне ничего не оставалось сделать, кроме как ехать на троллейбусе. 17. Кроме как послать телеграмму-нет другого выхода.

УРОК 16

ИХ ДЭЛГҮҮРТ

— Сайн байна уу! Би Танаас нэг юм асууя. Их дэлгүүр нь хаана байдаг вэ?

— Та энэ гудамжаар шууд яваад байтал чинь баруун гар талд чинь их өндөр байшин байгаа. Дээр нь «Их дэлгүүр» гэж бичээстэй байгаа.

— Танд их баярлалаа. Баяртай.

— За, баяртай.

ДЭЛГҮҮРТ

— Сайн байна уу, худалдагч аа!

— Сайн Та сайн байна уу?

— Танай бэлэн хувцасны тасаг хэдэн давхарт байдаг вэ?

— Бэлэн хувцасны тасаг дөрөвдүгээр давхарт. Та шууд дээшээгээ гар. Цахилгаан шатаар явсан ч болно.

БЭЛЭН ХУВЦАСНЫ ТАСАГТ

— Сайн байна уу, худалдагч аа!

— Сайн, Та сайн уу?

— Би монгол дээл авах гэсэн юм. Байна уу?

— Монгол дээл бий, бий. Та өөрөө ороод үз. Та ямар өнгөнд дуртай вэ? Манайд хүрэн, хөх, ногоон торго дээл, саарал даавуун дээл, шар чигчүүн дээл байна.

— Би ч цэнхэр л өнгөнд дуртай хүн юм даа. Танайд үйтэнхуар дээл байна уу?

— Одоогоор дуусаад байна. Гурав дөрөв хоноод ирвэл ч байна даа.

— Энэ хөх дээлийг чинь өмсөөд үзэж болох уу?

— Бололгүй яах вэ, үз, үз.

— Танд өмсөхлөөр бага ч юм шиг.

— Харин ээ, бүслэхээр бүр ч бага болох болов уу?

— Жаахан оосойж магадгүй. Харин энэ хүрэн дээл овоо урт юм шиг байна. Та өмсөөд үз.

— За, тэгье.

— Тэр шүү. Их сайхан таарч байна. Сайхан ч зохиж байна.

— За, үүнийг чинь авъя, ямар үнэтэй вэ?

— 175 төгрөг (Зуун далан таван).

— За, май, талоноо.

— За, дээлээ ав (Боож өгнө).

— Баярлалаа, худалдагч гуай. Бэлэг дурсгалын тасаг аль вэ?

— Доошоо буунгуут бий.

БЭЛЭГ ДУРСГАЛЫН ТАСАГТ

— Сайн байна уу, Та.

— Сайн. Та сайн уу?

— Энэ зааны ясан сийлбэрээс өөр сийлбэр байна уу?

— Модон сийлбэрийн шатар байна.

— Энэ баг чинь ямар үнэтэй юм бэ?

— Том нь арван долоо, жижиг нь найман төгрөг.

— Аль кассанд бичүүлэх вэ?

— Тэр буланд байгаа кассанд бичүүл.

— Баярлалаа.

КАССАНД

— 17 (арван долоон) төгрөг.

— Аль тасаг дээр бичих юм бэ?

— Бэлэг дурсгалын тасаг дээр.

— За, май.

— Баярлалаа.

* * *

— Худалдагч аа! Биений тамирын бараа худалддаг тасаг аль вэ?

— Таван давхарт, зүүн талдаа.

— За, баярлалаа.

Биеийн тамирын барааны тасагт

— Сайн байна уу, худалдагч аа!

— Сайн, та сайн байна уу?

— Танайд хэд хэдэн ноймрын тэшүүр байна?

— Гучин долоо, гучин ес, дөч, дөчин нэгэн ноймрынх байна.

— Тэшүүр чинь шаахайтай юу?

— Шаахайтайгаа, хадаастай ч бий. Эсвэл шаахайгий нь хаддаг газарт хадахлаар нь ч авч болно.

— Шаахайтай гучин есөн ноймрыг авъя!

— Тэг, тэг, жаран зургаан төгрөг бичүүл!

— За, баярлалаа

— Май, талоноо!

— За, май, 39 ноймрынх.

— Баярлалаа, баяртай.

— Баяртай.

Слова и выражения

шууд	— 1) прямо, непосредственно, 2) прямой
баруун гар талд	— справа, на правой стороне
бичээстэй	— написано
бичээс	— надпись
бэлэн	— готовый, приготовленный
хувцас (ан)	— одежда, платье
тасаг	— 1) отдел, секция, цех 2) комната (в общежитии)
дээшээ	— наверх, вверх
цахилгаан шат	— лифт
дээл	— деля, халат, шуба
өнгө (н)	— цвет
хүрэн	— коричневый
торго (н)	— 1) шелк, 2) шелковый
саарал	— серый
даавуу (н)	— 1) простая хлопчатобумажная ткань 2) материя, ткань
шар	— желтый
чисчүү (н)	— 1) чесуча, 2) чесучевый
үйтэнхуар	— род червленого бархата
дуусаад байна	— кончились (здесь: в продаже)
өмсөөд үзэх	— примерить, померить
өмсөх	— надевать (что-либо)

бүслэх	— опоясывать, подпоясываться
бүс (эн)	— пояс, кушак
оур	— ...3) усилительная частица еще, даже; совсем, вполне, совершенно
оосойх	— быть коротковатым
(...ж) магадгүй	— может быть, возможно, вероятно
урт	— 1) длинный, долгий
	2) длинно, долго
	3) длина, долгота
таарч байна	— сидит подходит (об одежде)
таарах	— годиться, быть впору, подходить
зохиж байна	— идёт (об одежде)
үнэ	— цена
талон (толоон)	— чек
боож өгөх	— завертывать
боох	— завязывать, перевязывать, бинтовать. обвертывать, упаковывать
бэлэг дурсгал	— сувенир
зааны ясан сийлбэр	— резьба по слоновой кости
заан	— слон
яс (ан)	— 1) кость, скелет, 2) костяной
модон	— здесь: по дереву
шатар	— шахматы
баг	— маска
жижиг	— маленький, мелкий
өнцөг	— угол
биенийн тамирын	— спортивный
бараа (н)	— товар
худалдах	— торговать, продавать
тэшүүр	— коньки
шаахай	— ботинки, тапочки
хадаастай	— прикрепленный, прибитый, пришитый
хадаас (ан)	— 1) гвоздь, 2) прибивка (чего-либо)
хадах	— прибивать, приколачивать, пришивать

Запомните пословицу:

Уул үзээгүй байж хормой шуух
Ус үзээгүй байж гутал тайлах
Не видя горы, поднимать подол
Не видя воды, снимать обувь

ПОСЛЕДОВАТЕЛЬНОЕ ДЕЕПРИЧАСТИЕ

Дагалдах нөхцөл үйл үг

Суффиксом этой формы является **-хлаар** (**-хлээр**, **-хлоор**, **-хлөөр**):

Последовательное деепричастие выражает такое действие, вслед за которым наступает другое. По своему значению эта форма близка к предварительному деепричастию, но отличается от него тем, что.

1) Между действием последовательного деепричастия и каким-либо вторым действием возможен больший или меньший интервал.

2) Возможно наступление второго действия тогда, когда действие последовательного деепричастия ещё не кончилось.

Таково теоретическое различие между формами **на-хлаар** и **на-магц**, однако в речи это различие не всегда ощутимо.

Последовательное деепричастие на русский язык можно переводить оборотами «Вслед за...», «После того, как...», «Как только...» «С...» и т. п. **Например:**

1. Танк **явахлаар** явган цэрэг хөдлөв. — Вслед за танками двинулась пехота.

2. Чамайг **явахлаар** бид явна. — Вслед за тобой пойдем мы.

3. Өглөөний хичээл дуусах**лаар** оройн сургууль эхэлнэ. — По окончании утренних занятий начнутся занятия вечерней школы.

4. Ахыг **явахлаар** чи ирээрэй! — Как только уйдет брат-приходи!

5. Хүйтэн болох**лоор** өвөлжөөндөө бууна. — С наступлением холодов переедем на зимовку.

6. Нар гарах**лаар** хоёулаа явна. — С восходом солнца отправимся вдвоём.

7. Намайг хөдөө **явахлаар** чи тэр дарга дээр очоорой! — После моего отъезда в худон ты сходи к тому начальнику!

8. **Явахлаараа** хэлээрэй! — Будешь уходить (уезжать) — скажешь!

9. Буцах**лаар** чинь уулзана! — Вернешься-увидимся-

10. Өвөл болох**лоор** цанаар гулгана. Наступит зима-покатаемся на лыжах.

11. Зун болох**лоор** амарна. Наступит лето-отдохнем.

12. Ажил дуусах**лаар** Сүхбаатарын талбайд уулзана. — По окончании работы встретимся на площади Сухэ-Батра.

ПОПУТНОЕ* ДЕЕПРИЧАСТИЕ

(Далимдах нөхцөл үйл үг)

Попутное* деепричастие имеет суффикс **-нгуут** (**-нгуут** и выражает 1) либо действие, к моменту завершения (или в момент совершения) которого наступает другое) т. е. или конец первого действия по времени совпадает с началом второго действия, или второе действие совершается попутно);

2) либо действие, после которого сразу же наступает второе действие (в таком случае это деепричастие может быть заменено формой на **-магц**).

На русский язык форма на **-нгуут** переводится оборотами «Пока...», «Не успел...», «как...», «Только...», «Как только...», «Сделав что-то...» и т. п. **Например:**

1. Ирэнгүүтээ л явах гэж дээ. — Не успел придти (только пришел) -нужно уходить.

2. Дорж намайг харангуутаа танилаа. — Дорж сразу (букв.: взглянув...) узнал меня.

3. Надтай уулзангуутаа «Баяр хүргэе!» гэж тэр хэллээ. — Встретившись со мной, он сказал: «Поздравляю!».

4. Гэртээ ирэнгүүт захидлаа уншлаа. — Придя домой, прочёл письмо.

5. Чиний дууг сонсонгуут их баярлав. — Очень обрадовался, услышав твой голос.

6. Морийг услангуут хамаг бие нь хөлөрчээ. — Пока поил коня, все его тело покрылось испариной.

7. Багшийг орж ирэнгүүт сурагчид босдог. — С приходом учителя ученики (обычно) встают.

Примечание. В монгольском языке есть еще одно «Попутное» деепричастие- «Дашрамдах» нөхцөл үйл үг, -выражающее действие, попутно, заодно с которым совершается действие управляющего глагола. Суффиксом этой формы является **-нгаа** (**-нгээ**, **-нгоо**, **-нгөө**). «Дашрамдах нөхцөл үйл үг» употребляется очень редко, так как эту форму можно заменять будущим причастием в дательном падеже. **Например:**

1. Би морь услангаа түлш түүгээд ирнэ (=Би морь усладаа түлш түүгээд ирнэ). — Пока пою лошадей-наберу топлива.

2. Чи хот оронгоо Сүхийнхээр ороод ирээрэй! (=Чи хот орохдоо Сүхийнхээр ороод ирээрэй!) — По пути в город навести (семью) Сухэ!

Упражнение 1. Составьте диалог на тему «В магазине».

Упражнение 2. Переведите текст. Прочитайте 5—6 раз. Запомните.

Дэлгүүрийг монголоор бас хоршоо гэдэг юм. Хоршоо гэдэг нь аман ярианд гол төлөв тохиолдоно.

Үүнийг юу гэдэг юм бэ? -гэж орос хүн асуухад Батаа «цаастай чихэр» гэдэг юм гэж хариулжээ. «Цаастай чихэр» гэдгийг орос болговол «сахар с бумагой» гэнэ. Гэтэл монгол хэлэнд орос хэлний «конфета» гэснийг оролдог «голио» гэж аятайхан үг бий. Монгол хэлний «чихэр», орос хэлний «сахар», украины «цукор» цөм ерөнхий нэг утгатай үг.

Дэлгүүрээс юм авахдаа «Би таван төгрөг кассанд төллөө» гэж ярих ёс бий. Гэвч «төлөх» гэдэг монгол үг «өр» (долг) гэсэн үгтэй сайн хоршино (хорошо сочетается). Харин энэ нөхцөлд бол «төлөх» гэдэг үйл үгийг хэрэглэх биш, «хураалгах» гэсэн үйл үгийг хэлбэл илүү тохиромжтой.

Упражнение 3. Переведите на русский язык.

1. — Энэ малгай Танд таалагдаж байна уу?

— Энэ малгай надад тун аятайхан санагдаж байна.

2. — Өмсөж үзэж болох уу? — Бололгүй яах вэ!

3. — Надад хэр зохиж байна?

— Миний бодоход энэ малгай Танд сайхан зохиж байна.

4. — Тэр (борооны) цув надад аятайхан санагдаж байна.

— Өмсөж үзэхгүй юм уу?

— Үзэлгүй яах вэ!

5. — Надад зохиж байна уу?

— Чамд сайхан зохиж байна.

6. — Энэ гутал чамд ямар санагдаж байна?

— Энэ гутал надад аятайхан санагдаж байна.

7. — Энэ пальто чамд таарч байна уу?

— Сайхан таарч байна.

8. — Энэ пальто чамд таалагдаж байна уу?

— Надад тун аятайхан санагдаж байна.

Упражнение 4. Переведите на монгольский язык:

1. — Мне очень нравится этот плащ. Не померить ли? — Конечно.

2. — Как он (на мне) сидит? — Очень хорошо сидит.

3. — Тебе нравится эта шляпа? — Да, эта шляпа мне очень нравится.

4. — Можно померить? — Конечно, можно!

5. — Мне идет? — по-моему, эта шляпа тебе очень идет.

6. — Тебе нравится это дэли? — Мне очень нравится.

7. — Мне идет это дэли? — Очень идет.

8. — Тебе нравятся эти туфли? — Да, очень нравятся.

Упражнение 5. Переведите на русский язык:

1. Сүрэнг явахлаар хоёулаа номын сан уруу очёе. 2. Зун болохдоор бид амралтад амарна. 3. Чи улс амьтан цөөрөхлөөр энд хүрээд ирээрэй. 4. Чи ирэнгүүтээ утастаарай. 5. Чи намайг ирэнгүүт утастаарай. 6. Намайг оронгуут л загнаж гарав. 7. Би оронгуутаа номоо уншиж эхлэв. 8. Ингэж хэлэнгүүт Бат гарч одов.

Упражнение 6. Переведите на монгольский язык:

1. Вслед за вами двинемся мы. 2. Вслед за тобой пойду я. 3. С восходом солнца отправитесь втроём. Приедешь-увидимся! 5. С наступлением весны птицы начинают петь. 6. С приходом учителя дети замолчали. 7. С наступлением холодов дачники разъехались. 8. С наступлением зимы мы начинаем кататься на лыжах. 9. С нашим приездом они прекратили работу. 10. С восходом солнца они встали, оделись и побежали в сад. 11. Как только Дулма вышла из комнаты, все переглянулись. 12. Будешь уезжать-скажешь! 13. После того, как отец приедет из Дархана, я отдам тебе деньги. 14. Наступит лето-будем отдыхать. 15. Станет меньше народу-приходи! 16. Учитель объяснит-поймёшь. 17. Прочтешь письмо-узнаешь.

Упражнение 7. Переведите на монгольский язык:

1. Не успел я войти-Цэрма начала ругать меня. 2. Не успели мы так сказать-раздался звонок в дверь. 3. Как только приедешь-позвони. 4. Как только я уйду-позовите их. 5. С приходом учителя все (обычно) встают со своих мест. 6. Не успели они выйти из комнаты-раздался телефонный звонок. 7. Придя домой, Баяр прочёл телеграмму. 8. Встретившись со мной, Лхагва сказал: «Рад Вас видеть». 9. Как только пришла мама, ушел отец. 10. Мунх сразу узнал меня. 11. Только погас свет (гэрэл унтрах)-начался спектакль. 12. Только я встал-они позвали меня. 13. Не успел Зориг придти-сразу начал читать. 14. Пока я пишу, Вы объясняйте. 15. Я буду писать эти предложения на доске и объяснять. 16. Услышав твой голос, дедушка очень обрадовался. 17. Не успели придти-нужно уходить. 18. При встрече со мной она спрашивает: «Как здоровье?»

Упражнение 8. Переведите на русский язык и выучите наизусть.

Ш. Цогт

ЦЭНХЭР ДЭЭЛ, ЦАГААН МАЛГАЙ

Цэнхэр дээл, цагаан малгай
Чиний өмсөх дуртай хувцас

Мэндлэн учрахыг мөрөөдөн хүсэгч
Миний нүдэнд дулаахан тусна.

Зугаа хөгжөө, цэнгэл баяслын
Зургаан сарын зун цагийн
Цэлмэг номин цэнхэр тэнгэр шиг
Цэнхэр дээл, цэнхэр дээл

Агаар тэнгэртээ чимэг болсон
Арван тавны тэргэл дугуй
Цалин мөнгөн цагаан сар шиг
Цагаан малгай, цагаан малгай.

Мэндлэн учрахыг мөрөөдөн хүсэгч
Миний нүдэнд дулаахан туссан
Чиний өмсөх дуртай хувцас
Цэнхэр дээл, цагаан малгай

Новые слова.

малгай
учрах

— шапка, головной убор
— 1) встречать, встречаться
(иметь свидание)

тусгах
зугаа
хөгжөө (н)
цэнгэл

2) случаться, приключаться
— попадать, падать, отражаться
— развлечение, веселье
— веселье, забава

баясал
цэлмэг
номин
тэргэл өдөр
тэргэл сар
дугуй

— 1) веселье, развлечение
2) наслаждение, блаженство
— радость, ликование, восторг
— ясный, чистый, безоблачный
— лазурит (минерал)
— пятнадцатый день лунного месяца
— полнолуние
— 1) круг, колесо, велосипед
2) круглый

Упражнение 9. Переведите пословицу на русский язык:

Өнгөрсөн бороонд
Цув нөмрөв

Упражнение 10. Переведите на монгольский язык:

1. — Скажите, пожалуйста, где находится ЦУМ? — Идите прямо и на правой стороне увидите высокое здание. Наверху написано «Центральный универмаг».

2. — Который отдел готовой одежды? — Этот отдел на третьем этаже. Идите прямо наверх. Можно и на лифте подняться.

3. — Спасибо. А где (который) отдел сувениров? — На первом этаже, слева.

4. — Мне бы хотелось купить дэли. Есть у вас? — Есть, есть. Пройдите, посмотрите сами. Какой цвет Вам нравится! У нас есть синие, зеленые, коричневые шелковые дэли, есть серые хлопчатобумажные и желтые чесучевые.

5. — Я люблю голубой цвет. У вас есть дэли из червленого бархата?

Только что кончилось. Приходите через два-три дня.

6. Можно примерить то синее дэли? — Конечно, можно! Примерьте.

7. Немного коротковато. Это коричневое дэли длиннее. Примерю-ка я его! — Прекрасно сидит (на Вас). И очень идет Вам.

8. — Ну, что ж, возьму это. Сколько стоит (Какая цена)? — Сто девяносто пять тугриков.

9. — Где (которая) ваша касса? — В том углу.

10. — Куда (где) пробить? — В отдел готового платья.

11. — Держите чек — Спасибо.

12. Заверните, пожалуйста. Спасибо. До свидания.

13. — Товарищ продавец! Где у вас отдел спортивных товаров?

— Еще выше. На 4-м этаже слева.

14. — У вас есть коньки с ботинками? — Есть сороковой и сорок первый номер.

15. — Покажите, пожалуйста, сорок первый номер. Я возьму. Сколько стоит? — Шестьдесят шесть тугриков.

16. — Скажите, пожалуйста, где находится отдел сувениров?

— Как только спуститесь вниз-увидите.

17. Сколько стоят эти маски? — Большая -семнадцать, а маленькая -восемь тугриков.

Упражнение 11. Переведите на монгольский язык.

А. 1. При встрече со мной Тумур спросил, иду ли я в театр. 2. Как только войдешь -(есть) большой светлый зал. Только спустишься -(есть) ресторан. 4. Как только я пришел домой -меня позвали. 5. Утром они только встали-сразу умылись-оделись. 6. Как только будет 12 часов погаснет свет. 7. Только мы вошли в юрту-хозяйка сказала: «Садитесь, пожалуйста, на почетное место (дэвшээ)». 8. Только Ульзийт меня узнал-направился ко мне (над уруу ирэх). 9. При встрече со мной он всегда спрашивает: «Что нового?». 10. Как только ты сказал-я сделал. 11. Учитель сказал-мы написали. 12. Не успела Цолмон закрыть дверь-раздался телефонный звонок. 13. С приходом директора все сразу

замолчали (прекратили свои разговоры). 14. Придя с работы домой, я перечитываю твоё письмо снова и снова.

Б. 1. Пока (= когда) пойшь лошадей-набери топлива! 2. Пока пасла овец-собрала аргал. 3. Пока разговаривала по телефону-убежало молоко (убежать молоко-сүү дэврэх). 4. По пути в город навести семью Шагдара! 5. По пути на родину заезжайте к нам! 6. Пока Дугар писал - (он) упокоился. 7. Пока я был дома - (я) всё приготовил. 8. Пока мы ехали в поезде - (мы) прочли эти рассказы. 9. Пока он ждал тебя - (он) всё обдумал. 10. Пока я жил у вас-я просмотрел все старые журналы. 11. Пока ты тут стоишь-понаблюдай за ними! 12. По пути к вам я встречу с Лувсанцэреном и возьму билеты. 13. Пока обедали-обсудили все вопросы.

Упражнение 12. Переведите на русский язык, используя словарь:

Д. Нацагдорж

ЦАГААН САР БА ХАР НУЛИМС

Арван нэгдүгээр оны хуучин улирлын арван хоёрдугаар сарын гучны өдөр тэнгэр цэлмэг, нар шарлан туссан үнэ хээр нэг сайхан өдөр байв.

Хойд уулын энгэрээр дун цагаан цас гилтгэнэн, түүний зах сэжүүр нь сэмэрч хайлан борлосныг харахад энэ өвлийн хүйтэнд онд орж ядсан эцэнхий туранхай үхэр малууд хөл дээр гарч, үүгээр түүгээр сүүлээ ширвэн явцгаадаг нь санагдаж, тэгсэм хүйтний илч хариад, хаврын сайхан улирал ирж байгаа нь мэдэгдэн, хэдийгээр тааламжтай сайхан боловч, малчин ардын бүсгүй Цэрмаа, Дагдангийн хаяанд зогсож, сэтгэлд их л гуныхралтайгаар элдэв зүйлийг бодмоглон урт урт шүүрс алдана.

Юу гэвэл, Цэрмаагийн нутаг Гурван сайханы өвөрт бий. Гэр ядуу тул эцэг эх нь түүнийг хотод илгээж, Дагдангийн зарцдуулан суулгасаар, гурван жилийн нүүр үзэж байгаа нь энэ. Дагдангийн ажил ихийг хэлэх үү, түүний эхнэрийн чангыг хэлэх үү, ирсэнээс хойш хэдэн жилийн дотор ер ч амарсангүй, бие сэтгэлийн зовлонг цадтал үзжээ. Энэ завсар Дагдангийн эхнэрийн таргалсан, Цэрмаагийн турсан хоёр яг тэнцэнэ. Ялангуяа ойрноос Цагаан сар болно гээд анхны хэдэн шөнө банш хийж, нойргүй хонов.

Дараах хэдэн шөнөө юм оёж, үүр цайлгав. Өнөө өдөр үүргэлэн нойрмоглож, бүхий бие зүдрэн галиравч, урьд нутагт байхдаа нйм нэг сайхан нар тусаж, уул талын цас хайлсан хаврын сайхан өдөр гэрийн хаяандаа сууж, сая төрсөн хэдэн хурга ишигтэйгээ наадан тоглож байсан нь

гэнэт санагдаж, гэр орон, эцэг эх, хөдөө нутгаа мөрөөдөн уйтгарлаж, сэтгэл нь хөдлөн байгаа нь энэ байжээ.

Гэтэл Дагдангийн эхнэр зургаан ханатай том гэгчийн цагаан гэрээс гарч ирээд, их л хүйтнээр хялайн харж, аягүйгээр зандран: «Чи яасан хар золиг вэ! Олбог хивсний шороо, тоосыг гүвээд ир гэхэд энд юугаа хийсэн муу монди вэ? Хашааны хог арилгасан чинь энэ үү? Маргааш Цагаан сарын шинийн нэгэн гэгчийг мэдэж байна уу, үгүй юу мал чин!» гээд туужуугаар нуруун дунд нь цохиж аваад, уурлан зогсоход Цэрмаа эсэргүүцэх аргагүй тул, «Толгой өвдөөд салхинд зогссон билээ, авгай минь» гээд хажууд байгаа том хивснийг авч, дааж ядан цасан дээр сэгсэрнэ.

Энэ үед ноднин жилийн бариулсан таван жангийн орос байшингийн цонхсоор Дагдангийн охин Мядагмаа гээг үсээ самнаж, нүүртээ оо энгэсэг түрхэн, бас л шинэ хийсэн бор ногоон торгон дээлээ тааруулан өмсөж байх нь үзэгдэнэ. Байшингийн дотор нсгэрэн дуулж, ийш тийш сэлгүүцэх бөгөөд цонхны салхивчийг нээж, Цэрмааг дуудан: «Айлчин ирвэл, зүүн тасалгаанд оруул!» гэж бас тушаал гаргана. Цэрмаа, Мядагмаагийн торгон дээлийн өнгөнд гялбахдаа өөрийн муу уранхай даавуу дээл уруугаа нэг хараад, Мядагмаагийн тэнхэлзүүр байдлыг өөрийн энэлэлт байдалтайгаа харьцуулан болож, нүднийхээ нулимсыг гилтгэнүүлсээр, гэдрэг одож, бас олбог дэвстэрийн тоос шороог гүвж шүүрдэхийн хамт, «Цагаан сарын өдөр манай гэрийн эзэд цөм сайхан торго дурдан дээл, булга минжин малтай хийж өмсөцгөөнө. Элдэв зүйлийн амтат идээ ба архи дарсыг төхөөрөн идэж ууцгаах нь ямар их жаргал вэ? Тийм байтлаа би юунд ингэж нойр дутуу, уранхай дээлтэй, энэлэн шаналан явна» гэж бодовч, нарийн учрыг олж эс мэдэн, гагцхүү «Мядагмаа хуучин дээлнээсээ нэгийг надад өмсүүлэх биз» гэж горьдоно...

1932 он.

УРОК 17

ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛС

(Советский Союз)

ЗХУ бол дэлхийн хамгийн хүчирхэг гүрний нэг бөгөөд 1917 онд Октябрийн хувьсгал ялан мандсанаар бүрэлдэн тогтжээ. ЗХУ-ын нийслэл Москва хот юм. Дэлхий дахинд дарлах, дарлагдах ёсыг устгаж, хамгийн шударга шинэ социалист нийгмийг анх бий болгож өгснөөрөө зөвлөлтийн ард

түмэн хүн төрөлхтний түүхэнд үүрд үл мартагдах гавьяа байгуулсан байна.

Энэ гавьяат үйлсэд дэлхийн хөдөлмөрчдийн их багш В. И. Лениний сруулсан хувь нэмэр асар их билээ.

В. И. Ленин бол шинжлэх ухааны социализм коммунизмын суут онолч, бүтээлч марксист туйлбартай хувьсгалч хүн байсан билээ.

Орос, Зөвлөлтийн ард түмэн дэлхийд олон зуун суут хүн төрүүлсэндээ бахархдаг. Шинжлэх ухааны аль ч салбарт зөвлөлтийн ард түмний дотроос дэлхийд нэрээ цуурайтуулсан эрдэмтэд үй олноороо бий. Зөвлөлтийн ард түмэн бол энх тайван найрамдлын бодлогыг тууштай баримтлагчид мөн. Хувьсгалын анхны өдөр агуу их Лениний гардан баталсан «Энх тайвны тунхагаас» эхлээд Зөвлөлт засгийн нам төрийн бодлого бол тууштай энх тайванч бодлого юм.

Зөвлөлтийн ард түмэн 20-р зууны түүхэн том үйл явдал болох Октябрийн хувьсгалыг ялан мандуулж, эх орны агуу их дайнд Зөвлөлт эх орноо Гитлерийн зандалчдаас тууштай хамгаалж, эдүгээ даян дэлхийд бат энх тайвныг гардан байгуулж байна. Энэ бүхнийг хараад тив дэлхийн эгэл түмэн баярлан бахдаж, социализм, нийгмийн дэвшил, аз жаргал, эрх чөлөөг тунхаглан зарлаж, хэрэгжүүлэн биелүүлэгч гэрэлт одон Москвагийн зүг халуун сэтгэлээ өргөж суудаг билээ.

Москва одоо дэлхийн шинжлэх ухаан-техникийн хувьсгалын манлайд явж байна. Сансрын уудамд анх зөвлөлтийн иргэн мөрөө гаргасан түүхтэйгээс гадна энэ бүхэн бол социалист байгуулалтын дотоод нөөц бололцоо хэчнээн арвин их, социалист байгуулалт хэчнээн давуу чадалтай болохыг илтгэн харуулж буй хэрэг.

Эдүгээ социализм ганц буюу хэд хэдэн орны хүрээнээс халин гарч, дэлхий дахинаа социалист бүхэл бүтэн систем аль хэдийнээ бүрэлдэн тогтоод социалист орнуудын хооронд эдийн засаг, соёл, шинжлэх ухааны хэлхээ холбоо урьд өмнө байгаагүйгээр ойртон нягтарсаар байна. Энэ их үйлсэд ЭЗХТЗ (Эдийн засгийн Харилцан туслах Зөвлөл)-ийн ажиллагаа онцгой байр суурь эзэлж байна.

Орчин үед нийгмийн өөр өөр байгуулалтай орнууд энх тайвнаар зэрэгцэн орших, зэвсэглэлийг бүх нийтээр нь хураах, дайн гаргуулахгүй байх, хамтран ажиллах харилцан тусалцах зэрэг дэлхий дахиныг хамарсан эдгээр гол асуудлын талаар ЗХУ-ын баримталж буй чиг шугам бол хамгийн зөв зүйтэй чиг шугам гэдгийг даян дэлхийн шударга иргэн бүр батлан хэлж байна.

Одоо дэлхийд энх тайвнаас өөр хэрэгтэй зүйл алга. Үүнийг хүн бүр ухамсарлаад зогсох биш бат бэх энх тайвны төлөө хүч зүтгэн дуу хоолойгоо нийлүүлэн тэмцэх хэрэгтэй.

Манай ертөнц дайны хар заналыг дахин үзэх ёсгүй. Эх үрсийн өнчрөл, янаг амрагийн хагацал болж, хорвоод гаслан зовлонгийн дуу цуурайтаж, хөдөлмөрч хүний гараар сүндэрлэн боссон хот балгас сүйрэх учиргүй.

ЗХУ эдүгээ энх тайван, шударга хүчний баг өмөг түшиг болж байна.

ЗХУ-аар удирдуулсан социалист хамтын нөхөрлөлийн бүх орнууд энх тайвны бодлогыг тууштай баримталж байгаагийн зэрэгцээ хоцрогдсон бага буурай орныг эрх чөлөө тусгаар тогтнолоо олоход нь зүйл бүрийн тусламж дэмжлэг үзүүлж байна. Энэ бол хамгийн шударга үйлс мөн.

Зөвлөлтийн ард түмэн бид социализм коммунизмын үйл хэрэг даян дэлхийд ялж, бат бэх энх тайван бүхний үйлс болно гэдэгт гүнээ итгэж байна.

Слова и выражения

хүчирхэг	— могущественный
гүрэн	— держава
мандах	— 1) восходить, подниматься 2) распространяться 3) расти, расцветать
бүрэлдэх	— формироваться, образовываться, составляться, складываться
тогтох	— 1) устанавливаться, образовываться 2) прекращаться, переставать; останавливаться
эгэл	— простой, рядовой, обыкновенный
дарлах дарлагдах ёс	— система угнетения, угнетение, гнёт
устгах	— уничтожать, ликвидировать
шударга	— 1) прямой, честный, справедливый 2) честно, справедливо
бий болгох	— создавать
өгөх	— ... 2) в сочетании с деепричастными формами выражает действие, совершающееся в пользу кого-либо, и переводится по значению деепричастия
хэлж эгэх	— говорить что-либо кому-либо (или для кого-либо)
хүн төрөлхтөн	— человечество
түүх (эн)	— 1) история; 2) исторический
үүрд	— навеки, навсегда, навечно, вечно
ул мартагдах	— незабываемый
гавьяа (н)	— заслуга, подвиг
гавьяа байгуулах	— совершать подвиг, проявлять доблесть
гавьяат	— заслуженный

үйлс	— совокупность всех деяний, дел, действий, поступков и деятельности человека (мн. ч. от «үйл»)
хөдөлмөрчин	— трудящийся
оруулах	— вносить (вклад, предложение, изменения, дополнения; вещи), вводить; ввозить; впускать; пропускать
хувь нэмэр	— вклад
асар их	— огромный
шинжлэх	— исследовать, изучать
ухаан	— 1) ум, разум; сознание 2) в счет обозначает «наука»
шинжлэх ухаан	— наука
суут	— гениальный
онолч	— теоретик
бүтээлч	— творческий, созидательный
хувьсгалч	— революционный; революционер
бахархах	— гордиться
салбар	— 1) отделение, часть чего-л., пункт 2) ветвь, отрасль
нэрээ цуурайтуулах	— прославлять свое имя
тууштай	— последовательный, решительный
баримтлах	— придерживаться, руководствоваться
баримтлагч	— сторонник, последователь
гардах	— делать что-л. своими руками
батлах	— 1) утверждать, ратифицировать 2) укреплять, скреплять
тунхаг	— манифест; декрет; объявление; оповещение; обнародование
төр	— строй, режим; государство; власть
бодлого	— политика; рассуждение; вычисление (мат.)
үйл явдал	— событие
дайн	— война
зандагч (ин)	— палач
хамгаалах	— защищать, оборонять; оберегать, охранять
даян дэлхий (дэлхий дахин)	— весь мир, земля
тив	— континент, материк
бахдах	— восторгаться, радоваться
нийгмийн дэвшил	— социальный прогресс
аз жаргал	— счастье
аз	— счастье, удача
эрх чөлөө	— свобода (полит.)
чөлөө (н)	— свободное время, досуг; отпуск

тунхаглах	— провозглашать; объявлять, обнародовать
зарлах	— объявлять, оповещать
биелүүлэх	— выполнять, исполнять
гэрэлт одон	— светоч
өргөх	— 1) поднимать (вверх). 2) возносить, возвышать (кого-л.)
манлайд явах	— идти в первых рядах, быть в авангарде
сансар	— космос
уудам	— широкое пространство, простор
мөрөө гаргах	— оставлять (свой) след
(...аас) гадна	— кроме, помимо, сверх того
дотоод	— внутренний
нөөц бололцоо	— потенциальные возможности
нөөц	— запасы, сбережения
арвин	— 1) обильный; 2) обильно
давуу чадал	— превосходство
илтгэх	— внести ясность, докладывать
харуулах	— показывать, демонстрировать
халин гарах	— выходить (за рамки)
халих	— 1) переливаться через край (посуды) 2) выходить из берегов (о реке)
хүрээ (н)	— рамки; круг; черта, предел; (перен) сфера влияния
хэдийнээ	— уже давно
хсооронд	— между
эдийн засат	— экономика
хэлхээ холбоо	— контакты, связи
ойртох	— близиться, подступать, приближаться, сближаться
нягтрах	— становиться тесным; уплотняться
ЭЗХТЗ (Эдийн засгийн харилцан туслалх зөвлөл)	— СЭВ (Совет экономической взаимопомощи)
ажиллагаа (н)	— деятельность
онцгой байр суурь	— особое место
эзлэх	— здесь; занимать
нийгмийн	— общественный, социальный
байгуулал	— строй
өөр өөр	— разные, различные
энх тайвнаар зэрэгцэн орших	— мирное сосуществование
зэвсэглэлийг (зэвсгийг бүх нийтээр (бүрэн хураах)	— всеобщее (и полное) разоружение

зэвсэг	—	оружие; орудие; инструмент
дайн гаргуулахгүй байх	—	предотвращение войны
хамтран ажиллах	—	сотрудничать; сотрудничество
харилцан туслалцах	—	взаимопомощь
хамрах	—	охватывать; вовлекать; включать
дэлхий дахиныг хамарсан асуудал	—	мировые (глобальные) проблемы
эдгээр	—	эти
талаар	—	в области (чего-л.), по линии) чего-л.)
ухамсарлах	—	понимать, осознавать
зүтгэх	—	1) тянуть, тащить, напрягая силу; 2) стараться, усердствовать; 3) (перен.) упорствовать, настаивать на своем
дуу хоолойгоо нийлүүлэн	—	в один голос
нийлүүлэх	—	1) соединять, присоединять, сливать, смешивать, объединять 2) снабжать, доставлять
занал	—	угроза
өнчрөх	—	1) осиротеть 2) (перен) чувствовать одиночество
үр	—	1. 1) плод, семя, зерно 2) плоды, результат, следствие П. дитя, ребенок
янаг амраг	—	любовь
хагацал	—	разлука, расставание
гаслан зовлон (г)	—	мука, горе, скорбь
цуурайтах	—	отдаваться
цуурай	—	эхо, отзвук, отголосок
сүндэрлэх	—	возвышаться
хот балгас	—	города (и населенные пункты)
сүйрэх	—	терпеть крах, разоряться
нөхөрлөл	—	товарищество
хамтын нөхөрлөл	—	содружество
зэрэгцээ	—	наряду, одновременно
олох	—	1) находить 2) доставать, добывать, получать, 4 обретать
тусгаар тогтнол	—	независимость
дэмжлэг	—	поддержка, содействие
гүнээ итгэх	—	глубоко верить

Запомните пословицу

Эхийн санаа үрд
Үрийн санаа ууланд
Мысли матери — о детях
Мысли детей — о горах

ГРАММАТИКА:

ДВОЙНЫЕ ПАДЕЖИ

(Давхар тийн ялгал)

Двойные падежи образуются путем присоединения двух падежных окончаний к основе одного и того же имени.

1. **Родительно-дательно-местный падеж** отвечает на вопросы «к кому?» и «у кого?» (только в смысле «в доме»). В разговорной речи эта форма встречается очень часто. **Например:**

аав—аавын—аавынд	— к отцу (в дом), у отца (в доме)
ах—ахын—ахынд	— к старшему брату (в дом) у старшего брата (в доме)
Жамба—Жамбын—Жамбынд	— к Жамбе (в доме), у Жамбы (в доме)
Иванов—Ивановын—Ивановын	— к Иванову (в дом), у Иванова (в доме)

2. **Родительно-совместный падеж** отвечает на вопрос «с кем (т. е. с чьими людьми?)». Например:

Бор—Борын—Борынтой	— с семьей Бора (с людьми Бора)
Төмөр—Төмөрийн—Төмөрийнтэй	— с семьей Тумура (с людьми Тумура)
Иванов—Ивановын—Ивановынтой	— с Ивановыми

3. **Дательно-местно-исходный падеж**, встречающийся лишь в единичных случаях, отвечает на вопрос «из чего (изнутри чего)?». Значение этой формы более узкое, чем значение простого исходного падежа. Например:

гэр—гэрт—гэрээс (ээ) — из юрты (из дома)

4. **Совместно-дательно-местный падеж** отвечает на вопросы «У кого (что-либо имеющего)?», «кому (что-либо имеющему)?», «у чего (с чем-то)?», «в чем (с чем-то)?» и т. д. Например:

морь—морьтой—морьтойд	— у кого-то (имеющего коня), кому-то (имеющему коня)
цас—цастай—цастайд	— на снегу, в снегу, по снегу; когда есть снег
мөс—мөстэй—мөстэйд	— на льду, по льду; когда есть лёд

5. **Совместно-винительный падеж** отвечает на вопросы «(кого) с кем?», «(кого, что) с чем?» и в предложении является прямым дополнением при переходном глаголе. Например:

нөхөд—нөхөдтэй—нөхөдтэйг	— (кого-то) с его товарищами
эрдэм—эрдэмтэй—эрдэмтэйг	— ученого; (кого-то) со знаниями
морь—морьтой—морьтойг	— (кого-то) вместе с его конем

6. **Совместно-орудный падеж** употребляется для выражения в предложении обстоятельства образа действия. Например:

амжилт—амжилттай—амжилт- тайгаар	— успешно (с успехом)
идэвх—идэвхтэй—идэвхтэй- гээр	— активно
гуныхрал—гуныхралтай—гуных- ралтайгаар	— печально (с грустью)
омог—омогтой—омогтойгоор	— высокомерно

7. **Совместно-исходный падеж** отвечает на вопросы «из-за чего?», «вследствие чего?». Эта форма употребляется для выражения причины (как следствия обладания чем-то). Например:

зав—завтай—завтайгаас	— поскольку свободен (букв.: со свободным временем)
өвчин—өвчтэй—өвчтэйгөөс	— из-за болезни, по болезни (букв.: из-за того, что с болезнью)

Словообразование: суффиксы «-рхаг», «-дал», «-рь-р)».

1. При помощи суффикса -рхаг (-рхэг, -рхог, -рхөг; -лхаг, -лхэг, -лхог, -лхөг, -после имен, оканчивающихся на -р) от именных основ образуются имена со значением ярко выраженного качества (напр., пристрастия к чему-либо, чванливости, преисполненности чего-то и т. п.). Например:
баярхаг — чванящийся богатством (от «баян» — богатство)

ноёрхог	— барский (от «ноён» — князь, барин)
эээрхэг	— самовластный, захватнический (от «эзэн» — хозяин)
ёсорхог	— педантичный (от «ёс» — порядок, этикет)
эрэлхэг	— мужественный (от «эр» — мужчина)
усархаг	— водянистый (от «ус» — вода)
ясархаг	— костистый, костлявый (от «яс» — кость)
элсэрхэг	песчаный, песчанистый (от «Элс» — песок)
уулархаг	— гористый (от «уул» — гора)
өвсөрхөг	— травянистый (от «өвс» — трава)
чулуурхаг	— каменистый (от «чулуу» — камень)
цасархаг	— обильный снегом, снежный (от «цас» — снег)

2. При помощи суффикса **-дал**, (**-дэл**, **-дол**, **-дөл**) от глагольных основ образуются имена со значением результата или места действия, абстрактного понятия действия. Например:

байдал	— состояние, ситуация, положение (от «байх» — находиться)
явдал	— походка; поведение; случай, положение, обстоятельство дела, действие; (от «явах» — идти)
оёдол	— шитьё; шов (от «оёх» — шить)
захидал	— письмо (от «захих» — делать наказ)
суудал	— сиденье; дежурство (от «суух» — сидеть)
буудал	— стойка (от «буух» — спускаться)
нүүдэл	— кочёвка; ход (в шахм.) (от «нүүх» — кочевать)
гүйдэл	— бег; ток; течение (от «гүйх» — бежать, течь)
асуудал	— вопрос, проблема (от «асуух» — спрашивать)

3. При помощи суффикса **-рь** (**-р**) от глагольных основ образуются имена со значением результата или места действия, абстрактного понятия действия. Например:

суурь	— основание, фундамент; базис; подставка; место (от «суух» -сидеть)
буурь	— стан; место (от «буух -спускаться»)
зоорь	— подвал, погреб (от «зоох» -вкапывать)
хуваарь	— график, расписание; распределение, разделение
(хувиар)	— (от «хуваах» -делить)
хавдар	— опухоль, отёк (от «хавдах» -отекает)
хэвтэр	— постель, ложе (от «хэвтэх» -лежать)
байр	— место, стоянка; квартира (от «байх» -находиться)
нэмэр	— прибавка; вклад (от «нэмэх» -добавлять)

Запомните пословицу:

Далайд дусал нэмэр
Капля морю добавка
(Копейка рубль бережет)

Упражнение 1. Ответьте на вопросы сначала устно, затем письменно. Умейте рассказать текст:

1. Октябрийн Агуу их хувьсгал хэдэн онд ялсан бэ? 2. В. И. Ленин ямар хүн байсан бэ? 3. Зөвлөлтийн ард түмэн энх тайвны бодлогыг хэрхэн хэрэгжүүлж байна? 4. Социалист байгууллагын давуу чанар юу юугаар илэрч байна? 5. ЭЗХТЗ гэж юу вэ? 6. Энх тайван гэгч юу вэ?

Упражнение 2. Составьте предложения со следующими словами и слово-сочетаниями.

1. Энх тайвны тунхаг. 2. Нийгмийн дэвшил. 3. Зэвсгийг бүх нийтээр хураах. 4. Дэлхий дахиныг хамарсан. 5. Хамтран ажиллах. 6. Харилцан туслалцах. 7. Энх тайван. 8. Өмөг түшиг.

Упражнение 3. Переведите на русский язык, используя словарь:

ЗӨВЛӨЛТ ТӨРИЙГ ҮНДЭСЛЭН БАЙГУУЛАГЧ

А. 1917 оны аравдугаар сарын 25 (арван нэгдүгээр сарын 7-) ны орой Петроградд Зөвлөлүүдийн II их хурал нээгдлээ. Улс орны өнцөг булан бүрээс бүгд 650 төлөөлөгч хурал цугласны 400 орчим нь большевикууд байжээ. Их хурал засгийн бүх эрх Зөвлөлүүдэд шилжсэнийг баяр баясгалантай тунхаглав. Энэ бол агуу их түүхэн үйл явдал байлаа.

Их хурал дээр аравдугаар сарын 26-нд Лениний хэлсэн үгийг төлөөлөгчид баяр бахдалтай угтан авлаа. «Ленинийг индэр дээр гарч ирэхэд танхимд цугларсан хүмүүс цөм босоцгоон индрийн зүг хошууран ханарч, зогсоо зайгүй алга нижгнүүлэн ташиж, «Ленин мандтугай!» гэсэн уриа цуурайтуулсаар байсан тул Ленин удтал үгээ эхэлж чдахгүй байж билээ» гэж их хурлын төлөөлөгч А. А. Андреев дурсан бичсэн байна. Хурлынхан ингэж л зогсоогоороо энх найрамдлын тухай Лениний илтгэлийг сонсоцгоосон бөгөөд тус илтгэлд байлдаж байгаа бүх орны ард түмэн, засгийн газруудад хандаж фронт дээр нэн даруй найрамдал байгуулах тухай уриалга батлан гаргахыг пролетарийн хувьсгалын жолоодогч санал болгосон байна.

Их хурал, Лениний саналаар сая сая ажилчин, тариачин олон түмнийг догдлуулж байсан хамгийн тулгамдсан асуудал болох найрамдлын тухай хуулийг баталжээ. Энэ бол империалист хөрөнгөтний эзлэн түрэмгийлэх бодлогод уг язгуураараа эсрэг Зөвлөлт засгийн энх тайванч гадаад бодлогыг анхны баримт бичиг байв. Социалист шинэ төрийн гадаад бодлого нь бүр анхнаасаа энх-тайванч улс түмний найрамдлын үйлсэд зориулагдсан байлаа. Найрамдлын тухай хууль нь дайн бол хүн төрөлхтний эсрэг чиглэсэн туйлын ялт хэрэг гэж зарласан байна.

Дараа нь Ленин газрын тухай илтгэл тавьж, хуулийн төслийг уншин сонгов. Газрын тухай хуулиар помещикийн газрын өмчийг ямар ч золиосгүйгээр эгнэгт устгаж, газрыг ард түмэнд шилжүүлэн өгөв. Тариачдын мэдэлд нийтдээ 150 сая га илүү газар шилжжээ. Тариачдын олон үеийн туршид мөрөөдөн тэмцэж байсан зүйл биелэгдлээ. Лениний хуулиар газрын хувийн өмчийг нийт ард түмний өмч, улсын өмчөөр халсан бөгөөд энэ нь хожим хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулах ажлыг хөнгөвчилсөн юм. Газрын тухай хуулийг их хурлын төлөөлөгчид санал нэгтэй баталлаа.

Зөвлөлүүдийн II их хурал, ажилчин, тариачны төлөөлөгчдийн Зөвлөлүүдийн Бүх Оросын Төвийн Гүйцэтгэх хороог сонгож, засгийн газар-Ардын Комиссар нарын Зөвлөлийг байгуулжээ. Ардын Комиссар нарын Зөвлөлийн даргаар В. И. Ленинийг сонгов. Ард түмэн улс орныг удирдах итгэл найдвараа большевикуудын намд хүлээлгэлээ. Ард түмний сонгосон Зөвлөлүүдийн их хурлын төлөөлөгчид дэлхийн анхны ажилчин, тариачны засгийн газрыг Ленин тэргүүтэйгээр байгуулав.

Б. Ажилчин, тариачид шинэ амьдрал байгуулах үйл хэргийн хүнд бэрх нөхцөл байдлын дунд эхэлсэн юм. Социалист хувьсгал ганц оронд, тэгэхдээ эдийн засгийн хувьд харьцангуйгаар үзвэл хоцрогдмол, хүн амын ихэнх нь жижиг

өмчит тариачид бүхий оронд ялсан билээ. Бас дайн үргэлжилж байв. Дайн нь улс орныг цөлбөн хоосруулж, ардын аж ахуйг хүнд хүчир эвдрэл сүйрэлд учруулж байв. Зөвлөлт засгийн олон тооны дайснууд түүний эсрэг хуйвалдаан, бослого үймээн зохион байгуулж, хорлон сүйтгэх, өдөөн хатгах явуулга үйлдэж, гүтгэлэг цуурхал дэгдээж байсан юм.

1917 оны арван нэгдүгээр сард Ленин «Ард иргэдэд» гэсэн уриалга бичиж, түүндээ Зөвлөлүүдийг тойрон нягтарч, төрийг удирдах хэргийг зоригтойгоор гүйцэтгэж ажиллахыг уриалжээ. Тэрбээр хурал, цуглаан дээр шинэ амьдрал байгуулахыг олон түмэнд цуцалтгүй уриалдаг байлаа. «Социализмыг дээд газрын зарлигаар байгуулж болохгүй» гэж Ленин хэлж байв. Социалист байгуулалтад хамгийн чухал, хамгийн гол зүйл бол олон түмний амьд бүтээлч ажиллагаа мөн гэж тэр үзэж байв.

Зөвлөлт засгийн газар Смольныйд (Петроградын нэг орд, энд Зөвлөлт засгийг тунхагласан юм) байрлаж байлаа. Энд ажил өдөр шөнөгүй оргилон өрнөж, эндээс хамаг заалт шийдвэр, удирдамж илгээж, улс орны өнцөг булан бүрээс энд хүмүүс цутган орж ирнэ. Энэ хамаг их ажлын гол төвлөрөл нь Ленин байлаа. Ленинд ажилчин, цэрэг, усан цэргүүд, тариачид хүрэлцэн ирнэ. Тариачны төлөөлөгчид хамгийн бөглүү тосгоноос ч Ленинтэй нүүр учран уулзах, өөрийн засгийн тэргүүнтэй ярилцах гэж нийслэлд хүрэлцэн ирдэг байлаа. Владимир Ильич бүгдийг хүлээн авч, санал хүсэлтийг нь анхааралтай сонсон ажил хэргийг хурдан шаламгай шийдвэрлэж, ажилчин, тариачныг сургаж, тэднээс өөрөө сурдаг байв. Ленин аливаа бүхнийг нэгээхэн ч орхилгүй хараандаа авч, нам, төрийн бодлогын бүх л үндсэн асуудлыг боловсруулж байсан юм.

В. Богино хугацаанд улс орны дотор улс төр, эдийн засгийн үндсэн өөрчлөлт хийв. Үйлдвэрлэл болон хуваарилалтад тавих ажилчны хяналт ямар байх тухай Лениний төслийг Зөвлөлт засгийн газар бүр анхныхаа өдрүүдэд батлан гаргасан юм. Ажилчин, албан хаагчдаас сонгогдсон төлөөлөгчид нь үйлдвэрийн бүх ажил хэргийг хянах эрх олж авсан байна. Ажилчин анги ингэж үйлдвэрлэлийг удирдах хэргийг гартаа авах анхны алхам хийлээ.

Түүнчлэн хуучин армийг халах, улсын иргэдийг үе давхраа болгон ангилдаг явдлыг устгах, хөрөнгөлөг ангийн онцгой эрх дархыг халах хуулийг батлан гаргав. Төмөр замын тээвэр, усан замын худалдаа, банк тэргүүтнийг ард нийтийн өмч болгож, гадаад худалдаа улсын гарт шилжлээ. Удалгүй фабрик, заводууд мөн ард түмний өмч болов.

Зөвлөлт төрийн бүх байгууллагууд, ардын комиссарын газрууд Лениний шууд удирдлагын дор байгуулагдав. Түүний

санаачлагаар улс ардын аж ахуйг төлөвлөн хөтлөх пролетарийн анхны байгууллага, Ардын аж ахуйн Дээд Зөвлөл, мөн Үндэсний хэргийг эрхэлсэн ардын комиссарын газар, хувьсгалын эсэргүү явдал болон хорлон сүйтгэгчидтэй тэмцэх Бүх оросын онц комисс байгуулагдсан юм. Ленин Зөвлөлтийн анхны үндсэн хуулийн эх бослон «Дарлагдан мөлжигдсэн хөдөлмөрчин ардын эрхийн тунхаг»-ийг боловсруулжээ. Энэ тунхагт Оросын бүх ард түмний бүрэн тэгш эрхийг тунхаглаж, бүх үндэстнийг тусгаар бие даасан улс төрөө байгуулах хүртэл өөрөө засан тохинох эрхээр хангалаа. Тус тунхаг Зөвлөлт орны ард түмнүүдийн эвдэршгүй нөхөрлөлийн бат бэх тулгуур суурийг тавьжээ.

Зөвлөлт засаг ард олон түмнийг өөрийн талд улам улам татан авлаа.

(«Владимир Ильич Ленин. Товч намтар»-аас)

Упражнение 4. Перескажите текст «Основатель Советского государства».

Упражнение 5. Переведите на монгольский язык, используя данные ниже слова и выражения.

разрабатывать	— боловсруулах
стройный	— <u>бүрэн цэгцтэй</u> (букв.: с. полным порядком)
руководящая роль	— удирдах роль
рабочий класс	— ажилчин анги
революционная борьба	— хувьсгалт тэмцэл
союз	— холбоо (и)
крестьянство	— тарначин
гегемония пролетариата	— пролетари нарын манлайлал
демократический	— ардчилсан
буржуазный	— хөрөнгөтний
перерастать в...	— ...-д урган орох
национально-освободительное движение	— үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн
руководство (руководить)	— ...-г удирдах
методы и формы	— арга хэлбэр
удивительно	— гайхамшигтай
правильно и мудро	— зөв мэргэнээр
увязывать	— хослуулах (букв.: соединять попарно)
рабочее движение в России	— Оросын ажилчны хөдөлгөөн

В. И. Ленин смог разработать стройную теорию о руководящей роли рабочего класса в революционной борьбе, союзе рабочего класса и крестьянства, гегемонии пролетариата, рабоче-крестьянской революционной демократической диктатуре, о перерастании буржуазной демократической революции в социалистическую революцию, — о руководстве

национально-освободительным движением, о методах и формах революционной борьбы и смог удивительно правильно и мудро увязать её (теорию) с практикой рабочего движения в России.

Упражнение 6. Составьте 20 предложений, используя слова и выражения, данные в упражнении 5.

Упражнение 7. Переведите на монгольский язык.

А. 1. Советский Союз направляет (чиглүүлэх) все свои усилия (бүх хүчин чармайлтаа) на принятие (авах) эффективных (үр нөлөөтэй) мер (арга хэмжээ) в области (талаар) предотвращения угрозы (аюул заналыг сэрэмжлэн зайлуулах) возникновения ядерной войны (цөмийн дайн гарах), прекращения гонки вооружений (зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох), реального (бодитойгоор) разоружения, которые должны привести (хүргэх) к полному и всеобщему (... бүх нийтээр бүрэн..) разоружению под (дор) строгим (хатуу чанд) и (бөгөөд) эффективным международным контролем (хяналт).

2. Необходимо принять энергичные (шаламгай) и эффективные меры для (... -ийн тулд) прекращения гонки вооружений, осуществления (... явдлыг ... хэрэгжүүлэн биелүүлэх) всеобщего и полного разоружения под строгим и эффективным международным контролем.

3. Политика мирного сосуществования государств (улс орнууд) с различным социальным строем отвечает интересам народов (улс түмний эрх ашигт нийцэх).

4. Разъясняя (тайлбарлаж политику СССР)... баримталж байгаа бодлогыг) в отношении некоторых вопросов)... зарим асуудлаар) разоружения (зэвсэг хураах), представитель Советского Союза подчеркнул (... г онцлон тэмдэглэх), что главная проблема заключается (...-д болж байгаа) в ограничении (...-г хязгаарлах) практических возможностей (практик боломж) совершенствования (боловсронгуй болгох) оружия массового уничтожения (үй олноор хөнөөгч...) и что вопрос полного и всеобщего запрещения (...-г хориглох) испытаний ядерного оружия) (цөмийн зэвсэг турших) привлекает (татаж байгаа) постоянное внимание (байнгын анхаарал).

5. Прения (санал шүүмжлэл), развернувшиеся (өрнөх) в первом комитете хороонд) Генеральной Ассамблеи ООН (НҮБ-ын Ерөнхий Ассамблей) по вопросу разоружения, свидетельствуют (...г гэрчлэх) о том, что государства (улс гүрнүүд) глубоко заинтересованы (...-г гүнээ сонирхох) в ослаблении напряженности (түгшүүртэй байдлыг намжаах) и стремятся (эрмэлзэж байгаа) к осуществлению (авч хэрэгжүүлэх) конкретных мер

тодорхой арга хэмжээ) в областях (талаар) ограничения гонки вооружений (зэвсэглэлээр хөөцөлдөх) и (ба) разоружения.

- Б. 1. Политика Советского государства была, есть и будет политикой мира.
2. Все прогрессивное человечество поддерживает миролюбивую политику Советского Союза.
3. Все страны социалистического содружества последовательно придерживаются политики мира; вместе с тем они оказывают всестороннюю помощь и поддержку тем странам, которые борются за (свою) свободу и независимость.
4. В. И. Ленин был гениальным теоретиком научного социализма и коммунизма, творческим марксистом, преданным революционером.
5. Ныне социализм вышел за рамки одной или нескольких стран; в мире давно уже образовалась целая социалистическая система, и экономические, культурные и научные контакты между социалистическими странами стали тесными, как никогда ранее.
6. Особое место занимает деятельность Совета Экономической Взаимопомощи.

Упражнение 8. Переведите на монгольский язык:

1. Они ушли к Дамбе (в дом). 2. Твои сидят у Болда (в доме). 3. Сходи к своему старшему брату (в дом)! 4. Наши переедут на зимовку (вместе) с семьей Дугара. 5. Мы сделаем эту работу (вместе) с семьей Тумура. 6. Принесите из дома цветную бумагу. 7. Когда снег, мы катаемся на лыжах, а когда лёд — на коньках. 8. Его нельзя посылать одного, нужно послать с товарищами.

Упражнение 9. Составьте предложения со следующими словами и словосочетаниями:

Найрамдалтайгаар орших, баяртайгаар дуулах, ... асуудлыг бодитойгоор шийдвэрлэх, ... засгийн газрыг ... тэргүүтэйгээр байгуулах, ... төлөвлөгөөг амжилттайгаар ... биелүүлэх, болгоомжтойгоор, идэвхтэйгээр, ашигтайгаар, гунигтайгаар, зоригтойгоор.

Упражнение 10. Переведите на русский язык, используя словарь:

1. Улсуудын хоорондын маргааныг шийдвэрлэхэд эрх тэгш бөгөөд аливаа хэлбэрээр хүч хэрэглэхгүй байх зарчмыг чанд сахин мөрдсөн цагт Азийн аюулгүй байдлын асуудлыг илүү үр ашигтайгаар шийдвэрлэж болох юм.

2. Одоо тогтоод байгаа цэргийн хүчний барагцаалсан тэнцүүрийг бид алдагдуулахыг хүсэхгүй байна. Харин ч бид энэхүү тэнцүүрийг хэн ч өөртөө ашигтайгаар өөрчлөх гэж оролдохгүй байхыг шаардаж байна.

3. Бүх улс хүч чармайлт гаргахыг шаардаж байгаа газар дэлхий дээр энх тайвныг хангах маш чухал чиглэл бол олон улсын хатуу чанд бөгөөд үр нөлөөтэй хяналтын дор зэвсгийг бүх нийтээр бүрэн хураахад хүргэх ёстой зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, зэвсгийг бодитойгоор хураах арга хэмжээг хэрэгжүүлэх явдал мөн гэдэг нь эргэлзээгүй юм.

Упражнение 11. Переведите на русский язык:

Сүүлийн жилүүдэд зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зарим тодорхой чиглэлд хязгаарласан нь ЗХУ, ах дүү социалист бусад орон, энх тайвныг эрхэмлэгч нийт хүчний цудалтгүй чармайлтын үр дүн юм. Цөмийн зэвсгийн туршилтад олонх төрлийг хориглох, цөмийн зэвсэг дэлгэрэхийг сэрэмжлэх, энэхүү зэвсгийг сансар, далайн ёроолд байрлуулахыг хориглох, стратегийн зэвсгийг хязгаарлах, бактериологийн зэвсгийг хориглон устгах, байгаль орчинд нэрэг дайны зорилгоор нөлөөлөхийг хориглох зэрэг асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулж, дэлхийн олон улс гүрэн нэгдэн орсон нь цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдлыг хязгаарлах, шинэ дайны аюул заналыг багасгах үйлсэд үнэтэй хувь нэмэр болов.

Упражнение 12. Переведите на монгольский язык:

1. Большая часть территории Монголии — гористая местность. 2. «Онегин был, по мнению многих..., ученый малый, но педант» (П). 3. В течение многих лет народ этой страны вёл мужественную борьбу против захватчиков. 4. Нанишите, пожалуйста, названия этих травянистых растений. 5. В какой гостинице Вы остановились (буух)? 6. Ждите меня на пристани (онгоцны ...)! 7. Скажите, пожалуйста, где находится ателье (...-ын газар)? 8. Две недели назад я послал тебе открытку (ил...). 9. Они сказали, что им не нравится его поведение (зан ...). 10. Прежде всего (юуны өмнө) необходимо было ликвидировать неграмотность (бичиг үсэг үл мэдэх...). 11. Лекция о международном (олон улсын) положении состоится в среду, в 16 часов. 12. Скажите ему, что около дома стоит легковая машина (...-ын машин)! 13. У тебя сегодня дежурство? 14. Сейчас твоя ход (шахм.)! 15. Назовите, пожалуйста, перелетных птиц (...-ийн шувуу), которые вам известны. 16. В августе наш театр уезжает на гастроли (тоглолтоор явах). 17. Я хотел бы посмотреть расписание (цагийн...) поездов. 18. Вы уже видели расписание занятий? 19. Ему пришлось встать со своего места (суурин дээрээсээ). 20. Я купил вчера в ГУМ-е очень красивый подсвечник (лааны...) 21. Что означает слово «базис»? 22. Мы узнали, что строители еще не заложили (тавих)

фундамент дома. 23. К сожалению, это злокачественная (хорт) опухоль. 24. Квартира удобная? 25. Мне сказали, что он живет в общежитии. 26. Ратификация этого договора (гэрээ) внесет (оруулах) огромный вклад в установление прочного мира. 27. Страны социалистического содружества вносят весомый (жинтэй) вклад в дело обеспечения мира во всем мире.

УРОК 18

БИДНИЙ НАЙРАМДАЛ

(Наша дружба)

Монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдал бол болд шиг хатуу, болор шиг тунгалаг юм. Бидний найрамдлыг дэлхийн хөдөлмөрчдийн их багш В. И. Ленин, монголын ард түмний сод хүү Дамдины Сүхбаатар нар үндэслэн байгуулсан билээ. Манай хоёр орны интернационалч найрамдал жар гаруй жил амжилттай хөгжин батажсаар ирлээ.

Монголын ард түмэн капиталист шатыг алгасаж, аажмаар социализмд шилжин орж болох түүхэн замыг анх В. И. Ленин ололын хувьд заан үндэслэж өгсөн билээ. Монгол орон социализмын замаар жар гаруй жил замнаж ирсэн түүх В. И. Лениний сургаалын үнэн болохыг гэрчилж байна.

Монгол оронд 1921 онд ардын хувьсгал мандаж, ард түмэн засгийн эрхийг гартаа авсан билээ. Үүгээрээ Монгол дэлхийд хоёрдогч социалист орон болсон түүхтэй.

Монгол-Зөвлөлтийн ард түмний эвлэршгүй бат найрамдал жилээс жилд өвөрмөц утга агуулгаар баяжиж байна.

Монголын ард түмэн социалист байгуулалтдаа олсон гайхамшигт ололт амжилтаа юуны өмнө ах дүү Зөвлөлтийн ард түмний өгөөмөр тусламжийн үр ач гэж үздэг юм. Ардын хувьсгал ялмагц, манай орны өмнө цоо шинэ нийгэм, түүхийн цоо шинэ нөхцөлд цогцлон байгуулах том зорилт тулгарсан билээ.

Феодалын хоцрогдсон Монгол орныг социалист шинэ аж үйлдвэр, хөдөө аж ахуй бүхий орон болгоход Зөвлөлт Холбоот Улс үнэлж баршгүй тусламж үзүүлсэн бөгөөд одоо ч үзүүлсээр байна.

Эх орны Их дайны хүнд жилүүдэд Монголын ард түмэн ах дүү зөвлөлтийн ард түмнийхээ шуударга-тэмцэлд нь сэтгэл санаа, эд материалын гүн дэмжлэг тусламж үзүүлж байсан.

Монголын ард түмэн социалист байгуулалтдаа олсон амжилтын нэг чухал хэсэг бол соёлын их хувьсгал хийсэн явдал мөн. Монголын социалист соёл хөгжин мандахад зөвлөлтийн эрдэмтэн мэргэд, багш нар гүн тусламж үзүүлсэн.

Монгол Улсын Их Сургууль дэлхийн хоёрдугаар дайны ид үе, 1942 онд нээгдсэн нь тус оронд дээд боловсролтой боловсон хүчин бэлтгэх гол уурхай нь болсон билээ. Энэ үед Зөвлөлт орон Гитлерийн фашизмын эсрэг хүнд ширүүн тэмцэл явуулж байсан ч гэсэн Монгол улсад их сургууль байгуулахад нь тусалж, шилдэг мэргэжилтнээ илгээж, хичээлийн тоног төхөөрөмж бэлэглэж байсан удаатай.

Монголын ард түмэн Зөвлөлтийн ард түмний сэтгэл хамрамгүй тусламжийн ач тусыг хэзээ ч мартдаггүй юм.

Бид энэ агуу их тусламжийн тухай ийнхүү уянгалуулан дуулдаг.

Ахан дүүсийн найрамдал

Ашид мөнхийн найрамдал

Эх үрсийн найрамдал

Эгнэгт мандах найрамдал.

Найрамдалтай байна гэдэг бол улс ардын аж ахуй, соёлын бүх салбарт хамтран ажиллаж, харилцан туслалцаж, бүх талаар ойртон нягтарна гэсэн үг.

Слова и выражения

болд	— сталь, стальной
болор	— хрусталь
сод	— выдающийся
үндэслэн байгуулах	— основывать
интернационалч	— интернациональный
батжих	— укрепляться
капиталист шат	— капиталистическая стадия (формация)
шат (ан)	— лестница, ступень, стадия
аажмаар	— постепенно
анх	— впервые
онолын хувьд	— теоретически (в теоретическом отношении)
замнаж ирсэн	— шёл, шла
замнах	— 1) часто ездить по одной и той же дороге 2) проторить путь
сургаал	— учение
үнэн	— правда, истина; правдивый, истинный, действительный
гэрчлэх	— свидетельствовать, подтверждать
мандах	— восходить, подниматься; распростра-

эвдрэх	— няться, возрождаться; совершаться (о революции)
өвөрмөц	— ломаться, разрушаться; рассориться
утга агуулга	— своеобразный, специфический
утга	— содержание, значение
агуулга	— смысл, значение
баяжих	— содержание
байгуулах	— обогащаться
гайхамшигт	— строительство, стройка
ололт	— удивительный, замечательный
юуны өмнө	— достижение
ах дүү	— прежде всего
өгөөмөр	— братский
үр ач	— щедрый, обильный
... гэж үзэх	— результат, следствие
цоо шинэ	— считать кого-что-л. кем-чем-л.
цоо	— совершенно новый
	— 1) при имеем-совершенно, совсем
	— 2) при глаголах-насквозь, напролёт
цогцлон байгуулах	— создавать, строить
цогцлох	— складывать грудой, наваливать в кучу
зорилт	— задача
тулгарах	— становиться антитезой, упираться
үйлдвэр	— предприятие
аж үйлдвэр	— промышленность, индустрия
хөдөө аж ахуй	— сельское хозяйство
бүхий	— с (последнее)
болгох	— делать что-что-л. кем-чем-л.
үнэлж баршгүй	— неоценимый
үнэлэх	— оценивать; ценить, дорожить
барах	— кончать, исчерпывать
Эх орны Их дайн	— Великая Отечественная война
хүнд	— тяжелый, трудный
тэмцэл	— борьба
сэтгэл санааны	— моральный
эд материалын	— материальный
эд	— вещь, предмет, имущество
соёл	— культура
ид	— сила, энергия, разгар чего-л.
нээгдэх	— открываться
тус	— П. этот, тот; наш
боловсрол	— образование
боловсон хүчин	— кадры
гол уурхай	— здесь: главная кузница
эсрэг	— против, наизрекор, вопреки,
ширүүн	— в сложн. —противо—, анти—

ширүүн	— 1) грубый, жёсткий
явуулах	2) перен.: жестокий, суровый
	— 1) отправлять, посылать
туслах	2) проводить, вести работу и т. п.
	— 1. помогать
	2. вспомогательный, подсобный
	3. помощник
шилдэг	— лучший, отборный, избранный
илгээх	— посылать, направлять
тоног төхөөрөмж	— оборудование
бэлэглэх	— дарить
удаа	— раз
сэтгэл харамгүй	— бескорыстный
харам	— 1) скупость, жадность
	2) сожаление
ач тус	— значение; роль; польза
тус	— 1. польза; помощь; услуга
хэзээ ч	— 1) никогда; 2) всегда
мартах	— забывать
ийнхүү	— вот так, таким путем
уянгалуулан дуулах	— петь с чувством, петь трогательно
ашид	— вечно, неизменно, всегда
эгнэгт	— навсегда, навеки; вечно, всегда.

ГРАММАТИКА:

ПОВЕЛИТЕЛЬНО-ЖЕЛАТЕЛЬНАЯ ФОРМА 3-ГО ЛИЦА

(3-р биеийн захиран хүсэх хэлбэр)

Суффиксами этой формы являются —**тугай** (—**түгэй**) в (письменной речи) и —**г** (преимущественно в устной речи).

Повелительно-желательная форма 3-го лица выражает пожелание, повеление или разрешение, чтобы какое-либо действие было совершено 3-м лицом и на русский язык переводится словами «Пусть ...!», «Да...!» и т.п. Например:

1. Дайн сөнөтүгэй! — Долой войну! (букв.: Да сгинет война!)
2. Даян дэлхийд энх тайван мандтугай! — Да здравствует мир во всем мире?
3. Дэлхийн коммунист, ажилчны хөдөлгөөний нэгдэл нягтрал улам батжин бэхжтүгэй! — Пусть (еще больше) крепнут единство и сплоченность мирового коммунистического и рабочего движения!
4. «Манай эх орны эрх чөлөө, тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн найдвартай баталгаа-монгол, зөвлөлтийн ард

түмний ах дүүгийн найрамдал мандтугай!» — «Да здравствует братская дружба монгольского и советского народов — надежная гарантия свободы, независимости и прогресса нашей родины!»

5. Энэ нь өчүүхэн ч атугай тус болог! — Пусть это принесет хоть небольшую пользу!
6. Хүү минь ирэг! — Пусть придет мой сын!
7. Номоо уншиг! — Пусть читают (Пускай читает)!
8. Цай уугаад яваг даа! — Ладно уж, пусть попьёт чай и уходит!
9. Юу л болбол болог! — Будь что будет! (букв.: Если что случится пусть случится!)

Отрицанием к этой форме является бүү. Например:
Дахин бүү үзэгдэг! — Пусть не повторится! (Или: Пусть больше на глаза не появляется!)

Словообразование: суффиксы «—л—», «—мж».

1. При помощи суффикса —л от глагольных основ образуются имена со значением процесса или результата действия (иногда носителя качества по действию), абстрактного понятия действия. Например:

найрамдал	— дружба (от «найрамдах» — приходить к согласию)
тэмүүлэл	— стремление (от «тэмүүлэх» — стремиться)
ёслол	— церемония, обряд (от «ёсдох» — отдавать честь, выполнять обряд)
өгүүлэл	— статья (от «өгүүлэх» — изрекать)
тогтоол	— постановление, решение (от «тогтоох» — устанавливать)
алжаал	— усталость, утомление (от «алжаах» — уставать переутомляться)
нэгдэл	— объединение, единство, единение (от «нэгдэх» — объединяться)
үргэлжлэл	— продолжение (от «үргэлжлэх» — продолжаться)
танил	— знакомый, приятель (от «таних» — узнавать, переутомляться)
гайхал	— чудак; чудной (от «гайхах» — удивляться)
хүсэл	— желание, хотение (от «хүсэх» — хотеть)
таамнал	— гипотеза, догадка (от «таамнах» — предполагать)
чадал	— мощь, сила; способность (от «чадах» — мочь)
ажилгүйдэл	— безработица (от «ажилгүйдэх» — не иметь работы)

илүүдэл	— излишек, лишний (от «илүүдэх» — превышать, быть лишним)
төөрөл	— заблуждение (от «төөрөх» — заблуждаться)
бүртгэл	— учёт (от «бүртгэх» — регистрировать)
оршил	— предисловие (от «орших» — заключаться в чём-л.)
тогтнол	— установление, утверждение (от «тогтнох» — устанавливаться, утверждаться)

2. При помощи суффикса —**мж** от глагольных основ образуются имена со значением абстрактного понятия действия (иногда — результата действия). Например:

бүтээмж	— производительность (от «бүтээх» — создавать).
зөвлөмж	— рекомендация (от «зөвлөх» — советовать-ся)
тааламж	— удовлетворение (от «таалах» — нежить)
үзэмж	— наружность, вид (от «үзэх» — смотреть)
тусламж	— помощь (от «туслах» — помогать)
удирдамж	— директива, руководство (от «удирдах» — руководить)
төхөөрөмж	— оборудование (от «төхөөрөх» — оборудовать).
сэрэмж	— бдительность (от «сэрэх» — просыпаться)
залгамж	— приемственность (от «залгах» — присоединять, надставлять)
болгоомж	— предосторожность, осмотрительность (от «болгоох» — быть осторожным, опасаться)
санамж	— заметка, урок (от «санах» — помнить)
боломж	— возможность (от «болох» — иметь место)
найрууламж	— композиция (от «найруулах» — составлять)
хоромж	— убыль, уменьшение (от «хорох» — сокращаться, убывать)

Упражнение 1. Ответьте на вопросы. Перескажите текст.

1. Монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдлыг анх хэн үндэслэсэн бэ? 2. Манай хоёр ард түмэн хэдэн жил найрамдалтай оршин сууж байна вэ? 3. Хоцрогдсон бага буурай орны тухай Лениний ямар сургаалыг Монгол орон амьдралд хэрэгжүүлж байна вэ? 4. Монгол оронд хэдэн онд ардын хувьсгал ялсан бэ? 5. Монголын ард түмэн социалист байгуулалтынхаа ололт амжилтыг юу гэж үздэг вэ? 6. Монголын ард түмэн Эх орны Их дайны жилүүдэд зөвлөлтийн ард түмэнд хэрхэн тусалсан бэ? 7. Монгол улсын их сургууль ямар үед байгуулагдсан бэ? 8. Монголын ард түмэн интернационалч найрамдлаа юу гэж магтан дуулдаг вэ?

Упражнение 2. Напишите небольшое сочинение на тему «Вечная дружба». Используйте следующие слова и выражения.

1. Мөнх найрамдлын бэлэг тэмдэг Дархан хот; 2. Эрдэнэтийн их барилга байгууламж; 3. Интернационалч, бат бэх найрамдлаа нүдний цэцгий мэт (как зеницу ока) хайрлан хамгаалах; 4. Монгол орны социалист бүтээн байгуулалтын бүх л түүхэнд; 5. Хамтран ажиллах, харилцан туслалцах үндсэн дээр.

Упражнение 3. Переведите. Поговорите между собой по следующему образцу.

- Сайн байна уу? Молом оо!
- Сайн байнаа. Та сайн уу?
- Сайн, сайн. Чи хаа ажиллаж байнаа?
- Би Эрдэнэт хотод ажиллаж байгаа.
- Өө, тийм үү? Ямар ажил хийж байна даа?
- Эрдэнэт хотын уулын баяжуулах комбинатад (Горно-обогатительный комбинат) тэрэг барьж байна (Работаю водителем).
- Эрдэнэт хотод чинь ямар үйлдвэр баригдаад байна аа даа?
- Зөвлөлтийн хүч хөрөнгөөр баригдаж байгаа бөгөөд дэлхийн арван том үйлдвэрийн тоонд орох тийм үйлдвэр баригдаж байна.
- Үгүй ерөө хүү минь, мөн ч сайхан хэрэг байна даа. Манай ах нар ч («наши братья» — имеются в виду советские товарищи) бидэнд ч мөн их юм хийж өгөх юмаа даа, хөөрхий. Цаана чинь автобус чинь ирлээ. Хүү минь, баяртай!
- За, баяртай, Буянт гуай!

Упражнение 4. Переведите на русский язык, используя словарь.

... Монголын сэхээтэн... нарын эрэлхэг шийдэмгий эхэлсэн ажлаас илүү чухал бөгөөд хэцүү ажил ертөнц дээр байхгүй.

... Оросын уран зохиолыг монгол хэлэнд орчуулахдаа ямар зарчмыг баримтлах вэ гэж ... асууж байна. Энэ асуултад... хангаж чадахуйц яв цаваар би хариулж чадна гэж үү дээ? Гэвч Монголын тухай миний уншсан номыг баримталж, монгол хүний сэтгэлийн тухай миний бодоход ... ард түмэнд идэвхтэй зарчмын номлол ялангуяа тус бололтой.

Бүх олон ястанд хүртээх зохистой сайн сайхан юм гэж Европт юу байдаг болбаас тэр цөм аж амьдралаа идэвхтэй зохиодгийн ачаар бүтжээ...

М. Горький.

19. V. 1925.

Итали-Сорренто.

«МОНГОЛ АРД» ГЭДЭГ ДАЙЧИН НИСЭХ ОНГОЦНЫ ЭСКАДРИЛЬ

БНМАУ-ын 25 дугаар бага хурлаас «Монгол ард» хэмээх нисэх онгоцны эскадриль байгуулж, СССР-ийн Агаарын цэргийн хүчинд шилжүүлэх тухай шийдвэрийг 1943 оны 3 дугаар сард гаргажээ. Чингээд уг эскадриль байгуулах мөнгө цуглуулах ажлын явцын тухай төвийн ба орон нутгийн сонинд «Нисэх онгоцны энэ эскадриль бол баатарлаг улаан армид барих манай эрхэм бэлэг мөн» гэсэн гарчигийн дор өдөр бүр нийтэлж байв. 1943 оны зун болоход 2 сая төгрөг хуримтлуулан, СССР-ийн улсын банканд шилжүүлсэн байна. Х. Чойбалсан 1943 оны 7 дугаар сарын 22-ны өдөр монголын хөдөлмөрчдийн энэ захиа даалгаврыг Зөвлөлт засгийн газарт уламжилсан цахилгаан утсандаа «Ялгуулсан улаан армийн эрэлхэг шонхрууд байлдааны эдгээр онгоцыг жолоодож, фашистын зандалчидтай баатарлаг тулалдаж буй манай «Хувьсгалт Монгол» хэмээх танкийн бригадын дайчдын нэг адил дайсны амьд хүч ба техникийг устгах болтугай» гэжээ.

(«Ах дүүгийн барилдалгааны ном»,
Түүхийн баримт бичиг).

1. Хулан хүүхэн бэр цэцэг бэлэглэж, сэтгэлийнхээ үнэнийг илчлэхэд Арслан тайж «болтугай, болтугай» гэжээ. 2. «За, тийм л байх болтугай» гэж цаадах нь дурамжхан өгүүлжээ. 3. Гурав хоног байтугай, долоо хоног ч хоолгүй явж чадна гэж сахалт эр сайрхжээ. 4. Миний зовлонг тэр зөв ойлгог. 5. Хурлын дараа Батсүх энд ирэг. 6. Лодой маргааш анд яваг. 7. Багш нар энэ тогтоолын зүйл бүрийг нэгд нэггүй мэдэж аваг. 8. Намайг тийм арчаагүй эр гэж тэр бүү бодог.

9. «Наран үүрд мандаж байг
Тэнтэр үүрд цэлмэг байг
Ээж минь үүрд байж байг
Би бас хамт байг»

10. За, та нарынхаар болог!

11. ... Бузар дайн нь

түүний өдөөгчид нь

түүнийг хүсэгчид нь

цөм сөнөтүгэй!

Бууны харанхуй ам

цаашаа харж,

дууны сайхан ая
наашаа түртүгэй!

(Ц. Гайтаз, «Дайн сөн түгэй!»,
1959 он)

12. ... Эх дэлхий маань энх байг!
Эзэн хүмүүс нь тунх байг!

(С. Дашдооров,
«Дэлхий», 1964 он)

Упражнение 7. Переведите на русский язык.

1. ... Савасан хэрэг сэтгэлчлэн бүтээд
Хэлсэн үг ёсчлон болоод
Уулзсан цагт өлзийтэй болтугай!
Учирсан хойно жаргалтай болтугай!

(Ц. Дамдинсүрэн,
«Буурал ижий минь» 1934)

2. ... Сайхан жаргал мөнхжиж
Савасан үйлс бүтэж
Сайн амьдрал батажтугай!
Самуун дайсан сөнөтүгэй!

(Ц. Дамдинсүрэн, «Монголын циркийн жү-
жигчид Зөвлөлт Бурнад Монголд очиж тог-
лоход зорнулсан шүлгүүд», 1942)

3. ... Мандсан хувьсгалын цогт удирдагч
Манай ялгуусан нам мандтугай!
Мэлчин ардын жаргалт амьдрал
Маш бадарч мандах болтугай!

(Ц. Дамдинсүрэн, «Монгол ардын үнэн удир-
дагч», 1944).

Упражнение 8. Переведите на русский язык:

1. Социализм, коммунизмын төлөө, империализм, коло-
ничлол, харгислалын эсрэг тэмцлийн ялгуусан туг, аугаа их
интернационалч сургаал-марксизм-ленинизм мандтугай!

2. Империализмын эсрэг тэмцлийн шийдвэрлэгч хүч энх
тайван, ийгмийн дэлхийн найдвартай түнш тулгуур —
дэлхийн социалист систем улам бэхжин хөгжтүгэй!

3. Социалист хамтын нөхөрлөлийн орнуудын ард түмний
интернационалч найрамдал, хамтын ажиллагаа улам бэх-
жин хөгжтүгэй!

4. Орчин үеийн хувьсгалт гол хүчин-дэлхийн социализм,
олон улсын ажилчин анги, үндэсний эрх чөлөөний хөдөл-
гөөний хүчирхэг бат холбоо бэхжин хөгжтүгэй!

5. Эх орондоо социализм амжилттай байгуулж байгаа
монголын ард түмний яруу алдар бадартугай!

6. Манай орны ажилчин анги, хоршоолсон ард, хөдөлмөрийн сэхээтний яруу алдар бадартугай!

7. Манай ажилчин анги, хөдөлмөрчдийн хамгийн өргөн олныг хамарсан, дайчин байгууллага — Монголын Үйлдвэрчний Эвлэл мандтугай!

8. МАХН-ын дайчин туслагч, бэлтгэл хүч, монголын залуучуудын тэргүүний оярд-Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл мандтугай!

Упражнение 9. Переведите на монгольский язык.

- | | |
|--------------------------------|-------------------------|
| 1. Пусть он туда пойдет! | — Нет, ты иди! |
| 2. Пусть она здесь сядет! | — Нет, вы садитесь! |
| 3. Пусть они его встречают! | — Нет, я встречу! |
| 4. Пусть он ему напишет! | — Нет, мы напишем! |
| 5. Пусть она все скажет! | — Нет, ты скажи! |
| 6. Пусть они сегодня работают! | — Нет, вы работайте! |
| 7. Пусть она откроет дверь! | — Нет, я сам открою! |
| 8. Пусть он ведет урок! | — Нет, я проведу! |
| 9. Пусть они сами позвонят! | — Нет, мы позвоним! |
| 10. Пусть они вдвоем приедут! | — Нет, он один приедет! |
| 11. Пусть он расскажет! | — Нет, вы расскажите! |
| 12. Пусть они сами провожают! | — Нет, мы проводим! |

Упражнение 10. Переведите на монгольский язык

1. Да здравствует дружба наших двух стран! 2. Да здравствует монголо-советская дружба! 3. Да будет мир! 4. Пусть крепнет наше единство! 5. Да живет (наслах) он долго (урт удаан)! 6. Пусть крепнет наша дружба! 7. Пусть расширяется наше сотрудничество! 8. «Пусть всегда будет солнце! Пусть всегда будет небо!» 9. «Пусть всегда будет мама! Пусть всегда буду я!» 10. Пусть будет тепло! 11. Пусть будет прохладно! 12. Пусть пойдет снег! 13. Пусть кончится дождь! 14. Пусть он читает свои книжки! А я пойду один. 15. Если она так скажет — пусть говорит! 16. Если он так делает — пусть делает! 17. Если они так подумают — пусть думают! 18. Если он поедет — пусть едет!

Упражнение 11. Выучите наизусть Государственный Гимн МНР:

БНМАУ-ЫН ТӨРИЙН ДУУЛАЛ

Урьдын бэрх дарлалыг устгаж
Ардын эрх жаргалыг тогтоож
Бүх нийтийн зоригийг илтгэсэн
Бүгд Найрамдах Улсаа мандуулсан
Сайхан монголын цэлгэр орон
Саруул хөгжлийн дэлгэр гүрэн

Үеийн үед энхжин бадартугай
 Үрийн үрд бэхжин мандтугай
 Ачит нам, улсыг гийгүүлж
 Хүчит түмэн, улсыг хөгжүүлж
 Буцашгүй зүтгэлээр дүүрэн хөвчилсөн
 Цуцашгүй тэмцлээр түүнийг товчилсон
 Сайхан монголын цэлгэр орон
 Саруул хөгжлийн дэлгэр гүрэн
 Үеийн үед энхжин бадартугай
 Үрийн үрд бэхжин мандтугай
 Зөвлөлт оронтой заяа холбож
 Дэвшилт олонтой санаа нийлж
 Хандах зүгийг бахтай барьсан
 Мандах коммунизмыг цогтой зорьсон
 Сайхан монголын цэлгэр орон
 Саруул хөгжлийн дэлгэр гүрэн
 Үеийн үед энхжин бадартугай
 Үрийн үрд бэхжин мандтугай

Упражнение 12. Переведите на монгольский язык:

1. Пусть он не думает, что я всё забыл! 2. Пусть они не знают, что произошло! 3. Пусть она не верит их словам! 4. Пусть он больше на глаза не появляется! 5. Пусть он не рассказывает о себе! 6. Пусть они не уезжают отсюда!

Упражнение 13. Переведите пословицу на русский язык:

Хэлэхийн урьд болгоомж
 Хийхийн урьд хичээмж

Упражнение 14. Переведите на монгольский язык:

1. За последние годы производительность труда возросла на 20 процентов. 2. Это предприятие строится с помощью социалистических стран. 3. Делегация проявила большой интерес (...-г ихэд сонирхох) к тому, как идет монтаж (угсрах) оборудования. 4. «Прежде всего надо учитывать (харгалзах) наши производственные (үйлдвэрлэлийн) возможности», — сказал директор (захирал). 5. У этого цветка очень приятный запах.

Упражнение 15. Переведите на монгольский язык:

1. Рассказ, который мы будем переводить, называется «Стремление». 2. Вы обещали познакомить меня со своим приятелем. 3. К сожалению, у него нет желания учиться. 4. Посмотри на этого чудака! 5. Это была всего лишь гипотеза. 6. А теперь давайте посмотрим актовый зал (...-ын танхим)! 7. На церемонии также присутствовал посол СССР в МНР. 8. Салют (...-ын буудлага) у нас всегда начинается

в 9 часов вечера. 9. Я никогда не читаю предисловий. 10. Поверьте мне, мне, Вас ввели (... -д учруулах) в заблуждение! 11. Он умный и сильный человек; я верю в него. 12. Докладчик подробно рассказал о принятых недавно постановлениях. 13. Продолжение повести (тууж) будет напечатано (хэвлэгдэх) в июньском номере журнала. 14. Впервые я побывал в этом объединении 8 лет назад. 15. Выпейте чаю! Он снимает (тайлах) усталость. 16. В статье под названием «Армия лишних людей» говорилось о безработице в капиталистических странах. 17. Ваш знакомый сейчас работает председателем сельскохозяйственного объединения. 18. Почти все страны этого континента обрели независимость. 19. Вам необходимо стать (... -д орох) на учёт. 20. Все считают его чудачком.

УРОК 19

МОСКВА ХОТ

(Город Москва)

Москва хот бол ЗХУ-ын нийслэл юм. Москва хот дэлхийд томоохон бөгөөд гоёмсог сайхан хотын тоонд зүй ёсоор орно.

Москва хотоос туршлага болгомоор зүйл тун олон бий. Жишээ нь түүх дурсгалын зүйлийг хадгалан хямгадах, хайрлан үлдээхийн үлгэр жишээг Москвагийн өнцөг булан бүрт үзэж болно. Москвагийн төв талбайг Улаан талбай гэнэ. Энд В. И. Лениний бунхан оршино. В. И. Лениний гэсэн шарилд бараалхахаар үй олон хүн өдөр бүр цуварна.

Улаан талбайгаас холгүй «Нэр нь үл мэдэгдэх дайчинд» зориулсан мөнхийн бамбар ноцно. Энд Кремль байна. Кремльд ЗХУ-ын Коммунист Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл байрлана.

Москва сүндэрлэсэн олон барилга, өргөн уудам гудамж, цэцэрлэгт хүрээлэнгээрээ алдартай. Москвад уран барилгын түүхийг хадгалсан олон байшин, орд бий.

Москва бол орчин үеийн хот юм. Москва хот шинэчлэн өөрчлөгдсөөр, өргөжин томорсоор байна. Жишээ нь 50-аад (тавиад) оны үеийн Калинины гудамжийг одоогийнхтой зүйрлүүлэхэд эрс ялгаатай.

Москва хотын дундуур Москва гол урсана. Москва хот Зөвлөлт орны үйлдвэр, соёл, шинжлэх ухааны гол төв нь юм.

Москва хотын нэг гайхамшигт зүйл нь дэлхийд алдартай метро юм. Метро гэдэг нь нэг ёсондоо газар дорх бү-

хэл бүтэн хот бөгөөд энэ бүхэн бол зөвлөлт хүний хэдөл-мөрч, бүтээлч чанарыг илтгэн харуулж чадна.

Би Москва хотод төрсөн. Төрөлх хотдоо би маш их хайртай.

Москвэд дээд, дунд, тусгай мэргэжлийн олон сургууль бий. М. В. Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их Сургууль Лениний ууланд оршино. Би энэ сургуулийн оюутан. Би энэ сургуульд таван жил суралцана. Манай сургуульд дорно дахины хэлний олон салбар бий.

Бүтэн сайн өдөр бид Горькийн нэрэмжит Цэнгэлдэх хүрээлэнд очдог. Би ЗХУ-ын улс ардын аж ахуйн үзэсгэлэнд очиж сансар судлалын музей үзэх их дуртай. Сансар судлалын ололт амжилтдаа зөвлөлтийн ард түмэн их баярлаж, үүнийгээ зүй ёсоор бахаддаг билээ.

Москвэд үзэж харах, сонирхох зүйл их бий. Болж өгдөг бол амралтын өдөр бүр л явж юм үзэж баймаар байх юм. Гэвч тэр бүр болж өгөхгүй. Заримдаа семинарын хичээлд бэлтгэх гээд зав олодохгүй болдог.

Москва хот 1980 оны Олимпын их наадмын хот. Москва хот даян дэлхийд энх тайван, аз жаргал, эрх чөлөө, нийгмийн дэвшлийг тунхаглан зарлагч хот.

Москва хотын Лениний нэрэмжит Номын сан дэлхийн томоохон номын сангийн нэг мөн. Энд шинжлэх ухааны бүхэл салбарын орчин үеийн бүтээлтэй танилцаж болно. Москвэд дэлхий даяар нэрээ цуурайтуулсан эрдмийн их театрууд, нэрт чуулгууд олон бий.

Москвэд дэлхийн ба олон улсын биеийн тамирын том том уралдаан тэмцээн үе үе болж, эрдэм шинжилгээний их, бага хурлууд ажлаа явуулдаг.

Москва өдрөөс өдөрт өргөжин тэлсээр байгаа бөгөөд Москвагийн аль ч өнцөгт очсон ямар нэг өөр хотод хүрээд оччихсон юм шиг санагдана.

— Та Москва хотын хүн үү?

— Үгүй, би уг нь Воронеж хотын хүн. Москвэд ирж суугаад олон жил болж байна. Би Москвагийн Их сургуулийн багш хүн. Москвагийн Их сургуулийг одоогоос хорнод жилийн өмнө төгсөж, хэдөө очиж ажилламаар байсан боловч, намайг энд багшаар үлдээж ажиллуулсан юм.

— Та аль хотынх вэ?

— Би Москва хотын унаган иргэн. Энд төрж өссөн. Би Арбатин гудамжнаа төрж өссөн хүн дээ.

— Тэгвэл ч ёстой Москвагийн үндсэн иргэн юм биз дээ.

— Тийм ээ. За, би явчлаа. Баяртай.

— Баяртай, баяртай.

Слова и выражения

томоохон	— крупнейший, крупный
гоёмсог	— красивейший
зүй ёсоор	— законно
тусгаж авмаар	— желательно позаимствовать
тусгах	— отражать
туршлага	— опыт
тун (тон)	— совсем, весьма, очень, совершенно, абсолютно (усилит. част.)
хадгалах (хямгадах)	— сохранять
хайрлах	— жалеть, беречь, любить
үлдээх	— оставлять
өнцөг булан бүрт	— во всех уголках
булан (г)	— угол, уголок
бунхан	— мавзолей, гробница
гэгээ (н)	— 1) свет; 2) светлый
шарил	— 1) мумия; 2) (почтит.) тело, труп уважаемого человека
бараалхах	— быть на приеме, получать аудиенцию
үй олон	— бесчисленное множество
цуврах	— идти друг за другом, вереницей
нэр нь үл мэдэгдэх	— неизвестный
дайч (ин)	— 1) становиться известным, выявляться 2) заявлять; сообщать
зориулах	— 1) боевой; 2) воин
бамбар	— предназначать, посвящать
ноцох	— факел
нам	— гореть; загораться, зажигаться
төв	— I. партия
хороо (н)	— II. низкий; тихий, спокойный
	— 1) центр; 2) центральный
	— 1) комитет
	2) район, квартал (в городе)
	3) полк
засгийн газар	— правительство
засаг	— власть; политический строй
алдар	— 1) слава, известность
	2) почтит. имя, фамилия
уран барилга	— архитектура
ур (ан)	— 1) мастерство, художество
	2) искусный, художественный
орд (он)	— дворец
шинэчлэн	— обновляться
өөрчлөгдөх	— изменяться
өргөжих	— расширяться, расти, увеличиваться

томрох	— становиться крупным, большим; увеличиваться
тавиад он	— пятидесятые годы
ялгаа	— отличие, различие, разница
илт	— ясно, определенно
дундуур	— 1) посередине, среди, между 2) неполный, неполно
нэг үгээр	— одним словом
газар дорх	— под землей, подземный
хөдөлмөрч	— трудолюбивый
төрөлх	— родной, присущий от рождения
маш	— очень, весьма
тусгай	— особый, специальный
мэргэжил	— специальность, профессия
нэрэмжит	— имени
суралцах	— учиться, обучаться вместе с кем-либо
(соёл, амралтын	— парк (культуры и отдыха)
цэнгэлдэх	
хүрээлэн (г)	
цэнгэлдэх	— веселиться, развлекаться, наслаждаться
хүрээлэн (г)	— 1) двор, сад; 2) академия
үзэсгэлэн (г)	— 1) зрелище; 2) выставка 3) красота, прелесть
судлал	— изучение, исследование
баярлах	— радоваться
болж өгдөг бол	— если это возможно
бэлтгэх	— 1) готовиться, подготавливаться 2) готовить, подготавливать
бүтээл	— творение, создание, произведение
танилцах	— знакомиться, ознакомляться
даяар	— весь
эрдэм	— 1) образование; наука; ученость 2) искусство, умение
чуулга	— ансамбль
уралдаан	— соревнование, состязание
тэмцээн	— матч, соревнование, состязание
эрдэм	— научно-исследовательский
шинжилгээний	
их, бага хурлууд	— научные конгрессы и конференции
хурал	— собрание
их хурал	— съезд, конгресс
бага хурал	— конференция
Воронеж хотын хүн	— уроженец города Воронежа
унаган иргэн	— коренной житель

унага (н)	— 1) жеребенок до года; жеребячий 2) перен.: исконный, родной, наследственный
өсөх	— 1) расти, подрастать 2) увеличиваться
үндэс (үндсэн)	— 1) корень; корневой 2) основа, основание; основной, коренной 3) национальность, народность; национальный

Запомните пословицу!

Дундуур дундуур гээд
Долоон дундуур
Говоря, дайте немножко-немножко,
Выпросил семь раз понемножку

ГРАММАТИКА:

ПРИЧАСТИЕ ВОЗМОЖНОСТИ

(Боломжийг заах үйлт нэр)

Причастие возможности выражает такое действие будущего времени, совершение которого возможно, желательно, необходимо, допустимо или неизбежно. Суффиксом причастия возможности является —маар (—мээр, —моор, —мөөр). Например:

- яв — явмаар — можно пойти; хотелось бы пойти
ор — ормоор — можно войти; хотелось бы войти
үз — үзмээр — можно посмотреть; хотелось бы посмотреть
өг — өгмөөр — можно дать; хотелось бы дать

Это причастие субстантивации, как правило, не подвергается и управляет всеми падежами. Отрицанием служит —гүй. Например:

Ийм байж болмооргүй — Так быть не должно.

(Или: Так, как будто, не должно быть!).

Причастие возможности в предложении является либо определением (1.), либо сказуемым (2.). Например:

- 1) уучилмаар — извинительный, простительный (такой, который можно простить)
- 2) мэдэгдмээр — ощутимый, очевидный (такой, который может ощущаться, быть познанным)
- 3) нчмээр — позорный, постыдный (такой, которого следует стыдиться)

- 4) харагдмаар — видимый, зримый (такой, который может виднеться)
- 5) уярмаар — трогательный (такой, который может вызвать умиление)
2. 1) Би танаас юм асуумаар байна. — У меня к Вам вопрос. (букв.: Я хотел бы спросить у Вас кое-что).
- 2) Би Танаас юм гуймаар байна. — У меня к Вам просьба.
- 3) Би юм уумаар байна. — Я хочу пить.
- 4) Би юм идмээр байна. — Я хочу есть.
- 5) Би юм идмээргүй байна. — Я не хочу есть.
- 6) Би энэ киног үзмээр байна. — Я хочу (мне хотелось бы, я хотел бы) посмотреть этот фильм.
- 7) Бид энд дахин ирмээр байна. — Мы хотели бы (нам хотелось бы) снова побывать здесь (приехать сюда).
- 8) Та ямар баримт авмаар байна? — Какую справку (какой документ) Вы хотели бы получить?
- 9) Та хэнтэй ярилцмаар байна? — С кем Вы хотите поговорить?

Словообразовательный суффикс «-мсэг»

1. При помощи суффикса —мсэг (—мсэг, —мсог, —мсөг) от именных основ образуются имена со значением усиленного качества, приверженности к выражаемому основному. Например:

гоёмсог — нарядный, красивый (от «гоё» — красивый, чудесный)

торгомсог — шелковистый (от «торго» — шелку)

гангамсэг — франтоватый, шеголеватый (от «ганган» — франт, шеголь)

ихэмсэг — важный, высокомерный (от «нх» — великий)

хөнгөмсөг — легкомысленный, ветреный (от «хөнгөн» — легкий)

Упражнение 1. Ответьте сначала устно, а затем письменно на вопросы: Умейте рассказать текст.

1. Та Москва хотын хүн үү? 2. Та Москвагийн ямар ямар театрт орж үзсэн бэ? (были)? 3. Москва хотын үзэсгэлэнт газруудыг нэрлэ! 4. Москва хотын том том сургуулиудыг нэрлэ! 5. Москва хотод 1980 онд ямар чухал үйл явдал болсон бэ? 6. Лениний нэрэмжит номын сан хаана оршдог вэ?

Упражнение 2. Напишите небольшое сочинение на тему «Город Москва».

Упражнение 3. Переведите на монгольский язык:

1. Участники встречи хотели бы обмениваться (солилцох) опытом. 2. Вы хотели бы съездить в парк культуры и отдыха имени Горького? 3. Я хотел бы сообщить Вам одну новость. 4. Нам хотелось бы посетить Мавзолей В. И. Ленина. 5. Глава делегации хотел бы встретиться с заместителем министра. 6. По пути в город Эрдэнэт мы хотели бы побывать в городе Дархане. 7. Члены делегации хотели бы возложить венок (цэцэг өргөх) к Мавзолею Д. Сухэ-Батора и Х. Чойбалсана. 8. Я хочу познакомиться с преподавателями вашей кафедры. 9. В статье под названием «Так быть не должно» говорилось о недостатках (дутагдал) в работе предприятия. 10. В какую республику Советского Союза вы хотели бы поехать? 11. Вы хотели бы побывать во Дворце съездов? 12. Прежде всего мы хотим побывать на Красной площади. 13. Я хочу поделиться (ярьж өгөх) с вами своими впечатлениями. 14. Нам хочется посмотреть знаменитое московское метро. 15. Наши гости хотели бы побывать на выставке, которая открылась недавно в Музее изобразительных искусств им. Пушкина.

Упражнение 4. Переведите на монгольский язык:

1. Ты хотел бы выпить чаю? 2. Вы хотели бы покушать? 3. Я не хочу есть. Я хочу пить. Я бы выпил сок (шүүс) 4. Мне не хочется встречаться с ним. 5. Мне хотелось бы обсудить с Вами кое-что. 6. Вы хотели бы посмотреть документальный (баримтат) фильм? 7. Я хотел бы посмотреть какой — нибудь новый художественный (уран сайхны) фильм. 8. Ты хочешь есть? 9. Я бы съел чего-нибудь. 10. Я бы выпил кофе. 11. Мне хотелось бы услышать эту песню. 12. Мне не хотелось бы говорить об этом сегодня.

Упражнение 5. Переведите на монгольский язык:

1. Что Вы хотите купить? 2. Я хотел бы купить подарок для мамы. 3. Вы хотите спать? 4. Я не хочу спать. Я бы почитал что-нибудь интересное. 5. Мне хотелось бы перевести эту повесть (тууж). 6. Я хотел бы купить свежие (шинэ) газеты. 7. Мы хотели бы съездить на Ленинские горы. 8. Я не хочу смотреть этот концерт. Давайте пойдем в кино! 9. Вы хотите отдохнуть? 10. Я хочу немного отдохнуть. 11. Мы хотели бы купить открытки (ил захидал), конверты (дугтуй) и марки. 12. У меня к вам вопрос. 13. У меня к Вам просьба. 14. Я хотел бы купить тапочки своему сыну. 15. Вы хотели бы взять у него интервью? 16. Мне не хотелось бы отвечать на этот вопрос. 17. Я хотел бы узнать, когда прибывает поезд № 6. 18. Мне хотелось бы встретить их на вокзале. 19. Ты хотел бы остаться здесь? 20. Мне не

хотелось бы жить в этом районе. 21. Мы хотели бы отправить сына в пионерский лагерь. 22. Я хотел бы показаться терапевту. 23. Мы хотим поехать в Монголию на несколько месяцев. 24. Мы хотели бы побывать на Выставке Достижений Народного Хозяйства СССР.

Упражнение 6. Переведите на монгольский язык:

1. Я хотел бы показать вам коллекцию монгольских марок. 2. Мне хотелось бы узнать, какая разница между этими двумя словами. 3. Я хотел бы показать свою дочь окулисту. 4. Мне не хотелось бы провозжать его. 5. Я хочу спросить у вас одну вещь. 6. Мне бы не хотелось приглашать его к нам. 7. Она хотела бы пойти в театр оперы и балета. 8. Мы хотим посмотреть этот спектакль в Кремлевском Дворце съездов. 9. Я хочу сам побеседовать с ним. 10. Мы хотим погулять немного по московским улицам.

Упражнение 7. Переведите на русский язык, используя словарь.

Ч. Чимид

МОСКВА

Зөвлөлтийн түг түмэн армин
Зүүх нь болсон нийслэлээс
Өрөөн дэлхийн өнцөг буланд
Өрнөөт урна цуурайлаад

Буурал Кремлийн цогт оройгоос
Будан нэвтлэгч гэгээ мандлаа,
Монголын арвин уудам талд
Москвагийн туяа тод тийлээ.

Халхын чөлөөт их нутгийн
Хар нүдэт малчин хүү
«Хайрт Москва минь» гэж дуулаад
Хамаг сэтгэлээ илтгэхдээ

Сэрүүл Москвагийн илчиг туяанд
С. Бхан орон минь цэцэглэсэн нь
Алтан Москва, ариун Монголтой
Ах дүү болсных гэдэг юм.

1913 он

Упражнение 8. Переведите на монгольский язык:

Недавно мы совершили прогулку по Московскому Кремлю (...д аялам). Выйдя из здания ИСАА, мы прежде всего направились на Красную площадь. На Красной площади находится Мавзолей В. И. Ленина, который изо дня в день посещают (орон) многие тысячи советских людей и ино-

страши. На Красной площади также находится собор (сум) Василия Блаженного. Рядом с ним — лобное место (цаазын индэр). Самая высокая башня (цамхаг) Кремля, на которой находятся главные часы нашей страны — Кремлевские куранты (жүн) — это Спасская башня. Высота башни с рубиновой звездой (бадмарага од) — 71 метр. Стены Кремля в середине 12-го века (12-р зууны үе) были деревянными, затем — белокаменными (цагаан чулуун), а с 15-го века — кирпичными (тоосгон). На территории Кремля (Кремлийн хашаан дотор) много архитектурных и исторических памятников. Там возвышаются соборы с золотыми куполами (орой) и дрезними надписями (эртний бичиг). Там есть знаменитые Царь-пушка (Хаан-буу) и Царь-колокол (Хаан-хонх), отлитые (нутгах) в 16-м и 18-м в. в. Там находится Большой Кремлевский дворец, в котором в наши дни проходят сессии (чуулган) Верховных Советов (Дээд Зөвлөл) СССР и РСФСР (ЗСБНХОУ). На территории Кремля в 1961 году построен Кремлевский Дворец съездов, за создание которого группе архитекторов присуждена Ленинская премия, а в 1967 году — в честь 50-летия Октябрьской революции — поставлен (босгох) памятник В. И. Ленину. Вокруг (...-ий орчинд) памятника много клумб с цветами (цэцгийн мандал). С первых же дней Советской власти Московский Кремль охраняется (хамгаалах) государством. Ежегодно миллионы трудящихся страны и тысячи зарубежных гостей посещают Кремль. Он открыт для всех.

Упражнение 9. Переведите на русский язык:

«Ногоорон харагдах уул нь
 Номин эрдэнийн уул — аа!
 Ноён сайхан нуруунд нь
 Хүүтэйгээ зугаалмаар уул аа!
 Хадтай өлдөр уул нь
 Хангай дэлхийн үзэсгэлэн,
 Хажууд суусан хүү минь
 Ганцхан миний баясгалан
 Цэнхэрлэн харагдах уул нь
 Чандмань эрдэнийн уул аа!
 Цэцэрлэг сайхан ойд нь
 Чамтайгаа цэнгэмээр уул аа!
 Модтой сайхан уул нь
 Монгол газрын чимэг ээ
 Ерөөлтэй учирсан хүү минь
 Ёстой миний амраг аа ...»

(Д. Нацагдорж,
 «Учиртай гурван толгой»)

Новые слова

ногоорох	— зеленеть
эрдэнийн	— драгоценный
хад(ан)	— скала, утес
баясгалан(г)	— радость, веселье, удовольствие
чандмань	— драгоценный камень, удовлетворяющий все желания
цэнгэх	— веселиться, развлекаться;
	наслаждаться
ерөөл	— пожелание, желание блага

Упражнение 10. Переведите на русский язык, используя словарь.

Н. Банзрагч

АЛТАН ЗУЛ

(Өгүүллэг)

Хаврын үдэш Москва хотноо юутай сайхан байдгийг энд ирсэн хүн болгон ер андахгүй. Тэнгэрийг намар өвлийн турш бүрхэж байсан зузаан үүл манан гэнэт алга болж, тунгалаг наран хүчтэй шарж мод цэцэгс яах ийхийн зуур соёолон дэлбээлж, төдхөн их хот тэр аяараа ногсон модод алаг цэцэгт умбадаг билээ.

Хаврын чийглэг бүлээн салхи сэвэлзсэн намуухан үдэш Москвагийнхан хөгшин залуугүй гэрийн мухрыг огсоорон цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, Москва голын эргээр зугаалан сэлгүүцэх нь нэн элбэгшинэ. Их хотын түм буман цэхилгаан дэнлүү ярсхийн асаж, гудамж талбай, цэцэрлэг өдөр мэт саруулхан болдог. Ерөөс хавар гэдэг тэнүүн сайхан дэлгэр цагийн эхлэл, байгаль бодис шинэдэн дэлгэрэхийн сурвалж болдог билээ.

Хаврын ийм нэгэн сайхан үдэш Кремлийн арын цэцэрлэгт хүрээлэнд хүн их байлаа. Энд тэндгүй хүүхдийн баясгалант дуун хадаж, залуу эхчүүд нялх булбарай үрээ дэнжгэр тэргэнд суулгаж нааш цааш аажимхан сүлжин явна. Өвгөн улиангарын өтгөн ногоон навчис шүхэрлэсэн налуу сандал дээр жаргалтай буурлууд зэрэгцэн сууж, өнө хотын юмыг дурсаж, өнөөгийн байдлаа хэлэлцэнэ. Сэтгэлтэй болсон хос залуус бид хоёроос өөр жаргалтай амьтан энэ хөрвөөд байхгүй гэсэн шиг орчин тойронд юу болж байгааг үл анхааран залуу насны жаргал хайр сэтгэлийн амтанд автан хоёр биеэ тэвэрч янаг халуунаар озон үнсэлцэнэ. Аяа, өнөөдөр энд хүн болгон жаргалтай баясгалантай байна...

Москва—один из красивейших городов мира. В Москве много парков и скверов, широких улиц и площадей, красивых зданий и памятников. Москва-город с более чем 800 летней историей. В Москве можно отыскать много старинных улиц, домов, церквей. Вместе с тем Москва—современный город с высотными домами и гостиницами, со множеством театров, кинотеатров, музеев, выставочных и концертных залов. Все, кто приезжает в Москву, восхищаются Московским метро—целым городом под землей.

Москва — город Олимпийских Игр 1980 года, город, в котором много стадионов и великолепных спортивных сооружений.

Москва — очень чистый город. Раню утром можно увидеть сотни машин, которые чистят московские улицы. Москва—зеленый город с чистым воздухом.

Население Москвы—свыше миллионов человек. Обычно в многомиллионном городе одна из главных проблем—проблема транспорта. Но в Москве этой проблемы нет. Городской транспорт хорошо развит, в любой уголок Москвы можно попасть на метро, автобусе, троллейбусе, трамвае, такси.

В Москве развито жилищное строительство. Ежегодно десятки тысяч москвичей получают новые квартиры.

Москва — крупнейший научный центр Советского Союза. Здесь сосредоточено много высших учебных заведений и научно-исследовательских учреждений. В Москве находится Академия Наук СССР. На Ленинских горах в начале 50-х годов было построено новое здание МГУ.

А старое здание находится в центре столицы, на проспекте Маркса. В 1985 году москвичи торжественно отметили 230—летнюю годовщину основания Московского Университета.

Москва—крупнейший культурный центр страны. Здесь проходят съезды писателей, композиторов, различные фестивали. В Москву на гастроли приезжают советские и зарубежные ансамбли, театральные коллективы, артисты. Раз в два года кинематографисты всех континентов съезжаются на Московский кинофестиваль.

В Москве проходят съезды партий, международные форумы и конференции. В Москве встречаются главы государств и правительств.

Москва—мирный и гостеприимный город. В Москву приезжают много туристов. С утра до вечера они путешествуют по городу. Им хочется побывать и на Красной площади, и в Кремле, и на Ленинских горах, и на ВДНХ, и во Дворце съездов, и в Третьяковской галерее, и в московских театрах.

ЗУНЫ АМРАЛТ

(Летний отдых)

Одоо удахгүй зуны амралт болно. Бид зуныхаа амралтаар БАМ явж ажиллах саналтай байгаа. — Чи зуныхаа амралтаар хаа амрах вэ?

Би нутаг явна. Монголын зун цаг их сайхан цаг. Би хөдөө очиж аав ээждээ мал маллахад нь тусална.

— Чи хөдөө очихоороо юу хийдэг вэ?

— Би үнээ сааж, мөн гэр зуурын ажил хийж эцэг эхдээ тусална. Завтай цагтаа ном уншина. Бас хонь хариулна.

— Бид ч бас багагүй л ажилтай байх байхаа. Өнгөрсөн жил бид Казахстанд очиж барилга дээр ажилласан. Бүтээлч ажилчин хүмүүсийн дунд орж ажиллах ч ёстой л их юм сурдаг юм байна билээ.

Амрах гэдэг бол зөвхөн унтах идэхийн нэр биш. Идэвхтэй амрахыг хэлж байгаа юм. Амралтынхаа үеэр загас барих, биеийн тамир хийх, аялалд явах их сайхан. И. Л. Павлов «Наилучший отдых — это перемена занятий» гэж хэлсэн байдаг юм. Үүнийг юу гэж монголчилбол таарах вэ? Энэ ч шууд монголчлоход амар биш өгүүлбэр байна. Өргөн утгаараа бол оюуны хөдөлмөрийн хүн биеийн хөдөлмөр, бусад төрлийн хөдөлмөр хийг гэсэн үг, явцуу утгаараа бол юм бичиж сууснаа түлээ хагалах, юм уншиж сууснаа хөгжим тоглох ч юм уу янз бүрийн ажлыг сольж хийж бай. Тэгвэл дээд зэргийн амралт болно.

— Тийм юмаа, тийм юм. Үнэхээр ч амралтын өдөр агаарт цанаар яваад, дугуйгаар аялаад ирэхэд бие ядарсан мэт боловч тархи толгой сайхан амарсан байдаг шүү дээ. Бид зуныхаа амралтыг бүтээлчээр өнгөрөөж сурах ёстой. Бүтээлчээр өнгөрөөх ганц зам бол төлөвлөгөөтэй байх явдал юм. Төлөвлөгөө сайн зохиож, түүнийхээ биелэлтийн дагуу нөхдийнхөө өмнө тайлан тавьдаг байх нь чухал.

— Петров, Та зуныхаа амралтыг яаж өнгөрүүлэх вэ?

— Би энэ жил хэлний дадлага хийхээр Монгол явна. Бид Монгол Улсын их сургуультай хамтран хөдөө орон нутагт ярианы хэлний дадлага хийхийн зэрэгцээгээр аман зохиолын цуглуулга хийх юм.

— Энэ ч ёстой сайхан ажил байна даа. Аливаа гадаад хэл сурч буй хүн хэлний бодит орчинд очиж, тэр хэлээр ярилцагч хүмүүсийн дунд орж ажиллахаас илүү чухал юмгүй. Монголын судлалын нэрт эрдэмтэд ийм л замаар ажиллаж ирсэн түүхтэй.

Амралтынхаа цагаар дуу дуулж, хөгжим дарж, бүжиг хийж хөгжилдөх хэрэгтэй. Сэтгэл уярам сайхан дуу ч ёстой л хүнийг амраадаг юм. Уран уншлага ч бас сайхан. Нэг үгээр хэлэхэд амралтынхаа цагийг үр ашигтай өнгөрөөж сурах хэрэгтэй. Архи ууж тэмхн татаад, дэмий хоосон цэц булаалдах шиг хэрэггүй зүйл байхгүй. Тэгж өнгөрсөн мөч болгон хайран. Хайран өнгөрсөн мөч эргэж хэзээ ч олдохгүй. Ялангуяа хүч чадал оргилсон залуу сайхан цагаа дэмий өнгөрөөвөл хойчийн өдөр харамсаад баршгүй явдал болно. Ингэхээр зуны амралт бол зөвхөн амралт төдий биш, ажил амралт хосолсон байваас зохино. Сайхан амаръя гэвэл сайн ажилла. Ажиллаж сураагүй хүн амарч бас сураагүй байдаг.

Эрхэм оюутнууд аа!

Та бүхний амрах цаг удахгүй болно. Амралтаа идэвхтэй, бүтээлч, хөгжил баясалтай, тавтай сайхан өнгөрүүлэхийг та бүхэнд хүсэж байна.

Слова и выражения

амралт	— отдых, отпуск, каникулы
нутэг явах	— поехать домой (на родину)
мал маллах	— пасти скот, ухаживать за скотом
үнээ (н)	— корова
саах	— донть
гэр уурын ажил	— домашние дела
завтай цагтаа	— в свободное время
унтах	— 1. спать, уснуть; 2. спальный
идэвхтэй	— активный; активно
идэвх	— активность
зэгас барих	— рыбачить
аялал	— путешествие
аялах	— отправляться в путь, путешествовать
Монголчлох	— переводить на монгольский язык
амар	— 1. спокойный, благополучный; легкий, нетрудный 2. спокойно; легко, нетрудно 3. спокойствие, благополучие
оюуны	— уместный
оюун	— ум, разум; соображение; мудрость
явцуу	— 1) узкий, тесный 2) замкнутый 3) перен. узкий, ограниченный (о человеке)
түлээ хагалах	— колоть дрова

хагалах	— разламывать, раскалывать, разрывать
хөгжим	— музыка
ядрах	— уставать, утомляться
ганд	— только один, единственный; одинокий; только
төлөвлөгөө (н)	— план
биелэлт	— осуществление, выполнение
дагуу	— вдоль
тайлан	— отчет; отчетный
ярианы	— разговорный
дадлага	— практика, навык
зэрэгцээгээр	наряду
аман зохиол	— фольклор
цуглуулга	— коллекция; сбор
цуглуулах	— собирать (в одно место), коллекционировать
хэлний орчин	— языковая среда
бодит	— реальный
орчин	1. окрестность; окружение, среда
хэлээр ярилцагч	2. возле, около, вблизи, вокруг; приблизительно, около
хүмүүс	приблизительно, около
хөгжим дарах	— носители языка.
	— играть на музыкальном инструменте
дарах	— 1) давить, жать, придавливать прижимать;
	2) подавлять, побеждать;
	3) консервировать
хөгжимдөх	— веселиться, забавляться
сэтгэл уярам	— задушевный
уярам (уярмаар)	— трогательный
амраах	— успокаивать
үр ашигтай	— эффективно
үр ашиг	— результат, эффект
ашиг	— выгода, польза, доход, прибыль, рентабельность
архи	— водка
тамхи татах	— курить (табак)
тамхи	— табак
татах	— 1) тянуть, тащить; дергать, вытягивать
	2) стягивать, натягивать
	3) привлекать, манить к себе
дэмий	— 1) зря, попусту, напрасно, бестолку
	— 2) ненужный, бестолковый, пустой
хоосон	— 1) пустой, порожний; нищий

цэц булаалдах	2) пустота; нишета — дискутировать, состязаться в мудрости
мөч	— 1) (уст.) четверть часа 2) момент
хайран	— 1. затраченный зря, погибший зря 2. жаль, жалко (о погибшем, об утерянном)
эргэж олодохгүй	— не вернется (о времени)
хүч чадал	— энергия
оргилох	— кипеть, бурлить, хлокотать; клубиться; извергаться; вспыхивать.
хойч	— будущее
хойчийн өдөр	— в будущем
харамсах	— сожалеть, жалеть
төдий	— столько; столь, так
хослох	— сочетать, соединять попарно
байваас = байвал	
сурзаггүй байдаг	— здесь: не умеет
эрхэм	— уважаемый, дорогой (при обращении)
хөгжил	— 1) развитие, прогресс, рост; расцвет, подъем 2) веселье, душевный подъем, пыл
тавтай	— 1) спокойно, не тороясь; на досуге 2) спокойный; уютный
тав	— II. спокойствие; уют
...-д уриалах	— обращаться с призывом (к кому-либо), призывать (кого-либо)
урла (II)	— призыв, зов
буцах	— 1) возвращаться, вернуться, идти обратно 2) отречься

Запомните пословицу

Тугалган жад шантрахдаа амархан
 Туйлбаргүй хүн буцахдаа амархан
 Оловянный штык легко сбивается
 Нерешительный человек легко отрывается

ЖЕЛАТЕЛЬНАЯ ФОРМА (ФОРМА ПОЖЕЛАНИЯ) ВСЕХ ЛИЦ

(1. 2. 3-р биеийн мөрөөдөн хүсэх хэлбэр)

Форма пожелания всех лиц имеет суффикс —**аасай** (—**ээсэй**, —**оосой**, —**өөсэй**). Отрицанием является **бүү**.

Эта форма означает страстное (зачастую-тщетное) желание, чтобы действие, выраженное глагольной основой, было совершено.

Форму пожелания всех лиц следует переводить на русский язык оборотами «Хорошо было бы, если б...», «Хорошо бы...», «(О, ах) если бы...», «Только бы...», «(Сделать) бы (что —то)!» и. т. п.

Например:

1. Тэр намайг хүлээгээсэй! — Подождал бы он меня!

2. Би чамайг зөв ойлгоосой гэж бодож байна. — Я хочу, чтобы ты правильно (меня) понял.

3. Бусад улс орон ч ингээсэй гэж бид хүсэн хүлээж байна. — Этого мы ждем и от других стран (букв.: Хорошо было бы, если б и другие страны так поступили).

4. Харин ээж нь пальтогий нь үзээд ганц орой углэлгүй өнгөрөөсэй! (Ч. Алгаа, «Тэмүүлэл») — Ах, если бы (его) мама, увидев (его) пальто, хоть один вечер помолчала бы! (букв. ... провела единственный вечер, не ругая (его) (Ч. Алгаа «Стремление»).

5. Хүндтэй хувьтай бяцхан иргэдийн Хүсэлтэй инээд хөгжиж байгаасай! (Н. Жамбалсүрэн, «Хүүхдийн инээд») — Только б раздавался желанный смех Маленьких граждан с достойной судьбой! (Н. Жамбалсүрэн, «Смех детей».)

6. Өөрийн биед хоёр жигүүртэй болоосой,

Даруй нисэж чамдаа очих юм сан.

(Д. Нацагдорж, «Мөрөөдөл», 1931)

— Иметь бы крылья —

Сразу бы полетел к тебе. (Д. Нацагдорж, «Тоска», 1931).

Словообразование: суффиксы «-аа (н)», «-м»

1. При помощи суффикса **-аа (н)** **-ээ (н)**, **-оо (н)**, **-өө (н)** от глагольных основ образуются имена со значением:

а) результата или процесса действия (если основа-непеходный взаимный или совместный глагол);

б) предмет, на который направлено действие, или предмет, служащий для совершения действия (если основа-переходный глагол);

в) качество, вызванное действием;

г) место, где происходит действие. Например:

- алалдаан — бойня, побоище, стражение (от «алалдах» — убивать друг друга, биться, сражаться)
- тулалдаан — стычка, столкновение; схватка, бой, борьба (от «тулалдах» — сражаться, препираться)
- хэлэлцээ (н) — переговоры (от «хэлэлцэх» — обсуждать)
- оролцоо — участие (от «оролцох» — участвовать)
- цуглаан — митинг, сходка (от «цуглах» — собираться, сходиться)
- хувилгаан — перерожденец (от «хувилгах» — перерождаться)
- шүтээн — святыня, предмет поклонения (от «шүтэх» — поклоняться)
- атираа — морщина, складка (от «атирах» — морщиться, свертываться)
- бөглөө (н) — пробка; тампон (от «бөглөх» — затыкать)
- хүрхрээ — водопад (от «хүрхрэх» — рычать)
- ачаа (н) — груз (от «ачих» — грузить)
- түлээ — дрова (от «түлэх» — растапливать, жечь)
- хэмжээ (н) — мера; размер; объем; уровень; мероприятие (от «хэмжих» — мерить)
- санаа — мысль; идея; намерение (от «санах» — размышлять)
- идээ (н) — еда, пища (от «ирэх» — есть)
- чалчаа — болтливый, болтун (от «чалчих» — болтать)
- нуршаа — надоедливый (от «нурших» — надоедать)
- хаваржаа (н) — веселее стойбище (от «хаваржих» — проводить весну)
- өвөлжөө (н) — зимняя стоянка, зимовка, зимник (от «өвөлжих» — зимовать, проводить зиму)

2. При помощи суффикса —м от глагольных основ образуются имена со значением результата или меры действия; предмета, на который направлено действие. Например:

- булаам — захват (от «булаах» — брать силой)
- гарам — брод, переезд (от «гарах» — переходить, переезжать)
- тоглоом — игра, игрушка (от «тоглох» — играть)
- хэрчим — полено, кусок (от «хэрчих» — нарезать)
- зүсэм — ломоть, кусок (от «зүсэх» — резать ломтями)
- алхам — шаг (от «алхах» — шагать)
- барим — мера, равная ширине ладони (от «барих» — брать)
- хөгжим — музыка (от «хөгжих» — веселиться)

Упражнение 1. Ответьте устно и письменно на вопросы. Умейте
рассказать текст.

1. Зуны амралт хэдийгээс эхэлдэг вэ?
2. Та зуныхаа амралтыг яаж өнгөрөөх гэж байна?
3. Амрана гэдэг юу гэсэн үг вэ?
4. Бүтээлчээр, идэвхтэй амарна гэж юу гэсэн үг вэ?
5. Амарч ч чаддаг, ажиллаж ч чаддаг хүн гэж ямар хү-
нийг хэлэх вэ?
- Тийм хүний тодорхой жишээ гарга!
6. Та хэдийд, хаана яаж бүтээлчээр амарснаа ярина уу?

Упражнение 2. Составьте предложения со следующими словами и
выражениями.

1. Зөв боловсон амрах. 2. Зуны амралт. 3. Дуу дуулж,
бүжиг хийж. 4. Эрүүл биед саруул ухаан оршино (В здоро-
вом теле-здоровый дух). 5. Наранд биеэ шарах (загорать
на солнце) 6. Эрүүл агаарт явж 7. хичээлийн жил дуусаж
8. Загас барих 9. Хэлний дадлага хийхээр.

Упражнение 3. Переведите на русский язык.

1. Хол газар явж, хүн амьтантай танилцаасай. Эрдэм
ном үзэж, нүд тайлаасай гэж би хүүгээ алс газар сургуульд
явуулсан билээ.

2. Чи миний сэтгэлийн зовлонг ойлгодог ч болоосой доо
гээд Тунгалаг санаа алдав.

3. Одоо нэг долоо хоног бороо ороосой. Тэгвэл газрын
өнгө мөн сайхан болноо доо.

4. Ийм чухал үед аав минь ирээсэй билээ.

5. «Болжмор шувуу шиг ч болоосой!

Хоёр жигүүр ч ургаасай!

Хойноос нь нисэж очоод,

Хамаг зовлонгоо тоочих сон»

(Д. Нацагдорж,
«Учиртай гурван толгой»).

6. Ганцхан хүсэх юм. Энэ ертөнц энх амгалан л байдаг
болоосой. Манай үр ач нар эгнэгт энх цагт амьдраасай гэв.

(С. Эрдэнэ,
«Энх амгаланг мөрөөдөгч»).

7. ... Яруу найргийн мөрт минь
Ямагт хавар л байгаасай.

(Д. Тарва, «Хавар»)

Упражнение 4. Переведите на русский язык, используя словарь:

Хүн ирээ хүн чамд минь дурлаасай
 Харин минь амин тун захидал бичээсэй
 Захидалаахнаа үг болгонд тэр хүн
 Заяа ниргалын дээднийг амласан байгаасай
 Амьдрал дурлалаа ганцхан чамд зориулан
 Алган дээрээ эрхдүүнэн энхрийлнэ гээсэй!
 Тэгэх тусам л чамайгаа бусдаас харамлана даа, би.
 Тэмүүлэх сэтгэлдээ намайгаа улам л хайрлана даа, би.
 Хүн ирээ хүн бүсгүй намайг дурсаасай
 Харин минь амин учрах болзоо тогтоогоосой.
 Үдэн дээр бүрийгээр тулзах тэр үедээ
 Үнэн дээр өрөвчтөн үгээ дэлгээсэй
 Хамаг бүхнээ ганцхан надад зориулан
 Халуун зүрхэндээ халамжлан явна гээсэй
 Тэгэх тусмаа л намайгаа бусдаас харамлана даа, чи.
 Тэмүүлэх сэтгэлдээ намайгаа улам л хайрлана даа, чи.

Упражнение 5. Переведите на русский язык, используя словарь.

Сайхан бүсгүйг нил харж гэнэ
 Аргаа алдан ингэж бодож гэнэ:
 "Болгөр нугад хэнзэлсэн нил би
 Талбээ юугаа дэлгэсэн ч болоосой!
 Амин зуур ч бол амраг бүсгүй
 Зүрхэндээ тэврэн хайрлаасай
 Аятай гараараа намайг тастаасай!»...

(Гёте, «Нил цэцэг», 1773 он.
 Орчуулсан Б. Явуухулан)

Упражнение 6. Переведите на русский язык, используя словарь:

МОРИН ХУУР

Эрт үед цагт сайн морьтой сайхан монгол эр байжээ. Сайн морьт нь Жонон хар гэдэг байжээ. Тэгээд арга буюу Жонон хар морь нь өтөлж үхжээ. Мориндоо хайртай тэр монгол эр, сайн морио үүрд дурсаж явъя гэж шийдээд сүүлчээ нь хоёр бут хялгас авч хоёр чавхдас хийж толгойг нь тэргүүн болгон залаад тэр хөгжмөө «Морин хуур» гэж нэрлэн хоёрхон чавхдасаар ертөнцийн зовлон жаргалыг эгшиглүүлдэг болжээ. Ингэж морин хуур үүссэн домогтой, морин хуур бол монгол үндэсний бахархал болох хөгжмийн шилдэг зэмсэг мөн.

Энэ хөгжмөөс үзэхэд монгол хүн морь хоёр эрт дээр үеэс хэчнээн ойр дөт байсан нь илэрхий. Эр хүний нөхөр, эмээлт хазаарт морь гэж зүйрлэн хэлэлцдэг. Дэлхийн бүх оронд насанд хүрэгсэд морь унаж уралдуулдаг бол гагцхүү Монголд арваадхан настай хүүхдүүд морь унаж уралдуулдаг билээ.

1. Прежде всего следует сказать об идее (гол...) этого произведения. 2. Он намерен (...тай) поехать работать в худон. 3. На вчерашней пресс-конференции (хэвлэлийн...) он заявил, что они намерены подписать (...-т) гарын үсэг зурах) это соглашение (хэлэлцээр). 4. В течение нескольких месяцев мы вели переговоры (...хийх) и скоро подпишем соглашение о сотрудничестве. 5. Вчера здесь состоялась прессконференция с участием советских и иностранных журналистов. 6. На митинге присутствовали (...-д оролцох) председатель исполкома (гүйцэтгэх захиргаа) Союза обществ мира и дружбы Монголии (МЭТНБХ)..., заместитель заведующего (орлогч эрхлэгч) отделом (хэлтэс) ЦК Партии..., ответственные работники (ажилтнууд) Министерства иностранных дел МНР и другие официальные (албаны) лица. 7. Председатель демократического фронта призвал народ быть готовым (...-д бэлэн байхыг) к решающей (шийдвэрлэх) схватке (...хийх) со сторонниками хунты. 8. Я хотел бы узнать, каков у вас грузооборот (...-ны эргэлт). 9. Наш завод выпускает только грузовые автомобили. 10. Мы хотели бы съездить к этому знаменитому водопаду. 11. Государства-члены ООН стремятся к осуществлению конкретных мер в области ограничения гонки вооружений. 12. В теплое время года монголы угощают (...-д барих) гостей своими молочными продуктами. 13. Вы любите молочные продукты? 14. Ты выступишь на митинге? 15. Мы намерены провести с ними переговоры. 16. С наступлением холодов переедем на зимовку.

Упражнение 8. Переведите на монгольский язык:

1. Мы хотели бы побывать на выставке детских игрушек. 2. Это, оказывается, был игрушечный пистолет (...-ын гар буу). 3. Вы читали работу В. И. Ленина «Шаг вперед, два шага назад» (нэг... урагшаа, хоёр... хойш)? 4. Консерватория (...-ийн дээд сургууль) находится недалеко от ИСАА, на улице Герцена. 5. Сегодня в Доме композиторов (...-ийн зохиолч) состоится концерт, посвященный годовщине провозглашения МНР. 6. Дайте нам, пожалуйста, три куска хлеба (...талх)! 7. Морин хуур-это национальный музыкальный инструмент. 8. Практические шаги (...хийх нь) в этом направлении (чиглэлээр) служили бы (...-т тус дөхөм үзүүлэхсэн билээ) интересам урегулирования (зохицуулах) назревших (тулгамдсан) проблем. 9. Существенные (эрс чухал) шаги в этом направлении могут быть сделаны на сессии (чуулган) Генеральной Ассамблеи ООН. 10. Говорят, он собирается поступать в Консерваторию. 11. Расскажите, пожалуйста, о жизни и творчестве этого композитора. 12. Де-

душка· сказал, что купить ему игрушечное ружье. 13. В свободное время я люблю слушать музыку.

Упражнение 9. Переведите на русский язык:

Ц. Дамдинсүрэн

АЛДАГДСАН АЗАРГА

Хотын нэгэн оюутан, зуны амралтаар нутагтаа харьж гэнэ. Энэ бол хориод настай хүү байжээ. Чухам нэрийг хэлэхээ байа. За Өлзий нэртэй юм болог. Гэр нь баян айл тул олон адуутай юм байжээ. Өлзий хариад адуунд явдаг болжээ.

Хэдэн жил сургуульд явсан тул адууг бүрнээ танихгүй, иймд азаргын тоогоор адуугаа бүртгэж явдаг билээ. Азарга нь бүрэн байвал адуу нь бүрэн гэж боддог байв. Азарга бүр арав хориод гүүтэй, нэгэн сүрэг болж тусгай явдаг тул мөн азаргаараа адууг бүртгэж болоод байв.

Өлзий, нэгэн өглөө бэлчээрлэсэн адуугаа хурааж азаргануудаа бүртгэвэл алаг азарга нь байдаггүй. Иймд бүх адуугаа Цагааннуурын хөвөөнд авчирч орхиод алаг азаргатай адуугаа эрэхээр явав.

Өлзий, шил талыг шүүрдэн, дов хонхрыг нэгжин эрэн эрсээр өдөр турш явавч ер олсонгүй. Тэр нутагт айл олон тул адуу бас олон. Ямар нэгэн алагтай адуу харагдвал нүдээ хөхөртөл ширтэн горьдсоор очно.

Гэтэл тэр адуунд гүү буюу алаг морь байна. Эсвэл ердөө алаг адуугүй, харин хар цагаан хоёр зүсмийн морь давхарлан байгаад алаг адуу мэт харагдсан байна. Үдэш болоход Өлзийн унасан морь арайхийж хөлөө солбино. Адуучин Өлзий гашуудалтайгаар буцаж морио юүлж унаад дахин эрье гэж адуундаа ирвэл тэнд олон хүн морио юүлэн унаж байна.

Өлзийн эцэг:

— Чи яагаад ингэж удав гэж асуувал Өлзий цухалдаж хэлсэн нь

— Яагаад удав гэж та юу хэлж байна? Алаг азаргатай адуу алга болоод бүр эрж олсонгүй. Хулгай авсан буюу чононд идэгдсэн биз ээ гэвэл эцэг хэлсэн нь:

— Чи ямар морь унаж явна гэхэд Өлзий мориноос бууж үзвэл, алаг азарга нь хариугүй зүдэрч, толгойгоо унжуулсан зогсож байна. Өлзий алаг азаргаа унаад алаг азаргатай адууг байсаар атал өдөр турш дэмий эрсэн байжээ.

1943.

Новые слова

алдагдах
азарга (н)

— потеряться, быть упущенным
— 1. жеребец

	2. в сочетании с названиями животных-самцов
харих	— возвращаться, вернуться
хориод	— около двадцати
байх	— ... 4) с винит. п. причастия буд. времени-переставать что-л. делать, прекращать
бүртгэх	— проверять, наличие, учитывать, брать на учет, регистрировать
сүрэг	— стадо; стая
тусгай	— 1) особый, специальный 2) отдельный
бэлчээрлэх	— пастись, находиться на пастбище
бэлчээр	— пастбище
алаг	— пестрый, разноцветный; пегий (о масти)
орхих	— 1) оставлять, покидать 2) бросать, отбрасывать, откидывать
шил	— П. плоскогорье, пригорок
шүүрдэх	— прочесывать (местность), выискивать
дов	— бугор, холмик, кочка
хонхор	— впадина, углубление, рытвина, ухаб
нэгжих	— обыскивать, производить обыск
хөхрөх	— синеть
ширтэх	— устремлять глаза, вливаться глазами; следить, не спуская глаз
горьдох	— надеяться, ожидать
гэтэл	— но, однако (противит. союз)
зүсэм	— I. масть II. кусок, ломоть
давхарлах	— удваивать, класть одно на другое
арайхийж	— кое-как, едва, с трудом
солбих	— скрещивать, переставить
гашуудал	— печаль, скорбь, траур
юүлэх	— 1. переливать, пересыпать 2. менять (лошадей)
цухалдах	— 1) быть узким, тесным 2) нервничать, раздражаться, сердиться
хулгай	— 1) воровство, кража 2) вор, бандит
чоно (н)	— 1) волк; 2) волчий
идэгдэх	— быть съеденным
биз	— наверное, вероятно, видимо, пожалуй (модальная частица)
харну (н)	— 1) ответ; возврат 2) ответный

хариугүй

— 1) безответный

унжуулах

2) никудашный, безнадёжный, плохой
— свесить (ноги), повесить (голову)

Упражнение 10. Перескажите текст «Алдагдсан азарга», используя новые слова.

Упражнение 11. Переведите пословицы на русский язык:

1. Ядрах цагт нөхрийн чанар танигдана.
2. Худал үг хулгайтай адил
Хуурамч хайр хөөстэй адил
3. Бэлчээр сайтай бол мал тарган
Бэх сайтай бол бичиг тодорхой
4. Ажилд дадлага хэрэгтэй
Ачаанд татлага хэрэгтэй

Упражнение 12. Переведите на монгольский язык:

1. Приехал бы он домой на каникулы! 2. Помог бы он родителям! 3. Подождали бы вы меня! 4. Помог бы ты нам ухаживать за скотом! 5. Пошел бы дождь! Тогда (тэгвэл) станет прохладно. 6. Пошел бы снег! Тогда покатаемся на лыжах. 7. Стало бы тепло! Тогда поедем на дачу. 8. Хорошо было бы, если б он съездили туда на практику! 9. Я хочу, чтобы вы правильно меня поняли. 10. Приехал бы мой отец сейчас! 11. Жили бы мы всегда вместе! 12. Был бы мир на земле! 13. Ах, если б ты понимал меня! 14. Ах, если б он мне позвонил! 15. О, если б я знал это! 16. Только бы увидеть ее! 17. Только бы он учился хорошо!

Упражнение 13. Переведите на монгольский язык:

1. Скоро наступят летние каникулы. Где вы собираетесь отдыхать? 2. В этом году мы целый месяц будем работать на стройке, а потом поедем на Кавказ. 3. А я хочу проехать с родителями в Прибалтику (Балтийн тэнгисийн орчин). 4. Я, наверное, буду отдыхать на даче. Буду кататься на велосипеде, читать книги, слушать музыку. 5. Во время летних каникул я обычно путешествую со своими друзьями. 6. Дорж, а ты как проведешь летние каникулы? 7. Я поеду на родину. Отправляюсь в худон и буду помогать родителям пасти скот, а также, в домашних делах. В свободное время буду читать, заниматься спортом. 8. Во время отдыха нужно петь, танцевать, веселиться. Но летние каникулы — это не только отдых. Хочешь хорошо отдохнуть-поработай хорошо. 9. Одним словом, нужно учиться проводить свои каникулы с пользой. 10. Кто не умеет работать, тот не умеет и отдыхать. 11. Человеку умственного труда время от времени следует заниматься физическим трудом. 12. «Наилучший отдых-это перемена занятий».

НӨХРИЙН АЧИЙГ БОДОГЧ

(Шидэт үлгэр)

Эрт урьд цагт нэг ядуу хүү байжээ. Алс холын нутагт нэгэн мэргэн лам байна гэж тэр сонсоод яавал эрдэм ном сурч болох тухай мэргэлүүлэхээр явж гэнэ. Гэтэл замд нь нэгэн ядуу хүн тохиолдож,

— Яавал энэ ядуу зүдүүгийн зовлонгоос ангижирч болохыг ламаас асуугаад ирээрэй гэж гуйжээ. Цаашаа явж байтал нь нэг баян хүн дайралдаж,

— Би ганц сайхан охинтой юм сан. Тэр минь арван найман нас хүртлээ нэг ч удаа дуугарсангүй. Яавал хэлтэй болохыг ламаас асуугаад ирнэ үү? гэж захижээ. Тэгээд цаашаа явж байтал нэг аварга могой тааралдан,

— Намайг мянган жил болоод луу болно гэсэн юм. Гэтэл би мянган жил болсон боловч могой хэвээрээ байна. Үүний учрыг мэргэн ламаас асууж өгнө үү? гэжээ.

Ядуу хүү цааш олон сар жилээр явган нүцгэн ядарч зүдэрсээр явж уг зорьсон газраа хүрч, нөгөө мэргэн ламтай учран золгожээ. Тэгээд өөрийн хэргээс бусдынхыг чухалчлан хамгийн түрүүнд ядуу хүний тухай ярихад нь:

— Тэр ядуу айлын зүүн хойно ганц хайлаас байгаа юм байна. Түүний доор нэг тэвш эрдэнэ байна. Түүнийг авбал ядуу зүдүүгийн зовлонгоос сална гэж лам хариулав.

Дараа нь баян хүний хүсэлтийг айлтгасанд:

— Заяаныхаа ханийг хармагц тэр охин аяндаа дуугарах болно. Санаа зовох явдалгүй гэв.

Аварга могойн тухай хүүг асуухад:

— Түүний толгойд молор эрдэнэ байгаа юм байна. Тэр могойн гавлыг нь цоолж эрдэнийг авбал луу болно гэжээ. Эцэст нь хүү өөрийнхөө тухай асуухад нь:

— Би нэг хүнд жилдээ гуравхан удаа мэргэлдэг тул чиний тухай одоогоор мэрэглэх боломжгүй байна гэж лам хэлж гэнэ. Хэрэв хүү өөрийнхөө тухай мэргэлүүлэх ахул даруй дахин нэг жил хүлээх байсан боловч, юуны өмнө нөхдийн тусыг бодож буцахаар шийджээ. Эргэж ирээд аварга могойтой уулзаж ламын айлдсаныг хэлэхэд, тэр могой би луу л болбол миний хүсэл сая хангагдах болно. Иймд миний толгойд байгаа эрдэнийг та аргагүй авч аль хэмээн гуйж гэнэ. Тэгэхэд нь нөгөө хүү могойн толгойг цоолж өнөөх эрдэнийг авсанд могой луу болон хувирч, тэнгэрт солонго татуулан гарч гэнэ. Ядуу хүү өнөө эрдэнийг гар дээрээ өргөн барьтал, өөрөө гэнэт таж магнай дээлтэй, тансар хилэн малгайтай, тавхгар луучин гуталтай, тангад мон-

гол ном мэддэг тийм эрдэмтэй сайхан хүү болж гэнэ. Хүү ихэд баярласандаа өнөө баян хүнд ламын айлдсаныг хэлэхээр гадаа нь очтол, баяны охин тэр хүүг хармагц, тачигнатал инээд алдав гэнэ. Хүү баян хүнд нөгөө ламын айлдсаныг нэгд нэггүй тоочин хэлсэнд, охины урам зориг улам бадарч, ам уралдан ярив гэнэ. Охиноо ийнхүү хүүрнэн ярьсанд эцэг эх хоёр нь ихэд баярлажээ. Хүү тэндээс явж ядуу хүн дээр ирж хайлаасны дор байгаа тэвш эрдэнийг авч өгч гэнэ. Тэгээд хүү баян хүний гоо үзэсгэлэн бүхий охинтой айл гэр болон амьдарч, амар сайхан жаргаж гэнэ.

Хэл зохиолын хүрээлэнгийн ар-
дын аман зохиолын хөмрөг,
Дундговь аймгийн Сайн ца-
гаан сумын Сэрээтэрийн Лув-
сангийн үлгэрийн цуглуулга:
1965 он (Монгол ардын үлгэр-
ээс)

Упражнение 15. Перескажете сказку «Нөхрийн ачийг бодогч».

Упражнение 16. Переведите на русский язык, используя словарь:

ДАЛАН ХУДАЛЧ

(Шог хошин үлгэр)

Эрт урьд Бэлэнсэнгэтэй толгой дээрээ тогоо тавьсан нэг хүн уулзаад,

— За Далан худалч гуай намайг нэг хуураад орхи! гэж тэр хүн хэлж гэнэ. Тэгэхэд нь:

— Чамайг хуурах байтугай тэнгэрт түймэр шатаад сүйд болж явна гэж Бэлэнсэнгийг хэлэхэд:

— Нээрэн үү? гээд гэнэт дээшээ харвал, толгой дээрх тогосгоо газар унаган хагалж гэнэ.

Эрдэмтэн П. Хорлоогийн, цуг-
луулгаас авав. («Монгол ар-
дын үлгэр»-ээс)

ГАХАЙ ХАРИУЛАГЧ, НОМЧ ЛАМ ХОЁР

(Шог хошин үлгэр)

Урьд, хааны нэг хүү би их эрдэм номтой лам болно. На-
дад хэдэн тэмээн тэрэг, нэг дээлийн шар торготой өгнө үү?
гэж эцэгтээ хэлжээ. Хаан аав нь хүссэн бүх зүйлийг нь хүү-
дээ бэлтгэн өгч гэнэ. Хааны хүү алс хол явж ном сурах

гэсэн боловч, юу ч сурсангүй харин хэдэн тэмээ тэргээ үрэн таран хийж, нөгөө шар торгоороо нэг сайхан лам дээл хийлгэж өмсөөд,

— Би эрдэм ном их сурч ирлээ гэж эцэгтээ хэлж гэнэ.

Хаан аав нь их номтой сайн лам болж ирсэнд нь баярлаад хүүдээ тусгай гэр өргөө барьж өгч гэнэ. Хааны хүүг эрдэм ном их сурсан гэж нутгийн нэгэн номч лам сонсоод түүнтэй ном хаялцахаар зөвшөөрөл эрсэнд хаан аав нь дуртай зөвшөөрч энэ тухай хүүдээ мэдэгдэж гэнэ. Гэтэл үүнийг сонсоод ном сураагүй хааны хүү одоо яадаг билээ гэж аргаа барж ичихдээ үхэр хариулдаг өвгөндөө ирж үнэн учраа хэлбэл, би чамд юугаа хэлэх вэ? Харин танай гахай хариулдаг тэнэг хүү чамд ямэр нэгэн тус хүргэж магадгүй гэжээ. Тэгэхээр нь хааны хүү нөгөө гахай хариулагч тэнэг хүүг дуудаж ирүүлээд, түүнд шар торгон дээлээ өмсгөж, өөрийнхөө өргөөнд үлдээж гэнэ.

Их номтой лам хааны хүүгийн гэрт хүрч ирээд, гахайчин хүүг номтой лам гэж бодоод гурван хуруугаа гозойлгосонд хариуд нь таван хуруугаа гозойлгож гэнэ. Номтой ламыг дэлэм дэлмээр алдлан заахад нь гахайчин хүү хариуд нь алд алдаар алдалж гэнэ. Номтой ламыг чихээ заахад нь гахайчин хүү бүтэн цээжээ зааж гэнэ. Гэтэл өнөө номтой лам үг ч дуугарсангүй буцаад явжээ.

Үүний дараагаар хаан хүү орж ирээд гахайчин хүүгээс тэр лам чамд юу гэж хэлэв гэхэд нь:

— Миний сайн тарган гахай бүрийг гурав гурван цэн мөнгөөр авъя гэхээр нь би тав таван цэн гэв. Тэр ламыг дэлэм хошног нэмье гэхэд нь би алд хошног нэм гэв. Тэгэхэд минь гахайн тарга чихэндээ байдаг уу? гэж асуухад нь би үгүй ээ, цээжиндээ байдаг юм гэсэнд тэр лам толгой сэгсрэн юу ч хэлсэнгүй шууд явж одов гэжээ.

Гэтэл бас номч лам гэртээ очоод,

— Би тэр ламтай гурван тивийн ном ярья гэхэд тэр үгүй, таван тивийн ном ярина гэв. Би бага багаар ярья гэж дэлэм дэлмээр алдлахад тэр, ихээр ярина гэж бүтэн алдаар алдлахад нь би чихэндээ сонссон бүгдийг ярья гэж хэлсэнд тэр лам цээжиндээ байгаа бүхнийг ярина гэв.

Хааны хүү бол хосгүй их эрдэмтэй хүн юм байна. Иймд би түүнтэй үнэхээр ном хэлэлцэх аргагүй болсон тул буцаж ирэв гэж нөхдөдөө ярьж гэнэ.

Хэл зохиолын хүрээлэнгийн ардын аман зохиолын хөмрөг, Б. Лхамсүрэнгийн үлгэрийн цуглуулга.

(«Монгол ардын үлгэр-ээс»)

Упражнение 17. Перескажите сказки «Далан худалч» и «Гахай хариулагч, номч лам хоёр».

Упражнение 18. Переведите на монгольский язык.

1. Хорошо бы порыбачить тут! 2. Хорошо бы посмотреть эту коллекцию! 3. Хорошо бы заехать туда на обратном пути! 4. Хорошо бы искупаться там! 5. Хорошо бы здесь отдохнуть! 6. Хорошо бы найти эту пластинку! 7. Хорошо бы достать билеты в театр! 8. Хорошо бы сходить за грибами! 9. Хорошо бы послушать музыку! 10. Ах, если б он вернулся! 11. Поехать бы сейчас домой! 12. Посмотреть бы этот фильм! 13. Достать бы билеты на этот спектакль! 14. Сдать бы этот экзамен! 15. Только бы услышать твой голос! 16. Иметь бы крылья! 17. Остаться бы тут дней на десять! 18. Было бы хорошо если б они приехали к нам втроем! 19. Было бы хорошо если б ты позвонил нам оттуда! 20. Послушать бы, как она поет! 21. Посмотреть бы, как он танцует! 22. Узнать бы, где они живут! 23. О, если б я видел это! 24. Приехала бы она десятого числа! 25. Прилетели бы они первого числа! 26. Помог бы он мне перевести эти предложения! 27. Если бы найти его адрес! 28. Если б он нас встретил! 29. Знать бы, где его искать! 30. Купить бы ей такую игрушку! 31. Познакомиться бы с ними! 32. Поработать бы там летом! 33. Съездить бы в Монголию на практику! 34. Поездить бы по стране!

ПОВТОРЕНИЕ

Упражнение 1. Переведите на монгольский язык:

1. На каком этаже находится ваша кафедра? 2. Во сколько должен прибыть поезд из Дархана? 3. Когда ты поедешь в Эрдэнэт? 4. Она, оказывается, стала врачом. 5. Какие словари вы взяли в библиотеке? 6. Тебе пора понять это. 7. Сколько человек будет обедать? 8. Встретьте, пожалуйста, его на вокзале завтра утром. 9. Покажите, пожалуйста, эту большую книгу. 10. Сколько красных ручек? 11. Сколько наших шкафов? 12. Сколько здесь столов? 13. Сколько тетрадей надо купить? 14. Она должна приехать пятого. 15. Наш поезд прибудет в пять. 16. Прочтите, пожалуйста, последнее предложение. 17. Сходите в библиотеку и возьмите эти два словаря. 18. Кому ты отдал мою тетрадь? 19. Дайте мне, пожалуйста, свежую газету. 20. Как сделать это упражнение? 21. Сделайте это упражнение устно. 22. Можно войти? 23. Войдите, войдите. 24. Где работает твоя старшая сестра? 25. Почему ты сидишь тут? 26. Зачем вы туда идете? 27. Почему вы не сделали домашнее задание? 28. С кем ты завтра пойдешь в театр? 29. Кто напишет это слово на дос-

ке? 30. Вам не надо переводить этот текст. 31. Вы ещё не выучили новые слова? 32. Я не могу его встретить. 33. Она не может здесь жить. 34. Напишите, пожалуйста, свои имя и фамилию. 35. Ну, пора ехать. 36. Ну, пора кушать. 37. Откуда ты взялся? 38. Приходите завтра! 39. Сходи сейчас! 40. Мы еще не написали это предложение. 41. Ручка не пишет. Чернила кончились. 42. Вам надо хорошо читать, писать и говорить по-монгольски.

Упражнение 2. Переведите на монгольский язык:

1. Вы можете послать ему телеграмму. 2. Можно взять Вашу книгу? 3. Ты ещё не прочел письмо? 4. Пойдемте-ка в гостиницу! Там есть хороший ресторан. 5. Дазайте пообедаем в нашей столовой! 6. Она, оказывается, стала официанткой. 7. Счастливого пути! 8. Счастливо оставаться! 9. Запишите домашнее задание! 10. Пишите новые слова! 11. Вы сможете перевести этот текст? 12. Прочтите, пожалуйста, этот диалог. 13. Мне не нужен этот журнал. 14. Надо купить эти цветы. 15. Сядьте здесь! 16. Ты поел? 17. Нет, еще не поел. 18. Во сколько ты пойдешь в кино? 19. Что вы купили в книжном магазине? 20. Здесь нельзя сидеть. Сядьте, пожалуйста, там. 21. Мы встретимся, немного посидим и вспомним прошлое. 22. Вы говорите по-монгольски? 23. Да, я могу говорить по-монгольски. 24. Я не могу перевести это предложение. 25. Можно взять этот карандаш? 26. Можно, возьмите. 27. Он пришел? 28. Нет, он еще не пришел. 29. Сейчас он обедает. 30. Какой плохой мел! У вас есть другой мел? 31. Пришел старший брат, а младший ушёл. 32. Возьми эту книгу в нашей библиотеке. 33. Кто будет читать текст? 34. Где вы взяли этот журнал? 35. Что он тебе подарил? 36. Приезжайте к нам снова! 37. Встань и закрой форточку! 38. Во сколько ты встал? 39. Мы пошли в ресторан, а они пошли в кино. 40. Поздравляем с праздником! 41. С новым годом! 42. Прочти этот текст! 43. Я взял мел и написал на доске это предложение. 44. Он писал письмо, а я читала газету. 45. Он переводил стихотворение, а мы диалог. 46. Мы встаем в 7 часов утра, а в 8 часов идем на работу.

Упражнение 3. Переведите на монгольский язык:

1. Почему ты не читаешь? 2. Почему он не пишет? 3. Не закрывайте окно! 4. Мы не закрываем окно. 5. Почему он к нам не приходит? 6. Обычно мы занимаемся 6 часов в день. 7. Ну, я пошел. 8. Пойдем вдвоем! 9. Она приходит с работы в 7 часов вечера. 10. Мой муж еще не приехал из художона. 11. Его приятель еще не поступил в институт. 12. Окончив университет, я стану востоковедом. 13. Как (в какой степени) он знает английский язык? 14. Пообедаем? —

Давай! 15. Кто видел этот фильм? 16. Никто еще не видел. 17. Поезд пришел в 3 часа, а в 4 часа мы отправили ему телеграмму. 18. Разрешите познакомить Вас с моим другом. 19. Разрешите Вас поздравить. 20. Разрешите сказать несколько слов. 21. Он пришел и сейчас пишет письмо. 22. Можно открыть форточку? 23. Нет, нельзя. На улице очень холодно. 24. До свидания! Пишите нам! 25. Мы кушали, а она смотрела телевизор. 26. Мы сидели дома, а он в библиотеке. 27. Мы читаем текст, а он смотрит в окно. 28. Сейчас она делает уроки. 29. Пообедав, мы пошли гулять. 30. За десять рублей ты не сможешь купить хорошие духи. 31. За три тугрика вы сможете купить две буханки хлеба. 32. Вы можете переводить с русского на монгольский язык? — Конечно, можем. 33. Я не могу перевести это предложение. 34. Можно взять твои часы? 35. Он не мог ответить на этот вопрос. 36. Можно мне прийти вечером? 37. Нельзя выходить зимой на улицу без теплой шапки. 38. Он встал? — Нет, еще не встал. Он вчера поздно лег. 39. Она поступила в ИСАА? — Нет, не поступила. 40. Ты не можешь его встретить? 41. Ты не пойдешь со мной в музей революции? 42. Какие музеи есть в вашем городе? 43. Она должна приехать десятого. 44. На сегодняшнем уроке мы будем читать новый диалог и переводить эти предложения.

Упражнение 4. Переведите из монгольского язык:

1. Где остановка автобуса, который едет до аэропорта? 2. Где находится тот ресторан, в котором мы вчера ужинали? 3. Журнал который сегодня читали, я отдал Доржу. 4. Выучите слова, которые сегодня записали. 5. Я это купил в магазине, который находится рядом с Красной площадью. 6. Что ты сказал человеку, который встретил тебя на вокзале? 7. Как зовут того мужчину, который приносит нам газеты и журналы? 8. Кто эта девушка, которая живёт в нашем этаже? 9. Ты знаешь тех двух женщин, которые были на кафедре? 10. Где книга, которую купили вчера? 11. Кто еще не купил этот словарь-пойдите в книжный магазин № 2. 12. Тот, кто смотрит телевизор каждый день, должен хорошо знать этого диктора. 13. Ученик, который написал это, сегодня отсутствует. 14. Врач, который пришел нам, мне не знаком. 15. Те, кто будет выступать, приходите 6 часов. 16. Те, кто пойдет в театр, принесите завтра деньги. 17. Тот, кто еще не выучил слова, не сможет перевести от текст. 18. Человека, который там сидит, я не знаю. 19. Кто хорошо выучил слова-тот получит «пять». 20. Там онт учитель, который преподает французский язык. 21. Ученик, окончивший школу, получает аттестат. 22. Студент, окончивший ВУЗ, получает диплом. 23. Кто этот человек.

который сейчас выступает? 24. Студенты, которые оканчивают Институт стран Азии и Африки при МГУ, знают три иностранных языка. 25. Как зовут того мальчика, который хорошо рисует? 26. Как называется тот парк, в котором мы вчера гуляли?

Упражнение 5. Переведите на монгольский язык:

1. В котором часу кончаются ваши занятия? 2. Ты ведь сказал, что сейчас пойдешь в библиотеку! 3. Я ведь правильно перевел! 4. Вы поедете в аэропорт или нет? 5. Я должен ехать. 6. Мне пора ехать. 7. На уроках мы читаем тексты и диалоги, пишем слова и выражения, переводим предложения. 8. Говорят, ты получил «три». 9. Говорят, она разошлась с мужем. 10. Говорят, он уехал в худон. 11. Я не могу сказать, где он. 12. Он сказал, что от Доржа пришло письмо. 13. Мы не слышали, как он вышел. 14. Друг написал: «Приеду в пятницу. Встречай». 15. «Зачем ты взял эту книгу?»-спросил Няма. 16. «Я буду ждать вас около гостиницы», -сказала переводчица. 17. «У нас все хорошо», -писал брат. 18. «Я собираюсь поехать домой на праздники», — сказала она. 19. Бат написал, что приедет только в августе. 20. Я вспомнил, что забыл дома записную книжку. 21. Прошло три года с тех пор, как он приехал в Москву. 22. Восемь лет прошло с тех пор, как он женился. 23. Вот уже пять лет, как она работает на фабрике. 24. Вот уже два года, как они уехали в Монголию. 25. «Я собираюсь обедать», -ответил он. 26. «Мы собираемся осматривать город», — сказали они. 27. Она написала, что скоро приедет. 28. Ты ведь сказал, что ничего не видел! 29. Когда он собирался делать домашнее задание, к нему пришел Бат. 30. Когда я утром встал, он собирался завтракать. 31. Когда учитель вошел, мы собирались уходить. 32. Когда я уезжал в аэропорт, он собирался спать. 33. Когда он отправился в институт, я собирался пойти в исторический музей. 34. Когда я читал газету, он писал письмо. 35. Когда я ем, я не разговариваю. 36. Когда вы учите слова, пишите их! 37. Когда ты писал, мы переводили это стихотворение. 38. Когда мы вернулись домой, дети собирались спать. 39. Когда мы выходили из гостиницы, они садились в машину. 40. Цэрэн сказал, что собирается ехать на вокзал. 41. Когда они собирались гулять, пришел отец. 42. Ты не должен так думать. 43. Решено: мы едем. 44. Тебе пора знать это. 45. Нельзя так говорить. 46. Нужно немного отдохнуть.

Упражнение 6. Переведите на монгольский язык:

1. Монголы говорят: «Если начал-закончи, если ищешь-найди». 2. Самая высокая точка территории МНР находится

на высоте 4653 метров выше уровня океана. Это-гора «Найрамдал» Монгольского Алтая. Вы можете найти ее на географической карте, если хорошо поищите. 3. Самые низкие точки территории республики лежат на высоте 500 метров выше уровня моря (океана). Если вы хотите знать среднюю высоту страны над уровнем моря — я скажу вам. Средняя высота составляет 1580 метра. 4. В Монголии много (больших) рек и озер. В самом глубоком, прозрачном и холодном озере Хубсугул обитает множество ценных рыб. Если Вы любите ловить рыбу, Вам нужно поехать в Монголию. 5. В какой части вашего аймака находится это чистое, светлоголубое озеро? 6. Если вы поедете в южном направлении, вы найдете несколько речушек, которые впадают в это озеро. По пути вам встретится целебный источник. Мы хотим построить там лечебницу. 7 Монголы говорят: «Коня упустить — поймаешь, слово выпустить — не воротить» 8. МНР расположена в северной части Центральной Азии. Если вы посмотрите на географическую карту, вы увидите реки, пустыни, горы, хребты. 9. Если вы еще не читали книгу известного монгольского писателя Ч. Лодойдамбы «Прозрачный Тамир», на высоте 4653 метров выше уровня океана. Это-гора «Най-вы должны это сделать. 10. Если Вы нигде не нашли эту книгу, я принесу Вам свою. 11. «Если нет болезней-счастье, если нет долгов-богатство», -говорят монголы. 12. Вы знаете пословицу «У кого есть друзья — тот широк, как степь, у кого нет друзей-тот узок, как ладонь»?

Упражнение 7. Переведите на монгольский язык:

1. Как только приедешь — сразу отправь телеграмму. 2. Как только мы вышли из вагона, он подошел к нам. 3. Как только встанешь-сходи за газетами. 4. Как только вы приезжаете в Москву, вы сразу замечаете, что все москвичи куда-то торопятся. 5. Как только концерт кончился, все встали со своих мест и долго аплодировали. 6. Как только он встает с постели, он сначала просматривает утреннюю почту, а потом идет бриться и умываться. 7. Как только началась война, они эвакуировались. 8. Как только ансамбль вернулся на родину, была устроена пресс-конференция с участием иностранных журналистов. 9. Только они вышли из машины -к ним подошел молодой, среднего роста человек в очках. 10. Только мы вошли-зажегся свет. 11. Как только мы приезжаем на море, мы забываем обо всем на свете, целый день купаемся и загораем. 12. Так только я окончил институт, я уехал на родину. 13. Как только перестал идти дождь, мы пошли в кинотеатр за билетами. 14. Как только я поступил в институт, мы перестали встречаться часто. 5. Как только начнутся каникулы, мы отправим его

в деревню. 16. Как только освободишься-позвони мне, пожалуйста. 17. Только ты ушел — принесли телеграмму. 18. Только мы вышли из института-пошел пождь. 19. Как только туда приедем-сразу тебе сообщим. 20. Как только проснись-сразу разбуджу тебя. 21. Как только Нямбу вошел в воду, он поплыл, как рыба. 22. Как только получите зарплату -сразу же уплатите членские взносы. 23. Только она легла—сразу же уонула.

Упражнение 8. Переведите на монгольский язык:

1. До которого часа ты сидел в библиотеке? 2. До нашего отъезда осталось пять дней. 3. До поступления в институт он два года служил в армии. 4. До того, как пришел поезд, мы успели поужинать в привокзальном ресторане. 5. До начала войны он считался временно свободным от военной службы. 6. До появления очертаний корабля они сидели на берегу, не обращая внимания на бегущих людей. 7. «Пока не пообедаешь — не пойдем гулять», -сказала бабушка своему внуку. 8. Я буду сидеть здесь, пока ты не придёшь. 9. До того, как эксплуататорский класс взял власть в свои руки, рабочие долго оказывали вооруженное сопротивление. 10. До начала фильма можно осмотреть выставку. 11. «Пока не сделаешь уроки-никуда не пойдем», -сказал отец. 12. Этот автобус едет до аэропорта. 13. До его прихода ты все успеешь сделать. 14. С приходом учителя все встают со своих мест. 15. «Придёшь-увидимся», — сказал Бат. 16. Будешь уходить-скажешь! 17. Дачники разъехались с наступлением холодов. 18. С нашим приездом они прекратили работу и обступили машину. 19. С наступлением зимы мы катаемся на лыжах. 20. С восходом солнца отправимся втроём. 21. С наступлением ночи колонна грузовиков двинулась дальше. 22. По окончании работы встретимся в сквере. 23. Вслед за вами двинемся мы. 24. Наступит лето-отдохнем. 25. Учитель объяснит-поймешь. 26. Прочтешь телеграмму — узнаешь. 27. Вернешься-позвони! 28. После моего отъезда сходи к нему!

Упражнение 9. Переведите на монгольский язык:

1. Только войдёшь -(есть) справочное бюро. 2. Только спустишься -(есть) кноск. 3. Не успели приехать (только приехали)-нужно уезжать. 4. Как только я увидел их-сразу все понял. 5. Не успела она открыть дверь — раздался телефонный звонок. 6. Он всегда здоровается при встрече со мной. 7 Ты сказал-мы написали. 8 Пока (=когда) ехал в поезде-прочел все рассказы. 9. Пока ждал товарища -сделал этот рисунок. 10. Пока жил здесь -написал много стихов. 11. Пока с ним разговаривала-убежало молоко. 12. По

пути в город навести семью Лувсана! 13. По пути к вам я зайду на почту. 14. Хотя в это озеро впадает много речушек, вы не найдете их на географической карте. Они встретятся вам по дороге. 15. Хотя лечебницу еще не построили, газеты много о ней пишут. 16. Хотя совещание закончилось, главы делегаций остались в столице для участия в торжествах. 17. Хотя летчики пристально всматривались в местность, они не обнаружили людей. 18. Даже если они выйдут в 5 часов, они опоздают на поезд. 19. Хотя мы подружались, я ничего не спрашивал о его прошлом. 20. Хотя мы были вместе целый день, мы не хотели расходиться по домам. 21. Хотя чесучевое дели было новое, она не одела его. 22. Хотя дети должны были гулять в саду, они вошли в дом и увидели, что их мать разговаривает с хозяином. 23. Хотя я видел эту пьесу дважды, я пойду с вами в театр. 24. Хотя я ежедневно повторяю новые слова, я делаю ошибки. 25. Даже если мы встанем в 6 часов утра, мы не успеем прочесть четырехста страниц. 26. Хотя я знаю две тысячи слов, я плохо говорю по-монгольски. 27. Хотя мы живем в одном доме, мы редко встречаемся. 28. Хотя он приехал две недели назад, он позвонил им только сегодня.

ПРИМЕЧАНИЯ

Дополнительно смотрите:

1) С. Галсан, «Сопоставительная грамматика русского и монгольского языков», часть 1 (Фонетика и морфология),

Из-во Министерства Народного образования МНР, Улан-Батор, 1975, стр. 153.

- 2) там же, стр. 150—151;
- 3) там же, стр. 128—129;
- 4) там же, стр. 188;
- 5) там же, стр. 220—223;
- 6) там же, стр. 239—248;
- 7) там же, стр. 218—220;
- 8) там же, стр. 133;
- 9) там же, стр. 258—260;
- 10) там же, стр. 259—260;
- 11) там же, стр. 243—252;
- 12) там же, стр. 258—260;
- 13) там же, стр. 125—129.

